



ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрхийг хангах зарим асуудал
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал: Үндсэн хуулийн зохицуулалт ба өнөөгийн практик
- Хувьцаа эзэмшигч компанийн эрх ашгийг хамгаалах нэхэмжлэл гаргах боломж ба ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг хамгаалах эрх зүйн боломж
- Захиргааны эрх зүйн тусгай ангийн өнгөрсөн, одоо, ирээдүй: Эдийн засгийн захиргааны эрх зүй нь төрөлжсөн захиргааны эрх зүй болох нь
- Сонгуульд иргэд нийтээрээ оролцох зарчим ба хорих газар ял эдэлж байгаа хоригдлуудын сонгуулийн эрхийн асуудал
- Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам
- Үндсэн хууль бол хууль тогтоогчдод зориулсан хууль мөн
- Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёсон
- Олон улсын үйлчилгээний худалдааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал
- Гэрээнээс татгалзах болон гэрээ цуцлах тухай Иргэний хуулийн зохицуулалтыг шүүхийн практикт хэрэглэх асуудал

Ц.Нямдорж
Ц.Зориг
Д.Дорлигжав
Д.Одбаяр
Д.Лүндээжанцан
Ц.Мөнх-Оргил
С.Батдэлгэр
Ц.Шаравдорж

П.Цагаан
Б.Долгор
Ж.Бямбадорж
Г.Баясгалан
Б.Пүрэвням
Ч.Отгонбаяр
Д.Батжаргал
Ж.Амарсанаа

С.Нарангэрэл

Д.Сандаг-Очир
Д.Зүмбэрэлхам

- Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
- Улсын Ерөнхий прокурор
- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга
- Улсын Их Хурлын гишүүн
- Улсын Их Хурлын гишүүн
- Улсын Дээд шүүхийн шүүгч
- Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх
- Монгол Улсын Ерөнхий сайдын хуулийн зөвлөх
- Хүний эрхийн үндэсний комиссын дарга
- ХЭДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
- Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч
- Монголын Нотариатчдын Танхимын Ерөнхийлөгч
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
- Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал
- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга
- Цагдаагийн ерөнхий газрын дарга
- Төрийн албаны зөвлөлийн дарга

СЭТГҮҮЛИЙН ШИНЖЭЭЧ ЭРДЭМТДИЙН ЗӨВЛӨЛ

С.Жанцан
Ч.Энхбаатар
Ш.Чоймаа
Б.Амарсанаа
Б.Гүнбилэг
Б.Тэмүүлэн
Г.Банзрагч
Д.Баярсайхан
Т.Мэндсайхан

- Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)
- Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)
- Хэл шинжлэлийн шинжлэх ухааны доктор (Sc.D)
- Хууль зүйн доктор (LL.D)
- Хууль зүйн доктор (Ph.D)
- Хууль зүйн доктор (Ph.D)
- Хууль зүйн доктор (Ph.D)
- Хууль зүйн доктор (Ph.D)
- Хууль зүйн доктор (Ph.D)
- Хууль зүйн доктор (Ph.D)

ХЯНАН ТОХИОЛДУУЛАХ ЗӨВЛӨЛ

Хүндэт зөвлөх: Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор Б.Чимид
Ерөнхий эрхлэгч: Д.Батжаргал
Эрхлэгч: Б.Гүнбилэг
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: С.Алтантуяа

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай-7
Утас: 312513, 99083007
Факс: 315736
Вэб сайт: www.legalinstitute.mn
И-мэйл хаяг: altantuya.s@legalinstitute.mn
Улсын бүртгэлийн дугаар: 279

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргаж түс хүрээлэнгийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Жилд 6 удаа.

Хууль дээдлэх Ёс

Цуврал 36 2012 он, Хоёрдугаар сар №1



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

АГУУЛГА

ХУУДАС

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ, АРГА ЗҮЙ

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрхийг
хангах зарим асуудал 5

*ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
тэргүүлэх ажилтан,*

*хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор
С.Жанцан*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал:
Үндсэн хуулийн зохицуулалт ба өнөөгийн практик 18

*Удирдлагын академийн Захиргааны сургуулийн
Захирал,*

*хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор
Ч.Энхбаатар*

Хувьцаа эзэмшигч компанийн эрх ашгийг хамгаалан
нэхэмжлэл гаргах боломж ба ТУЗ болон гүйцэтгэх
удирдлагыг хамгаалах эрх зүйн боломж 32

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор,
хууль зүйн доктор (LL.D)*

Б.Амарсанаа

Захиргааны эрх зүйн тусгай ангийн өнгөрсөн, одоо, ирээдүй:
Эдийн засгийн захиргааны эрх зүй нь төрөлжсөн захиргааны
эрх зүй болох нь 37

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор,
хууль зүйн доктор (Ph.D)*

Г.Банзрагч

Сонгуульд иргэд нийтээрээ оролцох зарчим ба хорих газар ял эдэлж байгаа хоригдлуудын сонгуулийн эрхийн асуудал <i>Олгонгэнэгэр их сургуулийн багш, магистр (LLM)</i> <i>Р.Очирбал</i>	49
--	----

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам <i>Хууль зүйн чиглэсний хүрээлэнгийн судалгаа</i>	72
---	----

ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Үндсэн хууль бол хууль тогтоогчдод зориулсан хууль мөн <i>Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүй, хуурийн хэлтсийн ахлах зөвлөх, докторант</i> <i>А.Өлзийсайхан</i>	110
--	-----

Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёсон <i>Өвөрхангай аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч, магистр (LLM)</i> <i>Б.Сугар</i>	122
--	-----

Олон улсын үйлчилгээний худалдааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал <i>ХЗҮХ-ийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр (LLM)</i> <i>Б.Оюунбилэг</i>	129
--	-----

Гэрээнээс татгалзах болон гэрээ цуцлах тухай Иргэний хуулийн зохицуулалтыг шүүхийн практикт хэрэглэх асуудал <i>Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч, докторант</i> <i>А.Банзрагч</i>	141
---	-----

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ	146
-----------------	-----

CONTENTS

PAGE

ARTICLES

- Some Issues on Maintaining Human Rights in Criminal Procedure** 5
Jantsan.S, Sc.D
Priority Scientist of Research Institute,
University of Internal Affairs
- Legal Status of the President of Mongolia: Constitutional Rules and its Current Practice** 18
Enkhbaatar.Ch, Sc.D
Dean of School of Administration,
Government Agency of Mongolia
- Derivative Suits and Legal Opportunities to Defend Directors and Officers** 32
Amarsanaa.B, LL.D
Professor of School of Law,
National University of Mongolia
- Past, Present and Future of Special Part of Administrative Law: Economic Administrative Law Can Be a Part of Administrative Law** 37
Banzragch.G, Ph.D
Professor of School of Law,
National University of Mongolia
- Universal Suffrage and Voting Right for Prisoners** 49
Ochirbal, LL.M
Lecturer of School of Law,
Otgontenger University

RESEARCH REPORT

- The Implementation and the Difficulty of the Law on
Arbitration of Mongolia and Improving Its Legal Environment** 72
Research Report by National Legal Institute

NOTES

- The Constitution Is Dedicated to Legislators** 110
*Ulziisaikhan.L. Ph.D candidate,
Senior Consultant of Legal Department,
the Secretariat of the State Great Hural (Parliament)
of Mongolia*
- Respect of the Constitution of Mongolia** 122
*Sugar.B, LL.M
Judge of the Administrative Court of Uvurkhangaï Aimag*
- Some Issues on Legal Regulations of International Trade
of Services** 129
*Oyunbileg.B, LL.M
Researcher of Civil and Economic Law Sector,
National Legal Institute*
- Issues on Applying to Regulations Relating to Contract Refusal
and Annulment of a Contract of Civil Code of Mongolia in
Judicial Practice** 141
*Banzragch.L. Ph.D candidate,
Advocate,
Member of Association of Mongolian Advocates*

NEWS AND EVENTS 146

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрхийг хангах зарим асуудал

ДХИС-ийн Эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан,
хууль зүйн шинжлэх ухааны доктор
(Sc.D), профессор С.Жанцан



Монгол Улсын Ардчилсан Үндсэн хуулийн оршил хэсэгт: Монголын ард түмэн бид: "...хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлээ эрхэмлэн дээдэлж, ...эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно"¹ гэж тунхаглан зарласан билээ. Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байх учиртай.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд "хүн бүр ...эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй...хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь гутаан харьцах, шийтгэхийг хориглоно", Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 9 болон 17 дугаар зүйлд Хүний халдашгүй дархан байх эрхийг дэлгэрэнгүйгээр тогтоосон байдаг. Тухайлбал, Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх "улс оронд онцгой байдал тулгарч, улс үндэстэн оршин тогтноход аюул учирсан үед ч зөрчигдөх ёсгүй"² гэж онцлон заасан нь чухал ач холбогдолтой юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 3452 дугаар тогтоолоор "Бүх этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай" тунхаглал гаргасан ба энэ тунхаглалын зорилгыг бодитой хангахын тулд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984

¹ Монгол Улсын Үндсэн хууль У6: 2005 он, 1 дэх тал.

² Хүний эрх: олон улсын гэрээ, хэлэлцээрцэдийн эмхтгэл У6: НҮБ, 1990 он, 3 дахь тал.

оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцүгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци”-г албан ёсоор батлан гаргасан. Манай улс 2000 онд энэ конвенцид нэгдэн орсноор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мөрдөх болсон юм.

Нэрд гарсан соён гэгээрүүлэгчид, сэтгэгчид, гүн ухаантнууд хүн, түүний эрхийн асуудалд онцгой анхаарч байснаас Германы гүн ухаантан И.Кант “...иргэний нийгэм нь угтаа агуу их эрх чөлөө юм. Эрх чөлөөний эрх зүйн үндэс нь хүний эрх, эрх чөлөө юм. Энэ эрх, эрх чөлөө халдашгүй ариун байх ёстой”³ гэж сургасан.

Профессор Г.Совд “хүн бүр халдашгүй чөлөөтэй байх нь хүний угаас заяасан хувийн эрх...энэ эрх бол хүн бүрд Үндсэн хуулиар баталгаажуулсан хөндлөнгийн хэн боловч дур мэдэн халдаж болохгүй туйлын эрх...”⁴ гэж түүний эрх зүйн агуулгыг оновчтой тодорхойлжээ. Аливаа ардчилсан төр иргэдийнхээ өмнө тэдгээрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг сахиулах, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох үүргийг хуулиар хүлээсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрхийг тунхаглаад зогсохгүй мөн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”⁵ гэж төрийн чиг үүргийг тодорхойлов.

Үндсэн хуульдаа хүний эрхийг баталгаатай хангах, халдашгүй эрхийг сэргээхийг төрийн чиг үүрэг болгон анх удаа ингэж хуульчилсан нь Монголын захиран тушаах дэглэм бүхий (тоталитар) төрийн үйл ажиллагаанд хүний эрхийг бүдүүлгээр зөрчин, хуулийн хүрээнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар, өөрөөр хэлбэл шүүхийн оролцоогүй олон иргэдийг хэлмэгдүүлсэн хар түүхийг давтахаас урьдчилан сэргийлэх зорилготой гэж үзэж байна.

Хэлмэгдүүлэлттэй холбоотой түүхэн баримтыг иш үндэс болгоход 1930-аад оны сүүл 1940 оны эхэн үед манайд өрнөсөн их хэлмэгдүүлэлтийн үр дүнд гэм буруутгүй нийт 31 мянга 742 хүн хэлмэгдсэн бөгөөд тэдгээрийн 2062 хүн буудан алах, 11446 хүн хорих болон нутаг зааж суулгах (цөлөх) ялаар шийтгэгдсэн байдаг.⁶

1937 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн УБХ-ын тэргүүлэгчид,

³ Луидежикян,Д. Жалбыжав,Н. Эрх зүйн философи УБ: 1998 он, 137-142 дахь тал.

⁴ Совд,Г. Монгол Улсын Үндсэн хууль. Хүний эрх УБ: 1999 он, 50-51 дэх тал.

⁵ Монгол Улсын Үндсэн хууль УБ: 2005 он, 10 дахь тал.

⁶ ТЭГ-ийн тусгай архив Ф-МБ, ХН-ОБЭК №16, 220 дахь тал.

АСНЗ, Ерөнхий сайд, мөн Ерөнхий сайдын 1 дүгээр орлогч сайд нарын хавсарсан хуралдаанаас "...эх орноосоо урвах болон онц аюултай зарим гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хэргийг таслах онцгой бүрэн эрхтэй комисс байгуулж даргаар нь Х.Чойбалсан, гишүүнээр Лувсаншарав, Цэрэндорж нарыг томилж улмаар шүүхээс өөр байгууллага шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх онцгой эрхийг эдлэх болсон нь дээд зэргийн завхрал, хүний эрхийн зөрчлийн бүдүүлэг эхлэл тавигдсан юм. Мөрдөн байцаах, шүүн таслах эрх бүхий онцгой бүрэн эрхт комисс 1937 оны 10 дугаар сараас 1939 оны 4 дүгээр сарын 4-22-нд татан буугдах хүртлээ 51 удаа хуралдаж 27785 улс төрийн хэрэгтний хэргийг авч хэлэлцэж 20099 хүнийг буудан алах, 5739 хүнийг хорих ялаар шийтгэжээ. Зөвхөн нэг удаагийн хурлаар 1278 хүнийг бөөнөөр нь (нэрсийн жагсаалтаар) хэлэлцэн бараг бүгдэд нь буудан хороох ял оногдуулсан байдаг.⁷

1942 оны 2 дугаар сарын 24-нд МАХН-ын төв хорооны тэргүүлэгчдийн онц хурлаас гаргасан тогтоолд "... дайсан этгээд нарыг эрхтэнд нь гэмтээлгүйгээр зодох ба занчиж болох эрх, зөвшөөрлийг Дотоод Явдлын Яамны сайд нөхөр Шагдаржавын өөрийн хариуцлагад хатуу даалган өгсүгэй гээд энэхүү аргыг зөвхөн төвд хэрэглэхийг зөвшөөрсүгэй" гэж заасныг хэрэгжүүлэн хүмүүсийг зодох, занчих, өөрөөр хэлбэл эрүүдэн шүүлт тулгах аргаар хэргийг өөрөөр нь хүлээлгэж байсан нь Зөвлөлтийн эрдэмтэн Вышинскийн "хэргээ хүлээж мэдүүлэх нь хамгийн дээд зэргийн нотолгоо (нотолгооны хаан) мөн" гэсэн бүдүүлэг онол манайд биелэлээ олж байсны бодит илрэл юм.

Гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай эсэхийг нотлох зорилгоор Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг удирдлага болгон төр, түүнийг төлөөлсөн байгууллага, албан тушаалтан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үед зайлшгүй хүний халдашгүй болон бусад эрх хөндөгдөх, хязгаарлагдах эрх зүйн үндэслэл бий болдог. Академич Ж.Амарсанаа "хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад гол зүйл бол хязгаарлалтыг хортойгоор ашиглах явдлыг гаргуулахгүй байх асуудал чухал юм"⁸. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах зорилтыг хэрэгжүүлж буй байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект болох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх зайлшгүй хөндөгдөх болдог. Эрх зүйн

⁷ Бадарх, М. нэгдэл хийл амарлан, буюу тийл үзгич/ Тусгаар тогтнол сонин 1990 он, №100.

⁸ Амарсанаа, Ж. Хүний эрх: улс улсын ба үндэсний эрх зүйн асуудал УБ: 2000 он, 127 дэх тал.

онолын үүднээс хүний эрх нь ямар ч тохиолдолд хэмжээ хязгааргүй дур зорго биш юм. Монгол Улсын олон улсын гэрээ, конвенци болон үндэсний эрх зүйн хэм хэмжээнд аливаа хүний эрх, эрх чөлөө бусдын эдлэх эрхээр хязгаарлагдах нийтлэг жишиг шаардагддаг жамтай. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2-т "хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг хууль зүйн дагуу зөвшөөрөн, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад захирагдана", Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй бөгөөд"¹⁰ гэж заасан. Гэмт хэрэг үйлдэх замаар бусад хүний эрх, эрх чөлөөнд халдаж, хохирол учруулж байгаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэхийг шалгах ажиллагааны үед эрхийг хөндөх хангалттай үндэслэл болох ёстой. Хүний халдашгүй эрхийн хязгаарлалт нь Үндсэн хуулийн түвшинд, хязгаарлалтын хязгаарлалт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд тус тус тодорхойлогдоно.¹¹ Иймд хүний халдашгүй эрхийг хамгийн товчоор хүний хүсэл зоригийн хуульчлагдсан илэрхийлэл болохын хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд онцгойлон авч үзэх шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн заалтын агуулгаас үзвэл хүний халдашгүй эрх гэж өөрийнх нь төрөлх, жам ёсны хэрэгцээнээс үүдэлтэй мөн чанарын хувьд төрөөс тогтоосон болон зөвшөөрсөн бөгөөд эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажин хамгаалагдсан ямар ч тохиолдолд хөндлөнгийн хэн боловч хөндөж, хязгаарлаж хэрхэвч болохгүй хэд хэдэн туйлын эрхийн цогц ойлголт юм. Хүний халдашгүй эрх хэмээх цогц ойлголтыг:

- а. чөлөөтэй байх эрх;
- б. бие эрхтний халдашгүй эрх;
- в. орон байрны халдашгүй эрх;
- г. хувийн нууцын халдашгүй эрх;
- д. нэр төр, алдар хүндийн халдашгүй эрх;
- е. өмчийн халдашгүй эрх гэсэн эрхийн төрлүүд бүрдүүлдэг.

Халдашгүй эрх нь хүний эрхийн гол зангилаа асуудал болохын хамт хувийн эрхийн цом юм.

¹⁰ Хүний эрх: олон улсын гэрээ эзлэх зэрэгцлийн эмхэтгэл УБ: НҮБ, 1992 он, 8 дахь тал.

¹¹ Монгол Улсын Үндсэн хууль УБ: 1992 он, II, 8 дахь тал.

¹² Эрдэнэбат. Х. Хүний халдашгүй эрх УБ: 2002 он, 38 дахь тал.

А. Чөлөөтэй байх халдашгүй эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиглагаа

Хүний эрхийн түтээмэл тунхаглалын 3 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 19 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт харьцангуй бие даасан байдлаар тусгагджээ. Хүн чөлөөтэй байх гэсэн оюунлаг амьтан болохынхоо хувьд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол болон ардчилсан нийгэмд байдаг дэг журмыг зөрчихгүй, ямар ч дарамт, шахалт, хязгаарлалтгүйгээр өөрийнхөөрөө эрхээ эдэлж оршихыг хэлнэ. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хуульд заасан үндэслэлээр чөлөөтэй байх эрх хязгаарлагдана. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлд зааснаар сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол баривчилж болно. Мөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болох бусад эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болох үндэслэлтэй бол:

а. Оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах;

б. Цагдан хорих зэрэг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 64, 68 дугаар зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэж, эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 129 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хүний биед үзлэг, 135 дугаар зүйлд зааснаар нэгжлэг хийж байгаа нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг шууд хөндөхөд хүргэдэг. Хуульд заасан үндэслэл журмаас гадна хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг хязгаарлах, эх орноос нь хөөн гаргахыг хориглоно. Баривчлах нь чөлөөтэй халдашгүй байх эрхийг хамгийн ноцтой хязгаарладаг.

Баривчлах гэдэг нь хүнийг зохих дэглэм бүхий байранд хуульд заасан хугацаа, үндэслэл журмын дагуу албадан байлгах (хорих) гэсэн утгатай үйл ажиллагаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үүднээс баривчлах нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдсэн байж болох сэжигтэй этгээдийн чөлөөтэй байх халдашгүй эрх хязгаарлагдаж цагдаагийн ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хяналтад орсон үеэс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчээс тодорхой шийдвэр гаргах хүртэл түр хугацаагаар түүнийг эрх мэдэлгүй болгож байгаа төрийн албадагын арга хэмжээ юм. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын байгууллагын үйл ажиллагаанд хүний халдашгүй чөлөөтэй байх эрх ноцтой зөрчигдөх явдал арилахгүй байна. Хүний эрхийн үндэсний комиссоос нийслэлийн

хэмжээнд 2001, 2002 оны эхний улиралд хэрэгсэхгүй болгосон хэрэг хийсэн судалгааг дүгнэж үзэхэд "нийт 1873 хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд үүнд 2403 хүнийг холбогдуулан шалгаснаас тэдгээрийн 571 хүнийг 5-487 хоног цагдан хорьсон байна". Ганц худаг, бусад 7 аймагт Хүний эрхийн үндэсний комиссоос хийсэн судалгаагаар тэнд хоригдож байсан 1338 хүний 17,1 хувь нь 6 сараас 1 жилийн хугацаагаар 109 нь бусад 8,1 хувь нь 1-2 жилийн хугацаагаар 17 хүн бусад 1,2 хувь нь 2 жилээс дээш хугацаагаар хоригдсон байна.¹²

Б. Бие эрхтний халдашгүй эрх ба эрцүгийн байцаан шийтгэх ажиллагаа

Бие махбодь, эрхтний халдашгүй эрх нь Олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор хамгаалагдсан байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд "хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий ... харьцах шийтгэхийг хориглоно". Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "хүн бүр амьд явах эрхтэй..." мөн зүйлийн 13 дахь хэсэгт "...хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бүс хэрцгий хандаж болохгүй..." гэж заасан. Энэ эрхийн агуулга нь:

- а. Хүн бие махбодийн хувьд бусад этгээдийн хүчирхийлэл, зовиур, шаналгаа, дарамтаас ангид байх;
- б. Хүний бие махбодь нь анатомийн бүтцээрээ бүрэн бүтэн байх;
- в. Хүний бие эрхтнээс түүний зөвшөөрөлгүй дээж авахгүй, туршилт хийхгүй, мөн бие дээр нь элдэв зураг, шивээс, тэмдэг тавихгүй байх;
- г. Эд эрхтэн нь хэвийн ажиллагаатай байх ээргээр илэрнэ.

Бие эрхтний халдашгүй эрхийг хамгийн ноцтойгоор хөнддөг нэлээд түгээмэл байдаг хууль бус үйлдэл бол эрүүдэн шүүлт юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци"-г батлан гаргасан ба манай улс 2000 оны 11 дүгээр сарын 2-нд энэ конвенцид нэгдэн орсоноор үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэгжих болсон. Энэ конвенцийн заалт ёсоор төрийн албан тушаалтан буюу албан үүргээ гүйцэтгэж байгаа этгээд, түүний хатгалгаар бусад илээр, далдуур зөвшөөрснөөр аливаа нэг хүнийг түүнээс бусад гуравдагч этгээдээс үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа хүний талаар мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, шийтгэхийн тулд түүнчлэн түүнийг бусад гуравдагч

¹² Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний тулалд үзүүлэх УБ: 2002 он, 24 дэх тал.

этгээднийг аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар айлгах, албадах, санаатайгаар, хүчтэйгээр өвтгөх, бие махбодь, сэтгэл санааны хувьд тарчлаан зовоох аливаа үйлдлийг ойлгох бөгөөд хуулийн цээрлэл, тохиолдлоор үүссэн өвдөлт, шаналгаа, хамаарахгүй.¹³

Эрүүдэн шүүлт нь зөвхөн бие махбодийг өвтгөхөөр хязгаарлагдахгүй бөгөөд өвтгөх, шаналгах нь олон удаа давтагдсан, тарчлаах шинжтэй байдаг. Эрүүдэн шүүхийн хэргийг хандах гэдэгт:

- а. Хилсээр хэрэг хүлээлгэх;
- б. Албадан мэдүүлэг авах;
- в. Эрүүдэн шүүхээр заналхийлэх;
- г. Тохуурхан даажигнах;
- д. Доромжлох;
- е. Зодох, бие махбодид нь ямар нэгэн төрлийн гэмтэл санаатай учруулах;
- ё. Тарчлаан зовоох зэрэг үйлдэл хамаарна.

Хүнлэг бус эрүү шүүлт нь:

- а. Догшин хэргийг харьцах;
- б. Төрөл садан, ойр дотны хүмүүсээс эргэлт, уулзалт авах эрхийг хязгаарлах, хасах;
- в. Зохистой хоол ундаар хангагдах эрхийг хязгаарлах;
- г. Хоригдогсдын салхилах эрхийг хаах;
- д. Хүнлэг бус нөхцөлд хорьж цагдах хэлбэрээр хэрэгжинэ.

Хүний эрхийн үндэсний комиссоос “Эрүүдэн шүүхийг хориглох нь” сэдэвт нээлттэй хяналт, шалгалт, судалгаа явуулсан. Энэ судалгаанд хамрагдсан сэжигтэн, яллагдагч 1338 хүний 39,9 хувь нь дарамталж, айлган сүрдүүлж хэрэг хүлээлгэдэг, 32,0 хувь нь зодож, хүч хэрэглэж хэрэг хүлээлгэдэг гэж хариулсан нь тохиолдлын зүйл биш юм.

1999 оны 1 дүгээр сард Баянзүрх дүүргийн хүнсний захын манаачийг алж алт, мөнгөн эдлэл дээрэмдсэн хэрэгт хилсээр холбогдон мөрдөгдөж байхдаа эрүү шүүлтэд өртсөн “О” 1115 хоног, “О” 315 хоног, “Х” 201 хоног, “Б” 1252 хоног тус тус цагдан хоригдсон. Тэд Хүний эрхийн үндэсний комисст гаргасан өргөдөлдөө “Биднийг хилс хэрэгт холбогдуулан баривчилж, ганц худгийн подвальный 7-9 камер дамжуулан хорьж, шинэ камер болгонд ороход тэнд хоригдож байсан хүмүүс “алуурчид хийсэн хэргээ хүлээ, нуусан алт, мөнгөө гаргаж өг” гэж шаардаж, бакал гутал болон наарны 5см-ын банзаар биеийн бүхий л газраар цохиж, зодуулаад хөдлөж чадахгүй болоход шалан дээр ус асгаж байгаад нүцгэлж хэвтүүлэн

¹³ Шүүх эрх мэдлийн салбар зах зүйн эрх зүйлсийн Уб: 1996 он, 60 дэх тал.

Оюунчимэг, П. Эрүүгийн шүүлттэй тэнцээ чиглэн асрилал: онол практик сэдвт докторын диссертаци Уб: 2009 он, 27-29 дэх тал.

агсасан усандаа тог хүргэн цохиулж, гялгар уут болон сойзны иш түлж хайлуулан биеэн дээр дусаах, наах, нойр хоолгүй хонуулах зэрэг аймшигт тамлаагыг амсаж эцэст нь сүрьеэ өвчин тусч хохирсон гэж бичсэн байна. Энэ хэрэгт холбогдон мөрдөгдөж байхдаа “Д” нас баржээ.¹⁴

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарын эрх зөрчигдөх, цаашилбал эрүүдэн шүүгдэх нь хавтгайрсан учир Хүний эрхийн үндэсний комиссийн илтгэлийг Улсын Их Хурал тусгайлан хэлэлцсэн билээ.

В. Орон байрны халдашгүй дархан эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 17 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт орон байрны халдашгүй эрхийг заасан. Иргэдийн орон байрны халдашгүй байдлыг зөрчих нь эрүүгийн хуулийн 137 дугаар зүйлд заасан гэмт хэрэг юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 11 дүгээр зүйлд “Иргэний орон байр нь халдашгүй байна. Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэн ч иргэний орон байранд оршин суугчийн зөвшөөрөлгүй нэвтрэн орох эрхгүй. Орон байранд хийх нэгжлэгийг прокурорын зөвшөөрлөөр энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэнэ” гэж заасан. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 132 дугаар зүйлд заасан:

- Хэрэг шийдвэрлэх ач холбогдолтой зүйл, баримт бичиг байна гэх хангалттай үндэслэл байвал түүнийг эзэмшигчээс хураан авах;

- Эрэн сурвалжилж буй этгээд нуугдаж байгаа бусад гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зөвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан эд зүйл, түүнчлэн хэрэг шийдвэрлэхэд ач холбогдолтой бусад зүйл байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг олж илрүүлэх гэсэн хоёр зорилгоор прокурорын зөвшөөрлөөр иргэдийн орон байранд нэвтрэн орох эрхтэй.

Г. Хувь хүний нууцын халдашгүй эрх ба Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа

Хувь хүний нууцын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Хувь хүний нууц гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн

¹⁴ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тулалд шийтгэл №6: 2006 он, 13-15 дахь тал.

хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд нэлээд хохирол учруулж болозошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлсийг хэлнэ” гэж тодорхойлсон. Хувь хүний нууц нь:

а. Захидал харилцааны нууц;

б. Эрүүл мэндийн нууц;

в. Эд хөрөнгийн нууц;

г. Гэр бүлийн нууц;

Д. Хуулиар тогтоосон бусад нууц гэсэн төрөлтэй байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 12 дугаар зүйлд “Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууцыг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно” гэж заасан. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 136 дугаар зүйлд “Шуудан цахилгаанаар явуулсан зүйлийг шуудан цахилгаан харилцааны байгууллагад байх үед нь битүүмжлэх, хураан авах, түүнд үзлэг хийхийг прокурорын зөвшөөрлөөр хөндлөнгийн гэрч байгуулан явуулна гэж” заасан.

Эрүүгийн хуулийн 135 дугаар зүйлд “Иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 136 дугаар зүйлд заасан хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг мэдсэн этгээд задруулсан бол тус тус гэмт хэрэг болж эрүүгийн хариуцлага хүлээнэ. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үүднээс хүний нууцтай байх эрх нь эрүүгийн хэрэгт ач холбогдолгүй бол ямар ч тохиолдолд Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдоос бусдад задруулж болохгүй туйлын эрх юм.

Д. Нэр төр, алдар хүндийн халдашгүй эрх ба эрцүгийн байцаан шийтгэх ажиллагаа

Энэхүү эрх нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нэгэнт тусгагдан хэрэгжиж ирсэн. Тухайлбал, “Хүүхдийн эрхийн тухай” конвенцийн 16 дугаар зүйлд “хэн ч хүүхдийн ... нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй” гэж заажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “хэнд боловч...хүнлэг бус хэрцүгий хандаж нэр төрийг гутаан доромжилж болохгүй”, эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлд “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус хэрцүгий хандах, нэр төр, алдар хүндийг гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй”, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцүгий хандаж нэр төрийг нь доромжилж болохгүй” гэсэн хэд хэдэн эрхийн хамгаалалт тогтоожээ. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн

үүднээс хүний нэр төрийн халдашгүй эрх гэдэг нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, иргэний хариуцагч, нэхэмжлэгч, хохирогч зэрэг эрх ашиг нь хөндөгдөж буй оролцогчид түүнчлэн төрийн нэрийн өмнөөс Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъектууд болох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчдийн нэр төр, алдар хүндэд халдашгүй байх ёстой. Ялангуяа гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох нь шүүхээр тогтоогдоогүй байхад яллагдагч, шүүгдэгчийг гэм буруутай мэт үзэх зэргээр нэр төр, алдар хүндэд халдаж болохгүй. Эрүүгийн хуулийн 259 дүгээр зүйлд зааснаар хэргийг хянан хэлэлцэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай холбогдуулан шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Е. Өмчийн халдашгүй эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа

Энэхүү эрх нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжид бүрэн тусгагдсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "хөдлөх, үд хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө" гэж өмчийн халдашгүй эрхийг зөвшөөрсөн. Өмчийн халдашгүй эрх гэдэг нь аливаа хүний шударгаар өмчилж байгаа эд хөрөнгөд хэн ч дураар халдаж өмчлөлөөс нь эд хөрөнгийг хууль бусаар салгаж болохгүй туйлын эрх юм. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад зөвхөн иргэний нэхэмжлэлийг хангах, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эд хөрөнгө, мөн түүнчлэн эрүүгийн хэрэгт нотлох баримтын ач холбогдолтой зүйлсийг эрх бүхий этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу эзэмшигч, өмчлөгчөөс гаргуулан авахаас (хураан авах) бусад тохиолдолд өмчлөх эрх халдашгүй юм. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 188 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн эзэнгүй үлдсэн эд хөрөнгө, орон сууцыг хамгаалуулах арга хэмжээ авах үүрэгтэй байгаа нь өмчлөх эрхийн чухал баталгаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 188 дугаар зүйлд зааснаар "Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх,

сэтгэл санааны үр дагавраа арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ сэргээлгэх эрхтэй", Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлд "Иргэнийг хууль бусаар ял шийтгэн баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлган албадан эмчлүүлэх арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм буруут үл харгалзан төр хариуцан арилгана" гэж заагаад нөхөн төлөх үйл ажиллагааны үндэслэл, эд хөрөнгийн хохирлын төрөл, сэтгэл санааны үр дагаврыг арилгах тухай эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 390-393 дугаар зүйлүүдэд тус тус хуульчилсан байдаг.

Ё. Өмгөөлөгчлэх, хууль зүйн туслагцаа авах эрх ба Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн тусламцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах" эрхтэй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35, 36 дугаар зүйлд сэжигтэн, яллагдагч нь өөрийгөө өмгөөлөх, энэ хуулийн 39 дүгээр зүйлд зааснаар өмгөөлөгчөө өөрөө сонгон авах, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрх эдэлнэ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172 дугаар зүйлийн 172.3-т заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулаагүй бол гэмт хэрэгт сэжигтнээр тооцсон үеээс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлд заасан хүмүүсийн хэрэгт өмгөөлөгч заавал оролцоно. Өмгөөлөгчөө сонгон аваагүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний халдашгүй эрхийг хангахад ач холбогдол бүхий эрх зүйн баталгаануудыг Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад суулгаж өгсөн байдаг. Тухайлбал:

- а. Хуулиар тогтоосон үндэслэл, журмаас гадуур сэжигтнээр тооцож, яллагдагчаар татаж ял шийтгэхгүй байх;
- б. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нийцсэн байх;
- в. Шүүх эрх мэдлийг зөвхөн шүүх хэрэгжүүлэх;
- г. Хүний халдашгүй байх эрхийг хангах;
- д. Иргэний орон байр, захидал харилцаа халдашгүй байх, иргэний хувийн болон гэр бүлийн нууцыг хамгаалах;
- е. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийг өмгөөлүүлэх эрхээр хангах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчим болон

хуульчлагдсан. Онцолбол, хүний халдашгүй байх эрхийг хангах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тулгуур зарчим бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10 дугаар зүйлд:

1. хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч гэмт хэрэгт сэрдэн баривчлах;
2. прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч шинжилгээ хийлгэхээр эмнэлгийн байгууллагад байлгах;
3. шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч хорих;
4. хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэргийг

хандаж нэр төрийг нь гутаан доромжлох зэрэг хууль бус үйл ажиллагааг шууд хориглосон байдаг. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 20 дугаар зүйлд зааснаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйл ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах нийтлэг эрхийн хүрээнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан мэдүүлэг өгөхөөс татгалзах, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө өөрөө сонгон авах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэгт холбогдолгүйгээ нотлох үүрэг хүлээхгүй байх зэрэг сэжигтэн, яллагдагчийн эрхийг эдлүүлэх нь халдашгүй эрхийн чухал баталгаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн халдашгүй байдлыг алдагдуулааг зарим хууль бус ажиллагаа явуулахыг хуулиар шууд хориглосон байдаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 92 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "нотлох баримт цуглуулахдаа иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсхүл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус хэргийг харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно", мөн хуулийн 186 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахдаа хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх болон бусад хууль бус арга хэрэгсэл хэрэглэх, оролцогчийн амь насанд аюултай байдал бий болгохыг хориглоно"¹⁵ гэж тус тус хуульчилсан. Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулж "Илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцсон, яллагдагчаар татсан, ял шийтгэсэн" (Эрүүгийн хуулийн 248 дугаар зүйл), "Хүнийг хууль бусаар баривчилсан" (Эрүүгийн хуулийн 249 дүгээр зүйл), "Шүүхээс хууль бус шийдвэр гаргасан" (Эрүүгийн хуулийн 250 дугаар зүйл), "Эрүү шүүлт тулгах" (Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл), "Нотлох баримт хуурамчаар бүрдүүлсэн" (Эрүүгийн хуулийн 253 дугаар зүйл), "Гэрч хохирогчоор худал мэдүүлэг өгүүлсэн,

¹⁵ Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль УБ: 2007 он, 103, 127 дэх тал.

шинжээчээр худал дүгнэлт гаргуулсан, орчуулагчаар худал орчуулуулсан, худал хэлмэрчлүүлсэн” (Эрүүгийн хуулийн 256 дугаар зүйл) бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч холбогдох бусад хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа нь хүний халдашгүй эрхийн чухал баталгаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхийг хангах үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход шаардлагатай зарим санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх хэрхэн хөндөгдөж байгаад Хүний эрхийн үндэсний комисс, Улсын Ерөнхий прокурорын газар, хүний эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын хамтарсан шалгалт явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэх;

2. Нэгдэн орсон “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийн, хүнлэг бусаар хүний нэр төрний доромжлон харьцах, шийтгэхийг хориглох тухай конвенцийн заалтуудыг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх;

3. Эрүү шүүхтийг арилгах түүнтэй тэмцэх ажлын арга барил эзэмшүүлэх зорилгоор их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан “Хүний эрх-2” хичээлийг бие даасан сэдэв болгон зааж сурталчлах;

4. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан, прокурорын хяналт тавьж ялах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн хэргийн холбогдогч (яллагдагч, шүүгдэгч) шүүхийн шийдвэрээр гэм буруутгүй болох нь нотлогдож цагаатгагдсан тохиолдолд илт хууль бус үйл ажиллагаа явуулсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийг Эрүүгийн хуулийн 248, 249, 250, 251 дүгээр зүйлд заасан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж байх.

○○○○○○

○○○○○○

○○○○○○

Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал: Үндсэн хуулийн зохицуулалт ба өнөөгийн практик



Удирдлагын академийн
Захиргааны сургуулийн захирал,
хууль зүйн шинжлэх ухааны доктор
(Sc.D), профессор Ч.Энхбаатар

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ: МӨН ЧАНАР,
ОНЦЛОГ, ТӨРИЙН ТОГТОМЦООНД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Төрийн тэргүүний институт нь гүйцэтгэх засаглалын механизмын үлэмж чухал хэсэг юм. Төрийн тэргүүний эрх зүйн байдал удирдлагын хэлбэрээс шалтгаалж харилцан адилгүй байдаг бөгөөд орчин үеийн улс төрийн практикт бүгд найрамдах улсад төр, засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх бүхий улс төрийн дээд албан тушаалтныг ерөнхийлөгч гэнэ.¹ Төрийн тэргүүн нь улс орноо улс төрийн дотоод амьдралд төдийгүй олон улсын тавцанд төлөөлөх бүрэн эрхтэй. Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал нь аль ч улсын төрийн удирдлагын хэлбэрийг тодорхойлдог бөгөөд ерөнхийлөгчөөс парламент, засгийн газартай харилцах харилцааны онцлог, мөн чанараас шалтгаалж тухайн улсыг ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс, парламентын бүгд найрамдах улс, эсхүл удирдлагын холимог хэлбэр бүхий бүгд найрамдах улс хэмээн ангилдаг. Төрийн удирдлагын эдгээр хэлбэрийн гол ялгаа нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн харилцаа, засгийн газрыг бүрдүүлж байгаа байдал буюу засгийн газрыг хэн толгойлж байгаа, бүр тодруулбал, ерөнхийлөгч нь зөвхөн төрийн тэргүүн, эсхүл нэгэн зэрэг төр, засгийн

¹ Praesidens гэсэн латин үгнээс гаралтай - өмнө суутч (эрт үед хурал даргалж буй хүнийг ингэж нэрлэж байжээ), (англи, герман, францаар president; оросоор президент) нь бүгд найрамдах засаглалтай улсын төрийн тэргүүн гэсэн утга санааг илэрхийлдэг байна.

тэргүүн байгаа эсэхээс ихээхэн шалтгаалдаг.

Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсад ерөнхийлөгч нь засгийн газрыг толгойлдоороо төрийн төдийгүй засгийн тэргүүн байх бөгөөд ийм хэлбэрийг сонгосон улсад ерөнхий сайдын албан тушаал байдаггүй. Ерөнхийлөгчийг импичментын журмаар улс төрийн хариуцлагад татах бүрэн эрхийг парламентад олгосон байдаг, харин ерөнхийлөгчийн хамгийн бодитой бүрэн эрх болох парламентыг тараах эрхийг төрийн тэргүүндээ олгоогүй нь хүчтэй ерөнхийлөгчийн эрх мэдлийг саармагжуулах, үүгээр төрийн тогтолцоог тэнцвэржүүлэх зорилгоор хийсэн ухаалаг алхам юм.

Үүний эсрэгээр парламентын бүгд найрамдах улсад парламент нь ерөнхийлөгчийг сонгох, ерөнхий сайдыг томилох, засгийн газрын бүрэлдэхүүнийг батлах зэрэг үлэмж өргөн эрх мэдэлтэй байдаг. Ийм улсад засгийн газар нь парламентад ажлаа хариуцан тайлагнах бөгөөд бэлгэдлийн цөөн бүрэн эрхтэй, сулхан ерөнхийлөгч нь улс төрд төдийлөн жин дардаггүй. Харин хүчтэй парламентаас төрийн бусад институтыг дарамтлах бололцоог хаахын тулд парламентыг тараах бүрэн эрхийг ерөнхийлөгчдөө олгосон нь түүнийг улс төрийг хямрал нүүрлэсэн үед төрийн байгуулалтын бүхий л механизмыг тэнцвэржүүлэгч гол хүч болгодог юм.

Холимог засаглал нь ерөнхийлөгчийн ч, парламентын ч бүгд найрамдах улсын гол гол шинжүүдийг хосолдоороо онцлог юм. Тухайлбал, ийм хэлбэрийг сонгосон улсад ерөнхий сайдын албан тушаал байдаг боловч ерөнхийлөгч болон парламент засгийн газрыг байгуулахад хамтардаг, засгийн газар нь ерөнхийлөгчийн ч, парламентын ч өмнө ажлаа хариуцан тайлагнадаг, нөгөөтэйгүүр ерөнхийлөгч нь парламентыг тараах эрхтэй байдаг. Энэ бүхэн нь холимог улсад ерөнхийлөгч зөвхөн төрийн тэргүүн байдаг боловч гүйцэтгэх эрх мэдлийг ерөнхий сайдтай хамтран тэргүүлдэг, парламентыг тараах эрхтэй зэрэг нь түүнийг үнэн хэрэгтээ төрийн байгуулалтын цөм болгодог юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЛБАН ТУШААЛЫГ БИЙ БОЛГОЖ, ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ҮНДСЭН ХУУЛЬ, БУСАД ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН НЬ

Монгол Улс буурал түүхийнхээ дийлэнхэд хаант засгийн хэлбэртэй оршин тогтнож ирсэн. Харин Монгол Улсад анх удаа бүгд найрамдах хэлбэрийг тогтоосон 1924 оны Үндсэн хуулийн оршилд: "Харъяат улсад Бүгд Найрамдах Ардын Засгийг явуулж, Ерөнхий даргыг сонгохгүй, улсын бүх дээд эрхийг Улсын Бага Хуралд ба мөн Хурлаар

сонгогдсон Засгийн газар хадгалах” гэж зааснаас үзвэл тус улсын төрийн байгуулалтын мөн чанарыг Монгол Улс бүгд найрамдах улсын хэлбэртэй, ерөнхийлөгчгүй (төрийн тэргүүнгүй) улс байх, төрийн дээд эрхийг төлөөллийн байгууллага хэрэгжүүлэхээр тогтоожээ. Энэхүү тогтолцоо нь бага сага өөрчлөлттэйгээр 1990 он хүртэл үйлчилжээ.²

Харин 1960 оны Үндсэн хуульд 1990 онд орсон нэмэлтээр төрийн тэргүүний албан тушаалыг сэргээснийг 1992 оны Үндсэн хуульд баталгаажуулсан билээ. Ийнхүү анхдугаар Үндсэн хууль батлагдсанаас хойш 66 жилийн дараа Монгол Улс төрийн тэргүүн буюу Ерөнхийлөгчтэй болсон юм.

Төрийн тэргүүний институт нь орчин үед төрийн механизмд түүний эзлэх байр суурь, үүрэг ролийг тодорхойлсон, төрийн бусад дээд байгууллагатай харьцах харилцааг зохицуулсан, бүрэн эрхийг тогтоосон, төрийн тэргүүний сонгууль, уг албан тушаалыг орлох, бүрэн эрхийг дуусгавар болгох, эх орноосоо урвасан, Үндсэн хуулийг зөрчсөн тохиолдолд түүнийг хариуцлагад татах журмыг тусгасан Үндсэн хуулийн болон холбогдох бусад хуулийн хэм хэмжээнээс бүрддэг.

Аль ч улсын төрийн тэргүүний гүйцэтгэх нийтлэг эрх хэмжээнд үндэсний эв нэгдлийг илэрхийлэх, төрийн засаглалын залгамж холбооны баталгаа болох, төрийн бусад байгууллагын үйл ажиллагааг зохицуулж, улс төрийн хямрал үүссэн тохиолдолд сөргөлдөгч талуудыг зөвшилцүүлэх бүрэн эрхүүд багтана. Нийтийн жишгээр төрийн тэргүүн нь зэвсэгт хүчний ерөнхий командлагч байдаг. Дээрх бүрэн эрхийн зэрэгцээ төрийн тэргүүн нь гадаад улсад суух дипломат төлөөлөгчдийг томилох, төрийн дээд шагнал, одон, медалиар шагнах, улсаа төлөөлж олон улсын гэрээнд гарын үсэг зурах, уучлал үзүүлэх зэрэг эрх хэмжээг хэрэгжүүлдэг.

Түүнчлэн төрийн тэргүүн нь хууль санаачлах, хуульд гарын үсэг зурж, батламжлах, хуульд хориг тавих зэргээр парламентын хууль тогтоох ажиллагаанд идэвхтэй оролцдог юм.

Парламентын болон засаглалын холимог хэлбэртэй улсад ерөнхийлөгч парламентыг тараах эрхтэй байдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуулийн зүйл, заалтуудын агуулгаас харагддаг. Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн”.

² 1940 оны Үндсэн хуулиар төрийн дээд эрхийг хэрэгжүүлэх байгууллага нь Улсын Их Хурал, түүний чөлөө завсар Улсын Бага Хурал ба Бага Хурлын Тэргүүлэгчид, 1960 оны Үндсэн хуульд зааснаар төрийн эрх барих дээд байгууллага нь БНМАУ-ын Ардын Их Хурал, түүний чөлөө цагт төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурлын Тэргүүлэгчид байхаар тогтоосон байдаг.

Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дэмжлэг үзүүлнэ. Ерөнхийлөгч Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд үндэсний эв нэгдэл, ашиг сонирхлыг дээдэлж, шаардлагатай үед нийгмийн бүлэг, хэсэг, улс төрийн хүчнүүдийг зөвшилцөлд хүрэхэд нь зуучилна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжоор Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, сонгууль явуулах журам, үе шат, Ерөнхийлөгчийн бүрэн эрх эхлэх, дуусгавар болох нөхцөлийг заажээ.

Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тогтоосон Үндсэн хуулийн заалтууд чухал ач холбогдолтой юм. Ерөнхийлөгч нь төрцийн байгуулал, улс орны удирдлагын талаар өргөн хүрээ бүхий бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд тэдгээрийн нэлээд нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагын хоорондын харилцааны асуудалтай холбоотой юм. Тухайлбал, Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын анхдугаар хуралдааныг товлон зарлах буюу улс орны чанартай хойшлуулшгүй чухал асуудлыг хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын ээлжит бус чуулган чуулахыг санаачлах, Улсын Их Хурлын чуулганд өөрийн тааллаар оролцож улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, төрийн бодлогын аливаа асуудлаар Улсын Их Хуралд санал оруулах зэрэг бүрэн эрхийг эдлэнэ. Ерөнхийлөгчид олгосон бодит эрх бол Улсын Их Хурлын баталсан хууль, шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих эрх юм.

Удирдлагын хэлбэрээс үл шалтгаалан нийтийн жишгээр төрийн тэргүүнийг гүйцэтгэх эрх мэдэлд хамааруулдаг тул ерөнхийлөгчөөс засгийн газартай харьцах харилцааны асуудал аль ч улсын хувьд үлэмж ач холбогдолтой байдаг. Гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Засгийн газартай харилцах өдөр тутмын ажил хэргийн харилцааг Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон Засгийн газрын тухай хуулийн "Засгийн газраас Ерөнхийлөгчтэй харилцах" гэсэн 27 дугаар зүйлээр хуульчлан тодорхойлжээ. Тухайлбал, Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг томилох, Засгийн газрыг бүрдүүлэхэд зохих журмын дагуу оролцох, Үндэсний аюулгүй байдал, эв нэгдлийг хангах болон өөрийн бүрэн эрхэд хамаарах бусад асуудлаар Үндсэн хуульд заасны дагуу Засгийн газарт чиглэл өгөх, зарлигийнхаа биелэлтийн талаар Засгийн газрын мэдээллийг сонсох, Засгийн газрын хуралдаанд өөрийн тааллаар оролцож санал бодлоо илэрхийлэх, Улсын Их Хурлаас тодорхойлсон

Монгол Улсын дотоод, гадаад бодлогод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан болон үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй байгаа, түүнчлэн Засгийн газарт чиглэл өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг Засгийн газар хэрэгжүүлээгүй нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд саад болсон гэж үзвэл Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Засгийн газар нь Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авч Ерөнхийлөгчид мэдээлнэ. Ерөнхий сайд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлаа Ерөнхийлөгчид тухай бүр урьдчилан мэдэгдэнэ.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч өөр бусад бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ УДИРДЛАГЫН ХЭЛБЭРТЭЙ УЯЛДУУЛАН БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГА

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг зохицуулсныг бүхэлд нь авч үзвэл, нийтлэг зохицуулалтын хүрээнд тогтоосон нь харагдаж байна. Гэхдээ Ерөнхийлөгчийн сонгуулийн журам, түүнчлэн төрийн тэргүүнд олгосон зарим бүрэн эрх нь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим, бидний сонгосон удирдлагын хэлбэрийн үүднээс нарийвчлан авч үзвэл төрийн тогтолцооны тэнцвэрт байдлыг алдагдуулахад хүргэсэн гэж үзэх үндэстэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох журам, боловсронгуй болгох арга зам. Төрийн тэргүүн нь засаглах мандатаа аль субъектээс авснаас шалтгаалж түүний бүрэн эрх, зангарга, легитим шинж, улс төрд дарах жин тодорхойлогддог тул Ерөнхийлөгчийг сонгох журам түүний эрх зүйн байдлын үлэмж чухал хэсэг байдаг.

Монгол Улстай төстэй төрийн байгуулалттай, өөрөөр хэлбэл парламентын засаглалтай бүгд найрамдах улсад¹ төрийн тэргүүнээ ихэвчлэн шууд бус

¹ 1992 оны анхны эрчимтэй Үндсэн хууль баталгалаас өмнө тухайн үеийн Ардын Их Хурал, Улсын Бага Хурлын гишүүд төлөөлөгчид, эрхтгэн, судлаачдын дунд төрийн удирдлагын ямар хэлбэрийг сонгох талаар санал зөрөлдөж байсан боловч нийт ард иргэд, эрдэмтэн, судлаачдын олонхийн шийдвэр парламентын бүтд найрамдах төрийн хэлбэрийг сонгосны шалтгааныг Үндсэн хууль боловсруулах ажлыг зохион байгуулах комисс болон эрдэмтэн, судлаачид дараах үндэслэлээр тайлбарласан байдаг. Үүнд: нэгд, Монгол Улс хэргэ дээрээ хааны дарал дангаар ноёрхогч нэг намын удирдагчийн хатуу захиргаанд олон жил болсон тул Ерөнхийлөгчийн засаглалаас болгохын хэрэг, хоёрт, Ерөнхийлөгчийн засаглалтай болох Засгийн газар, цэрэг, улс төрийн бодлого нэг хүний гарт төвлөрч хоёр нх гүрний дунд оршиж манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын асуудал хөндөгдөнө, гуравт, Засгийн газар улс төрийн сонгуульд ялсан намын төлөөлөөр бүрддэг тул Ерөнхийлөгч гүйцэтгэх эрх мэдлийг тэргүүлбэл намын харьяалаас салгах боломжгүй бөгөөд дахин нэг намын дарангуйлал тогтож боломжгүй зэрэг зүйлийг анхаарч үзсэн байдаг. Чинца Б.Төр, нам, эрх зүйн шинэчлэлийн эгзэгтэй асуудал (нэгдүгээр хэсэг) УБс: 2008 он, 16, 133 дэлх тал.

сонгуулиар парламент⁴, эсхүл тусгай коллегий⁵ сонгодог. Парламентын бүгд найрамдах улсууд дотор зөвхөн Австри, Болгар болон Монгол Улсад Ерөнхийлөгчийг бүх нийтээр сонгодог билээ.⁶ Парламентын ихэнх бүгд найрамдах улс төрийн тэргүүнээ парламентаас, эсхүл парламентын оролцоотойгоор сонгодог журам тогтоосон нь цаанаа нарийн учиртай бөгөөд хамгийн гол нь ерөнхийлөгч өөрийгөө парламентад сэргүүлэн тавих явдлыг гаргуулахгүй байх зорилготой юм. Учир нь төрийн тэргүүн ч, парламент ч бүрэн эрхээ хэрэгжүүлэх мандатаа нэг эх үүсвэр буюу ард түмнээс авах тохиолдолд энэхүү хоёр институтын зиндаа ойртож, хоорондоо эрх мэдэл булаацалдах, үүнээс болж засаглалын дээд түвшинд үл ойлголцох байдал үүсэх, тэр нь даамжирсаар улс төрийн гүнзгий хямралд хүргэх аюултай. Түүхэнд ийм гашуун туршлага олон удаа давтагдсан тул эдүгээ парламентын бүгд найрамдах улсад төрийн тэргүүнээ төлөөллийн дээд байгуулагаас сонгох журам нь нэг ёсны стандарт болсон юм. Ийм ч учраас Монгол Улсыг сонгодог парламентын засаглалын хэлбэрт илүүтэй ойртуулахын тулд Ерөнхийлөгчийг парламентаас сонгох журамд шилжих санал санаачилга үе үе гарах болсон.⁷ Ерөнхийлөгчийг парламентаас сонгох саналын үндэслэл нь түүнийг бүх ард түмнээс сонгодог болгосон нь нүүрэн дээрээ Улсын Их Хурал хүчтэй, нидэр дээрээ Ерөнхийлөгч хүчтэй ийм л гажиг тогтолцоог бий болгосон, энэ нь Монгол Улсыг парламентын ч биш, ерөнхийлөгчийн ч биш хоёрын хооронд улс болгосон учраас сүүлийн жилүүдэд хоёрдмол тогтолцооны дутагдалтай, доголдолтой талуудыг амсахад хүргэсэн тэрхүү алдааг засах шилдэг арга гэж үзсэн байна.⁸

Үүнтэй холбогдуулаж Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн сонгуулийн одоогийн журмыг анхлан хэрхэн тодорхойлсныг Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх, батлах үеийн баримтуудад түшиглэн тодруулах хэрэгтэй болов уу. Ардын Их Хурлаар Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх явцад ихээхэн маргаан дагуулсан асуудлын нэг нь Ерөнхийлөгчийн сонгуулийн журам байсныг судлаачид тэмдэглэсэн байдаг.⁹ Маргааны гол гогцоо нь ерөнхийлөгчийг хаанаас сонгох тухай асуудал байсан бөгөөд дэлхий

⁴ Чех Улс, Унгар, Грек Улс.

⁵ ХБНГУ-д Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн коллегид буудастайн бүх гишүүн болон мөн тооны муж улсуудын төлөөллийн байгуулагаас сонгогдсон депутатууд, Италид парламентын хоёр танхимын бүх гишүүд болон мужуудын зөвлөмүүдийн төлөөлөгчид. Энэтхэгт парламентын гишүүдээс сонгогдсон төлөөлөл болон муж улсуудаас сонгогдсон төлөөлөл тус тус орно.

⁶ Урьд өмнө Финланд зэрэг парламентын бүгд найрамдах засагтай улсад Ерөнхийлөгчөө бүх нийтээр сонгодог журмтай байснаас Үндсэн хуулиа өөрчлөх замаар татгалзан билээ.

⁷ Энхболд.З Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог бийт ёстой/Өдрийн сонин-2009.03.03., Хажигмаа.Б Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгодог болгох/Өдрийн сонин-2008.05.28.

⁸ Хажигмаа.Б Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгодог болгох/Өдрийн сонин-2008.05.28. Энхболд.З Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог бийт ёстой/Өдрийн сонин-2009.03.06.

⁹ Чингиз.Б 7-р, нэм. эрх зүйн шинэчлэлийн эгзэгтэй асуудал Нэг.цгээр.дэвтэр УБ: 2008 он, 133 дэх тал.

нийтийн жишгээс харвал үүнд ард түмнээс, эсхүл парламентаас сонгох гэсэн хоёр сонголт л байдаг. Гэтэл Улсын Бага Хурлаас өргөн мэдүүлсэн төсөлд Ерөнхийлөгчийн сонгууль нь хоёр шаттай байх, эхний шатанд сонгогчдын санал хурааж, хамгийн олон санал авсан хоёр хүнийг дараагийн шатанд парламентын шүүлтүүрээр оруулахаар тогтоосон¹⁰ ойлгогмж муутай, өөр хаана ч байхгүй¹¹ этгээд зохицуулалтыг санал болгожээ. Үүний учир шалтгааныг “Монгол Улсын Их Цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай” БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганы 2 дугаар хуралдаанд тавьсан илтгэлдээ БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат тайлбарлахдаа: “Ерөнхийлөгчийг шууд парламентаас сонгох зарчим нэлээд түгээмэл байгаа бөгөөд тухайн нөхцөлд парламентат ёс төлөвшин хөгжих үйл явц эхэлж буй орнуудад төр засаг нь ард түмнээс сонгогдсон парламентад төвлөрдөг байна. Үүний хамтаар Ерөнхийлөгчийг эрх мэдлээ хэрэгжүүлэхэд ард түмний төлөөлөгчдөөс төрийн дээд хяналт тавих, Ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд гарч болох дутагдал доголдлыг сэргийлэх, тухайн үед зааруулах, улмаар эрх мэдлээ хэрэгжүүлэх явдлыг хязгаарлаж байх боломжийг бүрдүүлдэг. Гэвч энэ тохиолдолд Ерөнхийлөгчийн сонгууль зөвхөн парламентын хүрээнд, түүнд суудал авсан намуудын хэмжээнд болдог бөгөөд нийт ард түмний хүсэл эрмэлзэл үүнд төдийлөн нөлөөлж чадаагүй ажээ. Тиймээс ч бид эдгээр хэлбэрийг хослуулсан уян хатан “дундаж” гэж болох хувилбарыг сонгож авсан юм” гэжээ.¹²

Энэ тайлбартай холбогдуулж хэлэхэд сонгуулийн үнэмлэхүй олонхийн мажоритар тогтолцоог хэрэглэж буй тохиолдолд сонгууль хоёр шаттай байх, эхний шатанд нэр дэвшигчдийн хэн нь ч хуульд заасан олонхийн босгыг давж чадаагүй бол хоёр дахь шатанд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг өрсөлдүүлэх нь түгээмэл журам боловч зөвхөн нэг субъект (эсхүл ард түмэн, эсхүл парламент) хоёр шатанд хоёуланд

¹⁰ Их цаазын төслийн 31 дүгээр зүйлийн 1-д “Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна”, мөн зүйлийн 4-т “Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана”, мөн зүйлийн 5-д “Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн хэн нь ч нийлүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг хоёр дахь шатны сонгууль буюу Улсын Их Хуралд оруулан хэлэлцэж чуулганд оролцсон гишүүдийн саналыг нууцаар хураана”, мөн зүйлийн 6-д “Улсын Их Хурлын чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон хэмээн үзнэ. Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол дахин нэг удаа санал хураана. Санал хураалтаар хэн нь ч олонхийн санал аваагүй бол Ерөнхийлөгчийн сонгуулийг эхнээс нь явуулна”.

¹¹ Гагцхүү АНУ-ын Үндсэн хуулийн Арванхоёрдугаар нэмэлтээр Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь бүх нийтийн сонгуулиар хамгийн олон санал авахын дүрч бас томилгдсон сонгогчдын олонхийн саналыг авах ёстой бөгөөд хэрч хэн ч олонхийн санал аваагүй бол хамгийн их санал авсан гуравас нүүртэй хүнээс Төлөөлөгчдийн танхим нууц санал хураалт явуулж нэн даруй Ерөнхийлөгчийг сонгоно. Тэртээ 1804 онд батлагдсан нэлээд төлөгтэй энэ журам байнга улс төрчид, судлаачдын шүүмжлэлд өртөө билээ.

¹² Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг (эмхэтгэсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан). Уб: 2004 он, 523 дахь тал.

нь санал өгөх замаар эхнээсээ дуустал сонгуульд оролцож, үр дүнг нь тодорхойлдог. Харин сонгох субъект нь хоёр өөр байх нь (эхэлж ард түмэн, дараагийн шатанд парламент) тийм ч ухаалаг зохицуулалт биш болов уу. "Дундыг баримталсан" гэх энэ санал дээр баахан маргалдаж ихээхэн цаг зарцуулсны эцэст Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байх нь хэвээр үлдэж, хоёр дахь шатанд хамгийн олон санал авсан хоёр хүнийг хооронд нь өрсөлдүүлэх биш харин "анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрнө"¹³ гэж уг заалтыг өөрчилсөн юм. Уг нь Үндсэн хуульд "Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана"¹⁴ гэсэн бэлэхэн заалт байдаг бөгөөд дийлэнх оронд энэ журмыг сонгуулийн хоёрдахь шат гэж үздэг. Гэтэл эхний санал хураалтаар сонгогдох, хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг дахин өрсөлдүүлэх аль алиныг анхан шатны сонгууль гэж үзэхээр болжээ. Өөрөөр хэлбэл ухаалаг бус, этгээд заалт нь улам гажсан заалт болж хувирчээ.

Энэ заалт нь анхнаасаа үл ойлголцох байдлыг дагуулсныг, тухайлбал сонгуулийн хоёр дахь шатыг өөр өөрөөр тайлбарлаж, тодотгосон хоорондоо зөрүүтэй хуулийн болоц албан бус тайлбар, тодруулгууд олноор гарснаас харж болно. Жишээлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд: "Анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж түүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль гаргах нь сонгуулийн хоёр дахь шат байна."¹⁵ гэжээ. Хуулийн энэ заалтыг судлаачид зүй ёсоор шүүмжлэхдээ, энд өгүүлж буй сонгуулийн хоёр дахь шатыг бие даасан сонгуулийн шат гэж хэлэхэд төвөгтэй, учир нь нэр дэвшигчийг сонгох ямар ч сонгууль явагддаггүй, харин анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж албан ёсоор бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрч хууль гаргаж буй зайлшгүй явагдах үйл явц юм гэж тэмдэглэсэн байдаг.¹⁶

¹³ Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дэх зүйлийн 4 дэх заалт.

¹⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дэх зүйлийн 5 дахь заалт.

¹⁵ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, 3 дугаар зүйлийн 6, УБ: 1993 он.

¹⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (хамтын бүтээл) УБ: 2009 он, 154 дэх тал.

Бусад оронд ч ард нийтийн санал асуулгын дүнг батламжилж парламент нь хууль гаргадаг жишиг бий. Энэ нь тухайн шийдвэрийг давхар баталгаажуулж байгаа хэрэг биш, харин ард түмний шийдвэрийг хэлбэржүүлж, хуулийн хүчинтэй болгож байгаа асуудал юм. Тэгээд ч засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн зарчмын дагуу иргэд сонгох эрхийнхээ дагуу Ерөнхийлөгчийг сонгосон байхад түүнийг парламент хүлээн зөвшөөрнө гэдэг угаасаа ойлгомжгүй хэрэг юм. Угтаа парламент бол өөрөө ард түмний төлөөллийн байгууллага бөгөөд ард түмний хүсэл зориг, түүний илэрхийллийг хүлээн зөвшөөрөхгүй байх боломжгүй билээ. Нэгэнт ард түмний сонголтыг Улсын Их Хурал хэзээ ч өөрчилж чадахгүйгээс хойш түүнийг хуулиар баталгаажуулах явдлыг сонгуулийн бие даасан шатад тооцох шаардлага байхгүй.

Ерөнхийлөгчийг хаанаас сонгож байгаа нь тухайн төрийн тогтолцооны мөн чанарыг тодорхойлох шийдвэрлэх шалгуур хараахан болохгүй ч сонгодог парламентын тогтолцоонд ойртож байна гэсэн утгаар төрийн тэргүүнээ парламентаас сонгодог журамд шилжих саналыг дэмжих нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тойрсон асуудал. Засгийн газрыг парламентаас томилсон Ерөнхий сайд толгойлдог. Ерөнхий сайд болон Засгийн газарт итгэл хүлээлгэх эсэх асуудлыг парламент шийдвэрлэдэг, тэдгээрт итгэл хүлээлгэхгүй гэж үзвэл парламент Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийг огцруулах эрхтэй байдаг зэрэг парламентын бүгд найрамдах улсын гол шинжүүдийг Ерөнхийлөгч нь нийт ард түмний сонгуулиар сонгогддог, парламентын сонгуульд ялж олонх болсон нам болон эвслийн намын удирдлагуудтай зөвшилцөж Ерөнхий сайдын нэрийг дэвшүүлж, парламентаар томилуулах зэрэг ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсын төрийн удирдлагын гол шинжүүдтэй давхцуулан хэрэглэхээр тогтоосон нь Монгол Улсыг цэвэр парламентын биш, цэвэр ерөнхийлөгчийн ч биш, холимог удирдлага бүхий бүгд найрамдах улсын хэлбэрт нэлээд дөхсөн төрийн удирдлагын өвөрмөц хэлбэртэй болгожээ.¹⁷ Иймд хэдийгээр Монгол Улсыг парламентын бүгд найрамдах улс гэдэгтэй дийлэнх судлаачид, улс төрчид санал нэгддэг боловч Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар тогтоосон энэхүү тогтолцоог холимог буюу хагас ерөнхийлөгчийн засаглалын хэлбэр мөн гэж олон судлаач үздэг.¹⁸

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (хэлтэйн бүтээл) Үб: 2009 он, 13 дахь тал, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (хэлтэйн бүтээл) Үб: 2000 он, 26 дахь тал.

¹⁸ Ерөнхийлөгчийн засаглал гэж юу ариал байна аа? Өдрийн сонин, 2006-11-08; Чулуунжав, Д. Либерализм ба ардчиллын нөхцөл дэх Монголын төрийн тогтолцоо, байгуулалж, засаглал, үйл ажиллагааны хууль эрх, улс төр, философийн орчин цэсийн тулгуур асуудлууд (1990-2009 он) Үб: 2009 он, 317-326 дахь тал.

Үүнийг тухайн үед “Парламентын удирдлагын хэлбэр зонхилж байгаа зарим орны Ерөнхийлөгчийн эрх хэмжээтэй харьцуулахад манай Ерөнхийлөгчид нэлээд эрх эдлүүлэхээр төсөлд оруулсан боловч Ерөнхийлөгч төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх буюу Засгийн газрын үйл ажиллагааг чиглүүлэхтэй холбогдсон эрх хэмжээ одоогийн төсөлд арай дутмаг байгаа юм”¹⁹ гэж тайлбарласнаас үзвэл төсөл боловсруулагчид Монгол Улсын Ерөнхийлөгчид бусад парламентын орны төрийн тэргүүн эдэлдэггүй эрх мэдлийг атгуулж байгаагаа анхнаасаа мэдэж байсан нь тодорхой байна.

Үүний үр дүнд 1992 оны Үндсэн хууль ёсоор Ерөнхий сайд ба Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг томилох, тогтооход Ерөнхийлөгч парламент дахь олонхтой зөвшилцөх замаар гол төлөв хөтлөх эрхтэйгээр оролцож байсан, тиймээс Ерөнхийлөгч дэмжихгүй л бол Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх боломжгүй, энэ утгаараа ямар Засгийн газар байгуулагдах, түүний бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орох эсэх нь Ерөнхийлөгчөөс шууд хамаарах асуудал байсан юм. Нөгөөтэйгүүр, Ерөнхийлөгчийн дэмжлэггүйгээр Ерөнхий сайд уг асуудлаа Улсын Их Хуралд оруулах боломжгүй байсан. Энэ нь Засгийн газар Ерөнхийлөгч ба Улсын Их Хурал хоёрын хоёулангынх нь дэмжлэгийг авч байж л байгуулагдана гэсэн хэрэг байв.

Энэ тогтолцооны согог нь 1997 онд Засгийн газрын тэргүүнд нэр дэвшигчийг Ерөнхийлөгч долоон удаа буцааснаар илэрхий болж, улс төрийн хүчнүүдийг гарц хайхад хүргэсэн юм. Улсын Их Хурлын гишүүд 1999, 2000 онд Үндсэн хуульд оруулсан “алдарт” долоон өөрчлөлт нь энэхүү хайлтын үр дүн болсон. Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбоотой өөрчлөлтүүдэд шинжилгээ хийвэл эдгээр нь цэвэр Ерөнхийлөгчийн эсрэг хандсан нь харагдана (хүснэгт 1-ээс үзнэ үү):

Хүснэгт 1

Үндсэн хуулийг батлах үеийн заалт	Үндсэн хуульд 2000 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр
Үндсэн хуулийн 33-р зүйлийн 2 (Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх үндсэн бүрэн эрхийн тухай)	

¹⁹ Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг. (эмлэгдсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан), УБ: 2004 он, 523 дахь тал.

“Улсын Их Хуралд олонх суудал авсан намтай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах”	“Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах”
Үндсэн хуулийн 39 дүтээр зүйлийн 2	
“Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ”	“Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.

Нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайдыг томилоход намуудтай зөвшилцдөг эрх, түүнчлэн Засгийн газрыг огцруулах санал оруулах Ерөнхийлөгчийн эрхийг²⁰ тус тус үгүй хийж харин намууд хоорондоо хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлыг өөрсдөд нь буцаан барих, дамжуулах үүргийг түүнд үлдээжээ. Энэхүү өөрчлөлтийн шалтаг нь Засгийн газрын эрх зүйн үндсийг сайжруулах буюу Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн байж болох тухай асуудал байсан боловч бай нь Засгийн газрыг байгуулахад оролцох Ерөнхийлөгчийн эрх мэдэл байсан нь

²⁰ Гэхдээ Үндсэн хуулийн 43-р зүйлийн 3-т: Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өмнө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ” гэсэн заалт мандгидмгүйг учраас Монгол Улсын Ерөнхийлөгч одоо ч Засгийн газрыг огцруулах санал гаргах эрхтэй хэвээрээ байгаа.

өөрчлөгдсөн заалтуудын агуулгаас тодорхой харагдаж байгаа юм.

Зарим эрдэмтэн, судлаач Монгол Улсын Үндсэн хуульд 2000 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын төрийн байгуулалтын бүрхэг байдлыг арилгах, Монгол Улсад парламентын засаглалыг жинхэнэ утгаар тогтоох зайлшгүй шаардлагаар зөвтгөн тайлбарладаг.²¹ Ер нь Засгийн газрыг байгуулахад Ерөнхийлөгчийн зөвшилцөл хүчтэй байх зэргээс үзвэл парламентын болон ерөнхийлөгчийн засаглалын хувилбарыг хольж хутгасан гэж үздэг судлаачидтай санал нэгдэж болохоор байна. Ийм ч учраас парламентын бүтд найрамдах улсад засгийн газрын хувь заяаг парламент дангаараа шийдвэрлэдэг нийтлэг зохицуулалтыг Үндсэн хуульдаа суулгасан нь нэг их буруу зүйл биш байх. Гагцхүү энэхүү зохицуулалтыг хэтэрхий бүдүүлэг аргаар хийсэн нь харамсалтай.

Парламентыг тараах Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн тухайд. Парламентын засаглалтай орнуудад хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын хооронд онцгой харилцаа тогтдог юм. Олон орны туршлагаас харахад эдгээр байгууллага нэг нэгнээсээ салангид бус, ойр нягт, харилцан шүтэлцээтэй байх тусмаа төрийн үйл ажиллагаа хэвийн явагддаг байна. Засгийн газар нь парламентын өмнө улс төрийн хариуцлага хүлээх бөгөөд түүнийг огцруулах өргөн боломж парламентад байдаг.

Парламентын засаглалын суурь зарчим нь тухайн улсад хэрэгжиж байгаа улс төрийн бодлогын талаар парламент, Засгийн газар өөр хоорондоо нэгдмэл байр суурьтай байгаа эсэхийг шалгах үндсэн механизм болсон Засгийн газарт итгэл үзүүлэх, эс үзүүлэх журам байдаг. Түүний утга учир нь гагцхүү төлөөллийн дээд байгууллагын итгэлийг олсон тохиолдолд Засгийн газар улс орныг удирдах, харин итгэл алдсан тохиолдолд парламент нь засгийн газраа огцруулах учиртай. Итгэл үзүүлэх, эс үзүүлэх хууль зүйн хэлбэр нь Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаар парламентад санал хураах, нөгөөтэйгүүр Засгийн газраас итгэл үзүүлж байгаа эсэх талаар санал хураахыг хүсэж ерөнхий сайд парламентад хандах зэрэг байна. Хэрэв парламентын гишүүд олонхийн саналаар Засгийн газраас явуулж байгаа бодлогыг дэмжихгүй гэсэн санал өгвөл Засгийн газар урьд нь шууд огцордог байсан. Гэхдээ парламент энэ эрхээ урвуулан ашиглах юм бол төрийн үйл ажиллагааны тогтвортой байдла алдагдаж, улс оронд мөнхийн хямрал, засаглалын хомсдол нүүрлэх эрсдэлтэй.²² Нөгөөтэйгүүр, бүх эрх мэдлийг нэг байгууллагын

²¹ Мөнх-Эрдэнэ А. Монголд үзг засаглалд нэг үзг.

²² Ийнхүү нь, Францад Дөрвөдүх Бүтэ Найрамдах Улсын үед (1946-1958 он) арван хоёрхон жилийн дотор 50 орчим Засгийн газар солигдсон байдаг. Гагцхүү Шарль де Голлийн санаачлагаар Франц Улс засаглалын хэлмэгч буюу лагас Ерөнхийлөгчийн хэлбэрийг 1958 оны Үндсэн хуулиар тогтоосноор энэ байдал засарсан билээ. Макалов, В.В. Конституционные право зарубежных стран. Общая часть. Walters

гарт төвлөрүүлэх нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын тэнцвэрийг хангахад чиглэсэн засаглал хуваах онолд харшлах төдийгүй, эцсийн дүнд парламентын ноёрхолд хүргэнэ.

Засгийн газрыг огцруулах парламентын эрхийг хязгаарлах эрх зүйн үндсэн хэрэгсэл нь Засгийн газрын санаачилгаар Ерөнхийлөгчөөс парламентыг тараах эрх²³ нь юм. Өөрөөр хэлбэл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хооронд үүссэн үл ойлголцох байдалд цэг тавих эрхийг сонгогчдод олгоно гэсэн үг. Парламентыг тараах эрх нь төрийн тэргүүнд хадгалагдах боловч зөвхөн Засгийн газрын хүсэлтээр хэрэгжих журамтай бөгөөд энэ нь Засгийн газрын төлөө парламентын хүлээх хариуцлагыг тэнцвэртэй байлгах механизм болдог.²⁴ Нэгэнт Засгийн газраар хэт их оролдох нь парламентын гишүүдэд өөрсдөд нь ийм эрсдэл дагуулдаг учир ийм зохицуулалт хэрэгждэг оронд төр, засаг нь тогтвортой байдаг. Парламентыг тараах журмыг парламентын болон холимог засаглалтай олон оронд нэвтрүүлснээр²⁵ парламентын засаглалын нэгэн үндсэн согог арилсан билээ. Нөгөөтэйгүүр, энэ журмыг ашиглан Ерөнхийлөгч ба Засгийн газар хамтран парламентыг дарамталж болох тул Үндсэн хуулиудад парламентыг тараах боломжийг зарим талаар хязгаарласан байдаг.²⁶

Иймд Монгол Улс парламентын засаглалтай орны хувьд парламентын урагшгүй ажиллагаанаас болж улс төрийн хямрал үүсвэл Засгийн газрын хүсэлтээр парламентыг тараах эрхийг Ерөнхийлөгчид олгох нь зүйтэй болов уу.

Kluwer, M.: 2006 г., с.418. Дэлхийн хоёрдугаар дайны дараа 60 гаруй Засгийн газрын нүүрийг үзсэн Итали Улс ч Үндсэн хуулиа өөрчлөхөд хүрч байжээ. Чиркин,В.Е., *Конституционные право зарубежных стран*, "Юрисп" М.: 2005 г., с.176.

²³ Монгол Улсын Ерөнхийлөгч парламентыг тараах эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 22 дүгээр зүйлд тусгасан боловч төр нь хэрэгжих боломжоо багатай, ний нуутгүй хэлэхэд тунхаглахын төдий эрх юм. Тухайлбал, уг зүйлд зааснаар Ерөнхийлөгч дараах томоолдуудад парламентыг тарьж болох юм байна: нэгд, Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор Улсын Их Хурал өөрөө тарьх, хоёрдугаарт, Ерөнхий сайдыг томилж санхүүг Улсын Их Хурлаас өргөн мэдүүлснээс хойш 45 хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх, чадлаагүй бол ирмэг тарьх буюу эсхүл Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргах. Эдгээр хоёр боломжийн аль аль нь амьдрал дээр хэрэгжих нь түвчтэй.

²⁴ Нарангэрэл, С., *Эрх зүйн эх бичиг, анхны хэвлэл* Уб: Адмон, 2007 он, 368 дэх тал.

²⁵ Болгар, Польшид Засгийн газрыг бүрдүүлэх боломжгүй болсон, Грек Улсад Ерөнхийлөгчийг сонгох боломжгүй болсон, Словак, Эстонид парламент Засгийн газарт үл итгэж байгаагаар нэрэмжлэсэн, ОХУ, Унгар-тодорхой хугацааны туршид Засгийн газарт үл итгэж байгаагаар дагтан буюу олон удаа нэрэмжлэсэн, Литв-Засгийн газрын хэргэвчлэрийг батлаагүй, Польш, Эстонид Засгийн газраас санал болгосон улсын төсвийг тогтоосон хугацаанд батлаагүй бол, Мин тэнд.

²⁶ Парламентыг тараах боломжийг хязгаарласан дараах улсын гол заалт байдаг: юуны өмнө хоёр танхимтай парламентын дээд танхимыг тарьж болохгүй, өнцгий байдал буюу дайны байдал үйчилж байгаа үед парламентыг тарьж болохгүй (Франц, ОХУ, Итали, Польш), Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн сүүлийн зургаан сарын хугацаанд (ОХУ, Итали, Литва) буюу парламентын бүрэн эрхийн эхний зургаан сарын хугацаанд (Литва), эхний нэг жилд (Франц, ОХУ) тарьж болохгүй, хэд хэдэн улсад парламентыг тодорхой хугацаанд тодорхой тооны удаа (жишээлбэл, Румынд нэг жилд нэгээс нүүгүй) тарьж болохгүй байх журмыг тогтоожээ. Мин тэнд.

ДҮГНЭЛТ

Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал нь удирдлагын хэлбэрийг тодорхойлох нэг гол шалгуур болдог. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон Ерөнхийлөгчийн эрх зүйн зохицуулалтын байдлыг бүхэлд нь дүгнэвэл дэлхий нийтийн жишигт нийцсэн нь харагдаж байна. Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн анхны хувилбар нь сонгодог парламентын засаглалын хэлбэрээр бүтээгдсэн боловч Үндсэн хуулийг анх баталж байх үед энэ хэлбэрийн талаарх мэдлэг бүрэн бүрдээгүй, нөгөөтэйгүүр, Үндсэн хуулийг боловсруулах үйл явц олон шат дамжлага дамжин хэрэгжсэн зэргээс үүдэн зарим үзэл баримтлал, зохицуулалтад өөрчлөлт орсон бөгөөд эдгээр нь бүгд эсрэг шинж чанартай байгаагүйг тэмдэглэх нь зүйтэй. Үүний уршгаар төрийн дээд байгууллагын хоорондын харилцаа нь төрийн эрх мэдэл хуваарилах зарчмаас гажсан нь төрийн тогтолцооны тэнцвэрт байдлыг зарим талаар алдагдахад хүргэсэн билээ.

Монгол Улсад өрнөсөн засаглалын хэлбэрийн тухай маргаан нь утаасаа Үндсэн хуулиар нэгэнт сонголт хийсэн энэхүү тогтолцоо олонхийн үзэж байгаа шиг *парламентын засаглал* мөн эсэх тухай маргаан юм. Маргааны гол гогцоо нь хоёр үндэслэл буюу Ерөнхийлөгчийн сонгууль болон Ерөнхийлөгчид олгосон зарим бүрэн эрхийг тойрдог юм.

Парламентын нэгэн адил бүрэн эрхийн мандатаа ард түмнээс авсан Ерөнхийлөгч хууль тогтоох дээд байгууллагатай сөрөглөх нь Монгол Улсад ч гарч байсан нь түүний эрх мэдлийг хязгаарлах нь зүйтэй гэдэг дээр улс төрийн намууд санал нэгдэхэд хүргэсний зэрэгцээ Ерөнхийлөгчийг парламентаас сонгож, эрх мэдлийг нь хязгаарлах тухай асуудал сөхөгдөж ирсэн.

Иймд Үндсэн хуулиар тогтоосон төрийн тогтолцоо маань дэлхийн олон оронд хэдийнэ туршигдсаныг иш үндэс болгож нийтийн жишгийг дагах нь бусдын алдааг давтахгүйн баталгаа болох тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн журмыг үндсээр нь өөрчлөх, Ерөнхийлөгчийн зарим бүрэн эрхийг тодотгон өргөтгөх замаар Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тус улсын удирдлагын хэлбэр болох парламентын бүгд найрамдах улсын жишигт улам ойртуулах үндсэн дээр боловсронгуй болгох саналыг дэвшүүлж байна.

○○○○○

○○○○○

○○○○○

**Хувьцаа эзэмшигч компанийн эрх ашгийг хамгаалан
нэхэмжлэл гаргах боломж ба ТУЗ болон гүйцэтгэх
удирдлагыг хамгаалах эрх зүйн боломж**



**МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
дэд профессор, хууль зүйн доктор
(LL.D) Б.Амарсанаа**

Компанийн эрх зүйн асуудал өнөөдөр улам бүр бизнес эрхлэгчид төдийгүй хуульчдын анхаарлыг татаж байгаа сэдэв болоод байна. Энэ хүрээнд одоогоор төдийлөн хөндөгдөөгүй зарим асуудлыг тоймлон энэ өгүүллээр авч үзлээ.

ДЕРИВАТИВ НЭХЭМЖЛЭЛ

Компани нь өөрийн гэсэн эрх, ашиг сонирхолтой байдаг. Харин компани нь үүсмэл этгээд болохын хувьд эзэн биегүй учраас шууд утгаар түүнийг хамгаалах бодит бие байхгүй юм. Тэгвэл түүний эрх, ашиг сонирхлыг хэн хамгаалах вэ? Компанийн төлөөлөгч болохын хувьд ТУЗ, гүйцэтгэх удирдлага компанийн эрх ашгийг хамгаалах ёстой байдаг бөгөөд тэдгээрийн үйлдэл, эс үйлдэл (компанийн эрх, ашиг сонирхлыг хамгаалан компанийн нэрийн өмнөөс шүүхэд хандах гэх мэт) нь компанийн үйлдэл, эс үйлдэл болохыг хуулиар зөвшөөрдөг.

Гэтэл амьдралд компанийг төлөөлж түүний эрх ашгийг хамгаалах ёстой ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь компанийн эрх ашгийг хохироох үйлдэл хийх боломжтой, хохироодог тохиолдол элбэг бий. Өөрийн гэсэн эзэн биегүй этгээд болох компанийн эрх ашиг нь тухайн 32

компанийг удирдаж буй этгээдийн ашиг сонирхлоос өөр байх тохиолдол байдаг. Энэ тохиолдолд тэд компанийн эрх, ашиг сонирхлыг хамгаалан шүүхэд өөрсдийгөө өгнө гэж байхгүй.

Иймээс компанийн эрх ашгийг хамгаалуулах зорилгоор ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйлдэл, эс үйлдлийн талаар шаардлага гарган компанийг төлөөлөх эрхийг гуравдагч этгээдэд хуулиар олгодог байна. Энэ гуравдагч этгээд жишээлбэл, компанийн ажилтан, хувьцаа эзэмшигч байх бололцоотой боловч хөрөнгийн хувьд нягт холбоотой этгээд болох хувьцаа эзэмшигч компанийг төлөөлөх эрхийг хуулиар олж авах бололцоотой байдаг. Өөрөөр хэлбэл компанийг удирдаж буй этгээд нь компанийн эрх ашгийн төлөө үнэнч шударгаар¹, ажилдаа хариуцлагатай хандах² ёстой боловч ийнхүү ажиллаагүй үед жижиг хувьцаа эзэмшигч нь удирдлагын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж чадаагүй компанийн "жинхэнэ" ашиг сонирхлыг хамгаалан компанийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлөн шүүхэд ханддаг. Энэ нь компанийн эсрэг гаргаж буй нэхэмжлэлтэй хамааралгүй юм.

Дээр дурдсан байдлаар буюу хувьцаа эзэмшигч компанийн нэрийн өмнөөс, түүний эрх ашгийг хамгаалан шүүхэд хандах боломжийг олгодог нэхэмжлэлийг *дериватив* нэхэмжлэл буюу хувьцаа эзэмшигч компанийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах гэдэг. Энэ нь хувьцаа эзэмшигчийн хувьд өөрийн нэрийн өмнөөс гаргаж буй нэхэмжлэлээс ялгаатай бөгөөд шүүх энэ асуудлыг ялгаж салган тодруулах хэрэгтэй байдаг.

Өөрийн нэрийн өмнөөс гаргаж буй нэхэмжлэл нь шууд утгаараа өөрийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн байдаг бол *дериватив* нэхэмжлэл нь хувьцаа эзэмшигч этгээд компанийн нэрийн өмнөөс компанийн эрх ашгийг хамгаалахад оршдог. Энэ нь ялангуяа олон хувьцаа эзэмшигчтэй хувьцаат компанийн жишээн дээр илүүтэй тод харагдана. Хувь хүний нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах болон компанийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах хоёрын гол ялгаа нь эрх зүйн үр дагаварт нь байдаг бөгөөд *дериватив* нэхэмжлэлд хохирлыг компанид олгодог бол өөрийн нэрийн өмнөөс гаргаж буй нэхэмжлэлд тухайн гомдол гаргасан хувьцаа эзэмшигчид хохирлыг олгодог.

Нөгөө талаас *дериватив* нэхэмжлэл нь компанийн хувьцааны зонхилох хэсгийг эзэмшин шийдвэрт нөлөөлж чадах олонхийн эсрэг жижиг хувьцаа эзэмшигчид өөрсдийн компани дахь эрх ашгийг хамгаалах хэрэгсэл болдог. Энэ нь мөн компанийн удирдлагад байгаа этгээдийн буруу үйл ажиллагааг шүүхэд хандах замаар шүүн тогтооход чиглэгддэг.

¹ Компанийн тухай хууль (1999) 81.2. Энэ хууль Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагснаар 2011 онд хүчин төгөлдөр бус болсон.

² Duty of care, duty to act reasonably.

Жишээ. Компанийн нэрийг хувийн ашиг орлого олоход ашиглах, компанийн хөрөнгийг бусдад шилжүүлэх зэргээр хувийн зорилгод санаатайгаар ашиглах, санамсаргүйгээр их хэмжээний хохирол учруулах зэрэг тохиолдол.

Нэг буюу хэд хэдэн хувьцаа эзэмшигчийн гаргасан³ дараах шаардлагыг хангаж байгаа дериватив нэхэмжлэлийг шүүх хүлээн авах бололцоотой байдаг. Үүнд:

- Нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргах шалтгаан болсон (эс) үйлдэл болсон үед тухайн компанийн хувьцаа эзэмшигч байсан;
- Нэхэмжлэлийг гаргахаас өмнө нэхэмжлэлийг гаргавал зохих этгээд болох компанийн ТУЗ-д асуудлыг тавьсан боловч хүлээн аваагүй.

Энэ нэхэмжлэлийг хувьцаа эзэмшигчээс өөр этгээд гаргаж болохгүй шалтгаан нь хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий байгууллагаас бусад этгээд нь компанийн хэрэгт хөндлөнгөөс оролцох эрхгүй, түүний бизнесийн үйл ажиллагаанд саад болох учиргүй гэсэн зарчмаас үүдэлтэй юм. Компани нь өөрийн бүтцээрээ дамжуулан эрх ашгаа хамгаалах нь хамгийн зөв хэмээн үздэг бөгөөд үүнд хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ компанийн эрх ашгийг хамгаалах ёстой гэсэн уг зарчмаас үүдэн гарч буй юм.

Шүүх нь дериватив нэхэмжлэлийг хэлэлцэхдээ компанийн дотооддоо шийдэх ёстой асуудал учраас бизнесийн байгууллагын дотоод хэрэгт оролцохгүй байх зарчмыг баримтлан болгоомжтой хандах ёстой байдаг.

БИЗНЕСИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ДҮРЭМ⁴

Бизнесийн өөрийн мөн чанар нь байнгын эрсдэлтэй нөхцөлд ашиг олох явдал байдаг. Хэрэв ямар ч эрсдэлгүй нөхцөл байгаад, тэр нь бизнес болж байвал түүнийг хүн болгон хийх билээ. Бодит байдал ийм биш учраас тэрхүү эрсдэлтэй нөхцөлд шийдвэр гаргаж байдаг эрх бүхий албан тушаалтныг эрсдлээс зугтах байдалд аль болох түлхэж болохгүй юм. Ийнхүү эрсдлээс зугтах нөхцөл байдал оруулбал компанийн үйл ажиллагаа доголдох нь гарцаагүй.

Энд дурдсан эрсдэлийн нэг нь эрх бүхий албан тушаалтан ямарваа нэг үйлдэлдээ хуулийн хариуцлага хүлээх эрсдэл юм. Эрх бүхий албан тушаалтанд хуулийн хариуцлага хүлээлгэх хамгийн боломжит арга нь

³ Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга) 83 дугаар зүйл. Энэ зүйлд Компанийн зөлийн хувьцааны нэг буюу түүнээс дээшмийг эзэмшигч нь шүүхэд дериватив нэхэмжлэл гаргаж болохоор заасан байдаг.

⁴ Amr. Business Judgment Rule

түүнийг үүргээ биелүүлээгүйд тооцох явдал байдаг. Энд эрх бүхий албан тушаалтны хариуцлагатай хандах үүрэг гарч ирдэг. Энэ нь эрх бүхий албан тушаалтныг хувь хүнийх нь хувьд хариуцлага хүлээлгэхээр, түүний эд хөрөнгөд халдах боломжийг олгодоггоороо, энэ үүргийн агуулгыг хэт өргөн утгаар ойлговол бизнесийг удирдаж явах хүн олдохгүй, олдсон ч энэ үүргээ зөрчсөн болохгүйн тулд шийдвэрнийг хэт удаан гаргахад хүргэх юм.

Өмнөх хэсэгт дурдсанаар хариуцлагатай хандах үүрэг нь нэлээд өргөн хүрээнд тодорхойлогдох магадлалтай, тиймээс эрх бүхий албан тушаалтан энэ үүргээ биелүүлээгүй гэж тооцогдох эрсдэл өндөр юм. Өөрөөр хэлбэл энэ үүрэг эрх зүйн "яг таг" тодорхой байдлыг бий болгодоггүй учраас дурын этгээд дээрх тодорхой бус байдлыг ашиглан бизнесийн ердийн үйл явцад зөвтгөгдөж болох үйлдэл, эс үйлдэл (бизнесийн эрсдэл агуулсан шийдвэр)-ийг хийсэн эрх бүхий албан тушаалтныг байнгын эрх зүйн дарамтад (шүүхэд өгөх, тийнхүү сүрдүүлэх гэх мэт) оруулах, ажлыг нь хийлгэхгүй байх боломжтой юм. Нийм тохиолдол үүсэн гардаг нь гадаад улсуудын практик дээр нотлогдсон байна.

Ишигээ. ТУЗ нь өөр компанитай нэгдсэнээр өөрийн хувьцаа тутамд 10.000 төгрөг бэлнээр олгодоно хэмээн цээж нэгдэхийн төлөө санаа өгснийг аль нэг хувьцаа эзэмшигч түүнээс илүү байх ёстой байсан, үүргээ биелүүлээгүйгээс хохирол учирсан гэх чндэс.13.13эр голд.1 гаргаж болно.

Энэ тохиолдолд үнэхээр 10.000 төгрөг хангалтгүй, харин 10.010 төгрөг байх ёстой гэж маргаж байвал түүний аль нь зөв болохыг тогтоох маш төвөгтэй бөгөөд бизнесийн шийдвэр гаргах дүрмийг хэрэглэж, ТУЗ-ийн шийдвэрийг, мөн чанартаа ТУЗ-ийн гишүүдийг шийдвэр буруу гаргасан, үүргээ биелүүлээгүй гэж тооцон хариуцлага хүлээлгэх эрсдэлээс хамгаалах бололцоо бий.

Үүнээс зайлсхийх зорилгоор Бизнесийн шийдвэр гаргах дүрмийг шүүх хэрэглэдэг. Энэ нь нэг талаас компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг харьцангуй тодорхой болгох, хариуцлага хүлээх, эс хүлээх тохиолдлыг урьдчилан таагдахуйц байлгахын тулд үүрэг, хариуцлагын хүрээг хумих байдлаар томъёологдож, эрх бүхий албан тушаалтныг шаардлагагүй дарамт, шахалтаас хамгаалдаг. Энэ нь шийдвэр гаргах чадвар⁵ болон шийдвэр гаргахдаа хийсэн санаатай бус алдаа⁶ гэсэн хоёр зүйлээр тодорхойлогддог.

⁵ Англ. Imprudence of judgement.

⁶ Англ. Honest errors of judgement.

Дараах шаардлагыг хангаж байвал эрх бүхий албан тушаалтан нь бизнесийн шийдвэр гаргах дүрмийн хамгаалалтад ордол байна. Үүнд:

1. Үүргээ биелүүлэхдээ буюу шийдвэр гаргахдээ ямарваа нэг хувийн сонирхолтой байгаагүй;

2. Бизнесийн шийдвэр гаргахдаа тухайн нөхцөл байдалд тохирсон мэдээллийг ухамсартайгаар авч үзсэн байх;

3. Бизнесийн шийдвэр нь компанийн ашиг сонирхолд нийцсэн байх.

Дараах тохиолдолд компанид ашиг сонирхол нь уягдсан этгээд (stakeholders), ялангуяа жижиг хувьцаа эзэмшигч эрх бүхий албан тушаалтныг үүргээ биелүүлээгүй хэмээн буруутгах нь элбэг бөгөөд эдгээр тохиолдолд бизнесийн шийдвэр гаргах дүрмийг хэрэглэх бололцоотой байдаг.

- Охин компанийг өөрчлөн байгуулах;
- Хөрөнгийг нь бууруулах;
- Ногдол ашиг хуваарилах, түүний хэмжээг тогтоох;
- Хөрөнгийн тодорхой хэсгийг зарах;
- Зарим төрлийн бизнесээ зогсоох г.м.

Энэхүү бизнесийн шийдвэр гаргах дүрэм нь Монгол Улсын хууль тогтоомжид шууд заагдаагүй ойлголт бөгөөд зарим улсад (тухайлбал Япон) энэ нь зөвхөн онолын ойлголт боловч шүүх нь түүнийг хэрэглэдэг байна.

Дээрхээс үзэхэд үүргээ биелүүлэх буюу хариуцлагатай хандах үүрэг болон Бизнесийн шийдвэр гаргах дүрмийн агуулга нь төдийлөн тодорхой биш ойлголт болох нь харагдаж байгаа бөгөөд эдгээр ойлголтыг шүүх тодорхойлон тухайн тохиолдолд хэрэглэх шаардлагатай байдаг.

○○○○○ ○○○○○ ○○○○○

**Захиргааны эрх зүйн тусгай ангийн өнгөрсөн, одоо,
ирээдүй: Эдийн засгийн захиргааны эрх зүй нь
төрөлжсөн захиргааны эрх зүй болох нь**

**МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн дэд профессор,
хууль зүйн доктор (Ph.D)
Г.Банзрагч**



I. ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ТУСГАЙ АНГИЙН ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ

Энэхүү өгүүлэлийн хүрээнд Монгол Улсын захиргааны эрх зүйн тусгай ангийн хөгжлийн өнгөрсөн, одоо, ирээдүйн хандлагын тухай товч авч үзэхдээ цаг хугацааны хувьд 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш буюу Монгол Улс улс төр, нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжин “эрх зүйт” төрийг байгуулах зорилгоо тодорхойлсноос хойших үеийг хамруулсан.

Энэ үеэс эхлэн дотоодын хууль тогтоомжийг зорилго, агуулгаар нь нийтийн болон хувийн эрх зүй гэсэн үндсэн хоёр хэсэгт ангилсан бөгөөд ялангуяа нийтийн эрх зүйн хүрээнд хамаарагдах эрх зүйн салбаруудын зорилго, агуулга, мөн чанар үндсэндээ өөрчлөгдсөн. Үүний нэг нь Захиргааны эрх зүй¹ юм. Орчин үеийн захиргааны эрх зүй нь захиргаа ба иргэд хоорондын харилцааг, захиргаанаас иргэдэд эрх ба үүргийг бий болгосон харилцааг зохицуулж байна. Эрх зүйт төрийн нэг

¹ Захиргааны эрх зүй гэдэг нь (нийтийн) захиргаанд тусгайлан зориулагдсан, тухайлбал, захиргааны шийдвэр гаргах ажиллагаа, бусад үйл ажиллагаа болон захиргааны байгууллагатай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээнүүдийн нийлбэр цогц юм., Олгэрэл.П. Захиргааны эрх зүйн сэнхлэгий анги.

гол зарчим нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд иргэдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Энэ нь захиргаанаас эрх зүйн давуу байдлаа буруугаар ашиглаж иргэдийн болон нийтийн ашиг сонирхлыг хохироохоос сэргийлэхэд оршдог. Захиргаа нь нийгмийн бүх салбарыг хамарч маш өргөн хүрээгээр үйл ажиллагаа явуулдаг учраас тухайн салбаруудын захиргаатай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээнүүд захиргааны эрх зүйд хамаарна. Иймд хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн ихэнх хэсэг нь захиргааны эрх зүйд хамаарадагаараа бусад салбар эрх зүйгээс ялгагдахын зэрэгцээ хамгийн бэрхшээлтэй салбарт тооцогддог. Энэ нь захиргааны эрх зүйн нөлөөллийн хүрээ, нийгэмд гүйцэтгэх үүргийг илэрхийлэхийн зэрэгцээ нийгмийн хөгжил, хувьслаас үл хоцрон, тулгамдсан тодорхой асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэх, хоорондын зөрчил болон хийдэл багатай эрх зүйн цогц систем тогтолцоо бүрдүүлэхийг шаардаж байдаг.²

Иймд захиргааны эрх зүй гэдэг нь өргөн утгаараа нийтийн захиргааны үйл ажиллагааг зохицуулж буй бүхий л хэм хэмжээний цогц юм. Энэхүү өргөн хүрээтэй, төвөгтэй, цогц эрх зүйн салбарыг хууль зүйн шинжлэх ухааны судлагдахууны хувьд болон бодит хэм хэм хэмжээний хувьд системчлэх зорилгоор агуулгаар нь "захиргааны эрх зүйн ерөнхий анги"³ ба "захиргааны эрх зүйн тусгай анги" хэмээн хоёр хуваадаг.

Захиргааны эрх зүйн ерөнхий ангид захиргааны эрх зүйн бүх салбарт хамаарах үндсэн ойлголтууд, зарчмууд болон зохицуулалтууд хамаардаг. Үүнийг багцалбал, Нийтийн захиргааны тухай ойлголт; Захиргааны эрх зүйн эх сурвалжийн тогтолцоо, хэрэглээ; Захиргааны үйл ажиллагааны хэлбэр: захиргааны акт, захиргааны гэрээ; Захиргааны үйл ажиллагаанд гарч болох алдаа, түүний эрх зүйн үр дагавар; Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа; Захиргааны шийдвэр гүйцэтгэл, хяналт; Нийтийн эд зүйлсийн зохицуулалт; Захиргааны хариуцлага гэх мэт.⁴ Ялангуяа захиргааны актыг батлан гаргах, захиргааны гэрээ байгуулах, тэдгээрт тавигдах эрх зүйн шаардлага, түүнийг зөрчсөнөөс үүдэн гарсан үр дагаврын асуудлууд захиргааны эрх зүйн ерөнхий ангид чухал үүрэг гүйцэтгэдэг.

Захиргааны чиг үүрэг нь нийгмийн салбарын онцлог шинжээс хамааран ялгамжтай байдаг тул тэдгээрт тохирсон ялгаа бүхий эрх

² Олгэрэл.П Захиргааны эрх зүйн ерөнхий анги 33-35 дэх тал.

³ Манай улсын хувьд Захиргааны үйл ажиллагааны тухай хууль (захиргааны ерөнхий ангийн хууль) харахад баталгаагүй тул бодит хэм хэмжээний хувьд захиргааны эрх зүйн ерөнхий анги бүрэн утгаараа бүрдэжгүй байна. Харин олонын хувьд буюу шинжлэх ухааны судалгаа, судлагдахууны хувьд хэрэвгүй тогтсон гэж үзэж болно.

⁴ Хариуцлага уу. Олгэрэл.П Захиргааны эрх зүйн ерөнхий анги 36 дэх тал, Долгорсүрэн.Ж Монгол Улсын захиргааны эрх зүй 23-25 дэх тал, Сүхбаатар.Ж Монгол Улсын Захиргааны эрх зүй 24-25 дэх тал.

зүйн зохицуулалтыг шаарддаг. Иймд захиргааны эрх зүйн хэм хэмжээг зохицуулж буй салбарынх нь онцлогоос хамааран төрөлжүүлдэг. Өөрөөр хэлбэл, захиргааны эрх зүйн тусгай анги гэдэг нь захиргааны тодорхой нэг, бодитой чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг тусгайлан зохицуулах шаардлагад үндэслэсэн "төрөлжсөн захиргааны эрх зүй" юм. Захиргааны эрх зүйн тусгай ангийн хэм хэмжээ нь ерөнхий ангийн хэм хэмжээгээ үргэлжлүүлэн гүйцээж, илүү тодорхой болгохын зэрэгцээ зарим тохиолдолд мөн өөрчилж байдаг. Нөгөө талаас, захиргааны эрх зүйн ерөнхий анги нь бие даасан зохицуулалт үгүй, эсхүл төгс зохицуулалдаагүй тусгай ангийн харилцааг зохицуулдагаараа гүйцээх шинжтэй байдаг.

Манай улсын захиргааны эрх зүйн тусгай анги нь саяхныг хүртэл үндсэндээ системчилэлгүй, ерөнхий ангитайгаа уялдаа холбоогүй явж ирсэн. Харин 2006 оноос МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хичээлийн хөтөлбөрт Захиргааны эрх зүйн тусгай анги гэсэн бие даасан судлагдахууныг бий болгож заавал үзэх хичээлийн жагсаалтад оруулсан нь энэхүү салбар дахь нэг том алхам болсныг тэмдэглүүштэй.

Гэхдээ өнөөдрийн байдлаар захиргааны эрх зүйн тусгай анги гэдгийг нийгмийн салбарын удирдлагаар нь, тухайлбал, захиргаа-улс төрийн хүрээний, аж ахуйн хүрээний, нийгэм-соёлын хүрээний, салбар хоорондын хүрээний удирдлага хэмээн үзэж байна.⁵ Үүнийг доктор Д.Дашцэдэн, "Захиргааны эрх зүй II дэвтэр", доктор Ш.Цогтоо "Нийтийн захиргаа: удирдлага, эрх зүй", доктор Ж.Долгорсүрэн "Монгол Улсын захиргааны эрх зүй" зэрэг ном, сурах бичгээс харж болно.

Гэтэл энэхүү концепцис гадна Монгол Улсын Санхүүгийн эрх зүй, Татварын эрх зүй, Гаалийн эрх зүй, Экологийн эрх зүй, Газрын эрх зүй, Цагдаагийн байгууллагын захиргааны эрх зүй зэрэг нь захиргааны эрх зүйн бие даасан болон дэд салбар эрх зүй гэсэн үзэл баримтлал салбарын эрдэмтдийн хувьд байна.⁶ эдгээр нь ч манай улсын эрх зүйн тогтолцоо, тодруулбал нийтийн эрх зүйн хүрээнд өөрийн гэсэн байр сууриа эзлэх болтлоо хөгжжээ.

Түүнээс гадна нутгийн удирдлагын эрх зүй, төрийн албаны эрх зүй, төрийн хяналт шалгалтын эрх зүй зэрэг нь захиргааны эрх зүйн төрөлжсөн салбар эрх зүй юу, эсхүл тусгай ангийн асуудал уу, эсхүл бүр ерөнхий ангийн асуудал уу гэдэг нь тодорхойгүй байдалтай байна.

Үүнээс үзвэл Монгол Улсын захиргааны эрх зүйн тусгай ангийг нэг талаас нийгмийн салбарын удирдлагын асуудал, нөгөө талаас хэд

⁵ Хэрвүүмаа уу, Долгорсүрэн Ж. Монгол Улсын захиргааны эрх зүй 46 дэх тал.

⁶ Цогтоо Ш. Нийтийн захиргаа: удирдлага, эрх зүй. II хэсэг.

⁷ Тынор С. Санхүүгийн эрх зүй, Сэнгэлорж Т., Амархүү О. Экологийн эрх зүй, Цогтоо Ш. Гаалийн эрх зүй, Долгорсүрэн Ж. Цагдаагийн байгууллагын захиргааны эрх зүй г.м.

хэдэн бие даасан салбар болон дэд салбар эрх зүйгээс бүрдэж буй мэт ойлгогдож байна. Хэдийгээр энэ нь зарчмын хувьд зөрчилтэй боловч манай улсын эрх зүйн хөгжлийн түвшин, онцлогоос хамаарч зайлшгүй шинжтэй "Монгол Улсын онцлог" хэмээн зөвтгөж болох юм. Учир нь улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын хүрээнд дэх төр-иргэний хоорондын харилцааг зохицуулсан нийтийн эрх зүйн хэм хэмжээ нь бие даасан салбар эрх зүй болохуйц хэмжээнд, хууль зүйн шинжлэх ухааны судалгааны түвшинд ч төр үйлчилж буй эрх зүйн эх сурвалжийн хувьд ч төр хараахан хүрээгүй байна. Гэхдээ энэ нь шилжилтийн шинжтэй тул цаашид захиргааны эрх зүйн салбарын удирдлагаас салбарын эрх зүйн зохицуулалт буюу захиргааны эрх зүйн тусгай ангийг бүрдүүлэгч төрөлжсөн захиргааны эрх зүй болж хөгжих учиртай.

Захиргааны эрх зүйн тусгай ангийн хөгжлийн ирээдүйн чиг хандлагыг дүрсэлбэл:

- Захиргаа-улс төрийн салбарын удирдлагаас-“цагдаагийн эрх зүй”, “нийгмийн хэв журмын буюу аюулгүй байдлын эрх зүй”, “байгаль орчны эрх зүй”;⁷

- Нийгэм-соёлын салбарын удирдлагаас-“нийгэм хамгаалалын эрх зүй”⁸, “эрүүл мэндийн эрх зүй”, “боловсролын эрх зүй”, “соёлын эрх зүй”;

- Эдийн засгийн салбарын удирдлагаас- “эдийн засгийн захиргааны эрх зүй” зэрэг төрөлжсөн захиргааны эрх зүй хөгжих боломжтой гэж үзэж байна.

Түүний сацуу одоо нэгэнт тогтсон татварын эрх зүй, санхүүгийн эрх зүй, төрийн албаны эрх зүй, нутгийн удирдлагын эрх зүй, байгаль орчны буюу экологийн эрх зүй зэрэг нь байх нь гарцаагүй. Гагцхүү зорилго, агуулга, бүтцийн хувьд захиргааны эрх зүйн ерөнхий ангитайгаа уялдах, шинэчлэгдэх, зарим талаар өөрчлөгдөх шаардлагатай байж болох юм.

Дээрхээс гадна манай улсын онцлогоос хамааран цаашид “Барилгын эрх зүй”, “Уул уурхайн эрх зүй” зэрэг төрөлжсөн захиргааны эрх зүйг хөгжүүлэх шаардлагатай байна.

II. ЭДИЙН ЗАСГИЙН ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙГ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ТУСГАЙ АНГИЙН НЭГ БИЕ ДААСАН САЛБАР ЭРХ ЗҮЙ БОЛГОХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ

Хүн төрөлхтөний аж амьдралын оршин тогтнох, таатай амьдрах,

⁷ Монгол Улсын хувьд байгаль орчин буюу экологийн эрх зүй нь бие даасан салбар эрх зүйн хэмжээнд хөгжсөн байна.

⁸ Манай улсын хувьд тодорхойгүй шалтгаанаар нийгэм хамгаалалын эрх зүйг хувийн эрх зүйн хүрээнд хамааруулж ирсэн.

хөгжин дэвших эх үндэс нь баялаг боловч баялаг нь хязгаарлагдмал байдаг. Иймд "эдийн засаг" гэдгийг хязгаарлагдмал баялгийг илрүүлэх, үйлдвэрлэх, хуваарилах замаар хүний хэрэгцээг төлөвлөгөөтэйгөөр аль болох бүрэн хангахын төлөөх арга хэмжээ болон зохион байгуулалтын (байгууллагуудын) нийлбэр гэж тодорхойлсон байдаг.

Аль ч улс, үндэстний хувьд хязгаарлагдмал нөөц баялгаар хязгааргүй хэрэгцээгээ хэрхэн яаж зохистой хангах вэ? гэдэг асуудал үүсэх бөгөөд эндээс эдийн засаг дахь төрийн оролцооны зайлшгүй шаардлага урган гарч буй юм.

Эдийн засаг дахь төрийн оролцооны зорилго, зохицуулалтын арга, хэлбэр зэргээс шалтгаалан улс орон бүр эдийн засгийн харилцан адилгүй тогтолцоотой байна. Онолын хувьд эдийн засгийн меркантилизм (төрийн оролцоог шүтсэн), либерализм (төрийн оролцоог үгүйсгэсэн), интервенционизм (төрийн оролцоог тодорхой хүрээнд хүлээн зөвшөөрсөн)-ын үзэл баримтлалд тулгуурласан төвлөрсөн төлөвлөгөөт, зах зээлийн болон эдийн засгийн холимог загварууд байна.

Эдийн засгийн аль ч тогтолцооны хувьд төр-эдийн засгийн харилцааг зохицуулах эрх зүйн үндэс шаардлагатай байдаг бөгөөд түүнийг тогтоох нь төрийн нэг чиг үүрэг байдаг. Тэрхүү эрх зүйн үндсийг бүхэлд нь "эдийн засгийн эрх зүй" гэнэ. Өөрөөр хэлбэл төр иргэдийнхээ эдийн засгийн харилцааг зохицуулахыг (журамлах, дэмжих, удирдан чиглүүлэх, хянах гэх мэтээр) хүсэж байгаа л бол эдийн засгийн эрх зүй хэмээх ойлголт зайлшгүй яригдах болдог.

Эдийн засаг дахь төрийн зохицуулалт (оролцоо)-ын зайлшгүй шаардлага нь:

1. Зах зээлийн үйл ажиллагаанд оролцож буй хүмүүс, компаниуд зах зээлд ноёлж, шударга бусаар өрсөлдөх тохиолдол гардаг. Иймд төрөөс шударга бус өрсөлдөөнийг зохицуулах шаардлагатай болдог;

2. Зах зээлд оролцогчид буюу үйлдвэрлэгчид бусад буюу нийтийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэх нь цөөнгүй. Тухайлбал, уул уурхайн компани нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг. Үүнийг дам нөлөө гэх бөгөөд энэ салбарт төрийн оролцоо (торгууль тогтоох, үйл ажиллагааг нь зогсоох, байгаль орчныг сэргээх арга хэмжээ авах, хохирлыг барагдуулах гэх мэтээр) зайлшгүй шаардлагатай болдог;

3. Нийгмийн зарим нөөцийг, тухайлбал, байгалийн баялагийг иргэд хамтаар эзэмшиж, нийтээр хэрэглэдэг тул тэрхүү нөөцийн хэрэглээг төрөөс нийтийн ашиг сонирхлын тусын тулд зохицуулах шаардлагатай болдог. Хэрэв төрөөс эдгээр нөөцийн хэрэглээг зохицуулахгүй бол түүнийг хэт их хэрэглэх, сүйтгэх, булаацалдах асуудал үүсэх бөгөөд энэ

нь эргээд нийгэмд үр ашиггүй зардал үүсэхийн шалтгаан болдог;

4. Зах зээлийн эдийн засгийн оршин тогтнох үндэс нь өмч байдаг. Учир нь зах зээл бол бараа таваар, тэдгээрийг ашиглах эрхийн солилцоо тул энэхүү эрх нь хангалттай хамгаалагдаагүй нөхцөлд зах зээлд оролцож буй талуудад, нийгэмд асар их нэмэгдэл эрсдэл, зардал үүсдэг. Иймээс төрөөс өмчийн эрхийг баталгаажуулах зайлшгүй шаардлагатай.

Иймд зах зээлийн эдийн засагт төр зайлшгүй оролцох шаардлагатай бөгөөд төр оролцсоноор нийгмийн, зах зээлийн үр ашиг өснө гэж үздэг.

Эдийн засаг дахь оролцооны үүрэг, хэлбэр:

1. Төрийн оролцооны анхдагч үүрэг нь зах зээлийн зохицуулалт буюу хувийн хэвшлийн зохицуулах замаар баялгийг бүтээх үйл явцыг урамшуулан дэмжих. Энэ нь дараах хоёр хэлбэрээр хэрэгжинэ:

а. Зах зээлийн механизм ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

б. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх (институтыг бий болгох).

2. Төр өөрийн өмчийн үйлдвэрүүдээр дамжуулан зах зээлд тодорхой төрлийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх (жишээ нь, олон нийтийн тээврийн үйлчилгээ, дэд бүтэц гм.);

3. Төр зах зээл дэх бараа үйлчилгээний томоохон худалдан авагч болох. Төр нь төсвөөр дамжуулан их хэмжээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авдаг. Энэ нь эдийн засаг дахь төрийн оролцооны чухал хэлбэр юм. Ялангуяа жижиг зах зээлтэй улс оронд төрийн худалдан авалтын үүрэг ач холбогдол нэлээд өндөр байдаг. Учир нь төрийн худалдан авалт нь жижиг эдийн засгийг дотоодын болон гадаадын зах зээлийн үнийн хэлбэлзэл, эрсдэлээс хамгаалах, эдийн засгийг тогтворжуулах үүргийг гүйцэтгэдэг гэж үздэг;

4. Төр төсөв, татвар, татаас нийгмийн хамгааллын бодлогоор дамжуулан нийгэм дэх орлогыг дахин хуваарилдаг. Энэ нь төрийн оролцооны нийгмийн асар чухал үүргийн нэг нь юм. Орлогын дахин хуваарилалт нийгмийн шударга ёс, ёс зүйн асуудалд ихээхэн нөлөөтэй байдаг боловч буруу хийгдсэн тохиолдолд хүмүүсийн хөдөлмөрлөх сонирхлыг бууруулж, бэлэнчлэх сэтгэлгээг бий болгодог аюултай.

Эдийн засгийн эрх зүй гэдэг нь төрөөс эдийн засгийн харилцаанд оролцогчдын хоорондын харилцаанд болон тэдгээрээс төртэй харилцах харилцаанд нөлөөлөх хувийн болон нийтийн эрх зүйн бүхий л хэм хэмжээнүүдийн нийлбэр цогц бөгөөд энэ нь эдийн засгийн харилцааны болон эдийн засгийн бодлогын эрх зүйн үндэслэл нь болдог.

Эдийн засгийн эрх зүйг эрх зүйн ерөнхий системчлэлээр ангилан авч үзвэл энэ нь үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

• Эдийн засгийн нийтийн эрх зүй (эдийн засгийн үндсэн хуулийн

эрх зүй болон эдийн засгийн захиргааны эрх зүй);

- Эдийн засгийн хувийн эрх зүй хамаарна.

Эдийн засгийн нийтийн эрх зүй гэдэг нь төр, иргэд хоорондын эдийн засгийн харилцааг зохицуулж буй нийтийн эрх, зүйн хэм хэмжээ, арга хэмжээнүүдийн нийлбэр цогц юм. Өөрөөр хэлбэл төрөөс иргэдтэй эдийн засгийн харилцаанд оролцохдоо төлөвлөх, хянах, дэмжих, удирдан чиглүүлэх замаар нөлөөлөх буюу давуу эрхтэй оролцох эрх зүйн үндэс нь хэмээн тодорхойлж болох юм.

Харин эдийн засгийн хувийн эрх зүй нь зах зээл дэх үйлдвэрлэгч, худалдагч, хэрэглэгчийн хоорондох бараа, ажил үйлчилгээний солилцоог зохицуулсан иргэний, худалдааны, аж ахуйн нэгжийн, өмчийн, гэрээний, бизнесийн эрх зүй зэргээс бүрддэг.⁹

Эдийн засгийн нийтийн эрх зүйг дотор нь эдийн засгийн үндсэн хуулийн болон захиргааны эрх зүй гэж ангилдаг.

Эдийн засгийн үндсэн хуулийн эрх зүй нь тухайн улсын үндсэн хууль дахь эдийн засгийн харилцааг зохицуулсан хэм хэмжээний нийлбэр цогц байх бөгөөд энэ нь улсын эдийн засгийн бодлогыг тодорхойлох бөгөөд эдийн засгийн харилцааг зохицуулсан бусад хуулийн үндэс, үзэл баримтлал, зарчим нь болдогоороо тэргүүлэх ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндсэн хууль дахь эдийн засгийн холбогдолтой зохицуулалтыг агуулгаар нь дараах байдлаар ангилах боломжтой байна. Үүнд:

- Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тодорхойлогч зарчмууд буюу төрийн зорилго, үйл ажиллагааны үндсэн зарчим, эдийн засаг, өмчийн харилцаа, төр-эдийн засгийн харилцааны ерөнхий зарчмыг тодорхойлсон зохицуулалтууд (Ү.Х-ийн Оршил хэсэг, Нэгдүгээр зүйлийн 1.2, Тавдугаар зүйл, Зургадугаар зүйл г.м);

- Эдийн засгийн харилцаанд дахь хүний үндсэн эрхийн хамгаалалтууд (Ү.Х-ийн Арван зургадугаар зүйлийн 16.3 "өмчийн эрх", 16.4. "аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх", г.м);

- Үндсэн хуулийн этгээд (УИХ, ЗГ, УДШ)-ийн эдийн засгийн бүрэн эрхийн зохицуулалт (Ү.Х-ийн §25.7, 38.2, 66.4 г.м).

Дээрх хэм хэмжээ нь нэг талаас төрөөс эдийн засгийн харилцаанд оролцох эрх зүйн үндэс буюу бүрэн эрх, нөгөө талаас түүний оролцооны хязгаарлалт болж өгдөгөөрөө чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн "Монгол Улсын бүрэн эрхт байдал" гэсэн тэргүүн бүлэгт төрийн зорилгыг хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх хөгжлийн шинэ чиг баримжааг тунхаглаад

⁹ Харуучица уу. Rolf Stober *Allgemeines Wirtschafts-verwaltungsrecht* s.10, Werner Frotscher *Wirtschafts-verfassungs- und Wirtschafts-verwaltungsrecht* 1994, s.4.

энэхүү нийгмийн байгуулалын улс төр, эдийн засаг, нийгэм, оюуны гэсэн дөрвөн үндсийг тодорхойлжээ.¹⁰

Иргэний, ардчилсан нийгмийн эдийн засгийн үндсийг Үндсэн хуулийн 5 зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна" гэж заасан байдаг. Энэхүү зүйл нь нэг талаас Монгол Улсын эдийн засгийн тогтолцоо, бодлогын үндсэн зарчмыг агуулсан, нөгөө талаас эдийн засгийн аль нэг онол, зарчмыг тухайлан заагаагүй "төвийг сахисан" шинжтэй байна. Дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага гэдгийг хуульч Г.Совд хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцаар шалгарч бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн **зах зээлийн эдийн засгийн харилцаа** хэмээн тодорхойлсон байдаг.¹¹ Энэхүү зах зээлийн эдийн засаг орших үндэс нь нийтийн болон хувийн өмч гэсэн хоёр төрөл бүхий олон хэлбэрийн өмч юм. Энэ тухай Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална", 5.3 дахь хэсэгт "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно" хэмээн өмчийн эрхийг Үндсэн хуулийн түвшинд хамгаалсан байна. Өөрөөр хэлбэл энэ нь шударга, чөлөөт өрсөлдөөнд үндэслэгддэг зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд нийтийн ба хувийн өмчийн зохистой харьцааг тогтоох, тэдгээрийн олон хэлбэрийг дэмжин тэтгэх, нийтийн өмчийг төр, орон нутгийн хооронд зөв хуваарилах, хувийн өмчийг хуулиар хамгаалах тухай юм.

Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн **эдийн засгийг зохицуулна**" гэснээс үзвэл энэ нь нэг талаар Монгол Улс нь төрийн зохицуулалт бүхий зах зээлийн эдийн засагтай байх онцлог шинжийг,¹² нөгөө талаар эдийн засаг дахь төрийн зохицуулалтын үндсэн чиглэлийг тодорхойлжээ.

Төрийн зорилго, үйл ажиллагааны зарчим, төр-эдийн засгийн харилцааг тодорхойлсон дээрх зохицуулалтуудын агуулгыг нэгтгэн үзвэл зах зээлийн эдийн засгийн харилцаан дахь төрийн зохицуулалт нь **юуны өмнө өмчлөгчдийн эрхийг адил тэгшээр хамгаалах, төрийн өмчийг**

¹⁰ Чингид Б. Үндсэн хуулийн цээж баримтлал Ув: 2002 он, 50 дахь тал.

¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар Ув: 2000 он, 41 дэх тал. Хэдийгээр дэлхийн эдийн засгийн өмнөгийн хандлага нь зах зээлийн эдийн засгийн харилцаа мөн боловч Монгол Улс Үндсэн хуулиар зах зээлийн эдийн засаг байгуулахаар хатуу тогтсон гэж ойлгож бас болохгүй болов уу. Эдийн засаг нь байна өөрчлөгдөн хөгжиж, улам боловсронгуй болж байгааг нийгмийн амьд харилцаа тул Монгол Улс дэлхийн нийтийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлага ямар байна, түүнийг чиг хандлага болгон өөрийн онцлогт нийцүүлэн дагана гэсэн санаа юм. Зох.

¹² Харьцуула уу. Ред. Совд.Г Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Ув: 2000 он, 44 дэх тал.

хувьчлан хувийг өмчийг хөгжүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, аж ахуйн үйл ажиллагаа чөлөөтэй эрхлэх, хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, шударга бус өрсөлдөөнийг зохицуулах, төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлогыг тодорхойлох, үндэсний нөөцийг зохистой хуваарилах, улсын төсөв, түүний гүйцэтгэлийг хянаж батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих зэрэг хэлбэрээр хэрэгжихээр байна.

Иргэдийн эдийн засгийн үндсэн эрх нь иргэдийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх, өв залгамжлуулах эрх, эд хөрөнгө эзэмших эрх (§16.3), ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох... хувийн аж ахуй эрхлэх эрх (§16.4), оюуны бүтээл туурвин үр шимийг нь өмчлөх эрх (§16.8) зэргээс бүрдэх бөгөөд эдгээр нь төрөөс эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох хязгаарлалт болж өгнө. Түүнээс гадна ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх гэсэн төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд (§1.2). Монгол Улсын төрийн байгууламж нэгдмэл байх зарчим (§2.1), түүнчлэн төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох төрийн эрх бүхий байгууллагуудын эрх хэмжээ, чиг үүргийн тухай зохицуулалт зэрэг нь (§§25.7, 38.2, 66.4) эдийн засгийн харилцаан дахь төрийн оролцоо, түүний зохицуулалтын хүрээ, хязгаарыг тодорхойлсон үндсэн хуулийн эрх зүйн хэм хэмжээ болно. Өөрөөр хэлбэл энэ бүхэн нь төрөөс эдийн засгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг гаргах, түүнийг хэрэгжүүлэхдээ баримтлах зарчим, үйл ажиллагааных нь хүрээ хязгаар болох юм.

Ийнхүү Монгол Улсад эдийн засгийн харилцаан дахь төрийн зохицуулалтын асуудлыг Үндсэн хуулийн хэмжээнд хуульчилсан нь тус улсын эдийн засгийн харилцааны өнгөрсөн үеийн (социалист) онцлог болон өнөөгийн зах зээлийн эдийн засгийн харилцааг хөгжүүлэх онцлогтой холбоотой юм.¹⁵ Энэ нь ч цаашид Монгол Улсад эдийн засгийн харилцааг эрх зүй, тэр дундаа эдийн засгийн нийтийн эрх зүй (үндсэн хуулийн болон захиргааны) хөгжих үндэс нь болох юм.

Макро болон микро эдийн засаг нь (тухайлбал хувийн хэвшлийн үйл ажиллагаа, аж ахуйн нэгжийн хүлээх хууль зүйн хариуцлага гм) тухайн улсын эдийн засаг, захиргааны эрх зүйн тогтолцооноос шууд хамаардаг. Ямар ч төр, тодруулбал, либерал төр ч гэсэн эдийн засгийн харилцаагаа их, бага хэмжээгээр заавал зохицуулах бөгөөд эндээс “эдийн засгийн захиргааны эрх зүй” хэмээх ойлголт бий болдог. Иймээс эдийн засгийн захиргааны эрх зүй нь аль ч улсын эрх зүйн тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг нь болдог. Гэхдээ энэ нь бие даасан салбар

¹⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар 44-45 дахь тал.

эрх зүй юу, эсвэл олон салбар эрх зүйд шингэсэн байна уу гэдэг нь өөр асуудал юм. Үүнд нэг мөр хариулахад төвөгтэй. Эдийн засгийн захиргааны эрх зүйг бие даалгах эсэх нь түүнийг системчлэх, онцлог шинжийг нь тодорхойлох, уялдаа холбоог нь олох онол, практикийн зайлшгүй шаардлага, хэрэгцээгээр тодорхойлогдох юм. Энэхүү салбар эрх зүйн хөгжлийн үйл явц нь дэлхийн улс орнуудад харилцан адилгүй байна. Тухайлбал, англо-америкийн эрх зүйн тогтолцоот орнуудын хувьд "эдийн засгийн захиргааны эрх зүй" хэмээх ойлголт байхгүй, оронд нь эдийн засгийн шинжтэй асуудлыг захиргааны эрх зүйн ерөнхий ангиар зохицуулж байна. Түүний зэрэгцээ зарим төрөлжсөн эрх зүйн салбараар, тухайлбал, Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах хуль, Өмчийн эрх зүй, Картелын эрх зүй гэх мэтээр зохицуулдаг. Харин ХБНГУ, Швейцар, Австри зэрэг эх газрын эрх зүйн тогтолцоотой улс болон зарим азийн оронд уг ойлголт, салбар эрх зүй нь нэлээд эрчимтэй хөгжиж байна.¹⁴

Эдийн засгийн захиргааны эрх зүй нь "эдийн засгийн эрх зүй", "захиргааны эрх зүй" гэсэн хоёр үндсэн эрх зүйн ойлголтоос бүрдэж байна. Гол агуулга нь эдийн засаг, түүнийг удирдах гэсэн санаагаар илэрхийлэгдэж байна.

Нийтийн захиргааны байгууллага нь захиргааны болон үйлчилгээний удирдлагын тогтолцооноос бүрддэг. Үүнтэй уялдан эдийн засгийн захиргааны эрх зүй нь төрөөс эдийн засгийн харилцааг дэмжих (татаасаар), шударга бус өрсөлдөөнийг зохицуулах (эдийн засгийг удирдан чиглүүлэх) мөн бэлэвшгүй аюулаас урьдчилан сэргийлэх замаар (эдийн засгийг хянан, шалгах) эдийн засгийг зохицуулах арга хэрэгсэл нь болдог. Нэг үгээр хэлбэл эдийн засгийн захиргааны эрх зүй нь бүхэлдээ эдийн засаг дахь төрийн хүлээх "хариуцлага"-ын илэрхийлэл бөгөөд эдийн засаг дахь захиргааны зорилго, чиг үүрэг нь эдийн засгийн өсөлтийн таатай нөхцөлийг бүрдүүлэх явдал гэж болно.

"Эдийн засгийн захиргааны эрх зүй" гэдэг нь нийтийн захиргаанаас эдийн засгийн үйл явцыг удирдан чиглүүлэх, дэмжих, хамгаалах зорилгоор захирамжлах, зөвшилцөх, бодитойгоор хэрэгжүүлэх хэлбэрээр нөлөөлөх эрх зүйн үндэс буюу захиргааны эрх хэмжээ, чиг үүргийг тогтоосон хэм хэмжээ, түүнчлэн эдийн засгийн харилцаанд оролцогчдод (иргэн, хуулийн этгээд) нийтийн эрх зүйн эрх, үүргийг бий болгосон хэм хэмжээнүүдийн нийлбэр цогцыг ойлгох юм.

Эдийн засгийн захиргааны эрх зүйн хүрээнд уг салбар эрх зүйд баримтлах үзэл баримтлал, зарчим, бүтэц, төрийн оролцооны чиг үүрэг, хязгаар түүнчлэн уг салбар эрх зүй нь бусад салбар эрх зүйтэй хэрхэн

¹⁴ Rolf Stober. *Allgemeines Wirtschafts-verwaltungsrecht* 1998, s.10-11.

холбогдох зэргийг тогтоох нь чухал юм. Юуны түрүүнд эдийн засгийн захиргааны эрх зүйд ямар зарчмыг баримтлах вэ? (тухайлбал, эдийн засгийн эрх чөлөөний зарчим, эдийн засгийн тэгш байдлын зарчим, гадаад эдийн засгийн чөлөөт байдлын зарчим, эдийн засгийн өөрөө удирдлагын зарчим г.м) гэдгийг, түүнчлэн бусад салбар эрх зүйн зарчмууд нь энэхүү салбар эрх зүйд нөлөөлөх эсэх, нөлөөлөх бол хэр хэмжээтэй нөлөөлөх зэргийг тодорхойлох шаардлагатай байдаг.

ДҮГНЭЛТ

Дээрхээс үндэслэн цаашид эрх зүйн тогтолцооны хүрээнд "эдийн засгийн эрх зүй", түүний дотор "эдийн засгийн нийтийн буюу захиргааны эрх зүй" хэмээх шинэ ойлголт, салбар эрх зүйг дараах үндэслэлээр хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна:

- Эдийн засаг нь нийгмийн оршин тогтнох үндэс, ард түмний амьдралын түвшинг ахиулах хөшүүрэг тул төрөөс эдийн засгийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, дэмжих түүнчлэн хянах нь зайлшгүй бөгөөд энэ харилцааг зохицуулсан хэм хэмжээний цогц болох "эдийн засгийн захиргааны эрх зүй" -г системтэйгээр хөгжүүлэх нь зүйтэй юм;

- Монгол Улс нэгэнт эх газрын эрх зүйн тогтолцоотой оронд хамаардагийн хувьд уг тогтолцооны улс орнуудын эрх зүйн хөгжлийн туршлагыг судлах, түүнийг өөрийн орны онцлогт тохируулан зүй зохистойгоор нэвтрүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байна;

- Монгол Улсын Үндсэн хуулиар эдийн засаг дахь төрийн оролцоо, нөлөө, түүний хүрээ хязгаар, зорилго, чиг үүрэг, зарчим зэргийг тодорхойлсон өвөрмөц онцлогтой бөгөөд түүнээс бие даасан салбар эрх зүй үүсэх бүрэн үндэслэлтэй юм;

- Тэрхүү үндсэн хуулийн зохицуулалтыг захиргаа бодит амьдрал дээр буюу эдийн засгийн тодорхой харилцаанд хэрхэн хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл эдийн засгийн харилцаан дахь захиргааны зорилго, үйл ажиллагааны зарчим, хэлбэр, арга хэрэгслийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай байна. Түүнчлэн захиргаа эдийн засгийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ бусад салбар эрх зүйтэй хэрхэн холбогдох, өөрөөр хэлбэл бусад салбар эрх зүйг хэрхэн хэрэглэх, эдийн засгийн харилцаанд оролцож буй бусад этгээд, тухайлбал иргэн, хуулийн этгээд бусад нэгдэл, холбоо зэрэг нь захиргаатай хэрхэн харилцах (захиргааны өмнө ямар үүрэг хүлээх, түүнээс юу шаардах эрхтэй зэрэг) вэ? гэдгийг тодруулах шаардлагатай бөгөөд энэ бүхнийг эдийн засгийн захиргааны эрх зүйгээр

тодорхойлох юм;


- Сүүлийн үед эдийн засгийн харилцааг зохицуулсан олон тооны нийтийн эрх зүйн хэм хэмжээ буюу хууль тогтоомжууд гарч байгаа тул тэдгээрийг системчлэх онол, арга зүйн үндсийг тодорхойлох шаардлагатай байна;

- Орчин үед эдийн засгийн мэдлэгтэй эрх зүйчид шаардлагатай байгаа тул энэ чиглэлээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх, үүний тулд эдийн засгийн захиргааны эрх зүйг салбар эрх зүйн хэмжээнд хөгжүүлэх, бие даасан хичээлийн судлагдахуун болгох хэрэгцээтэй байна.

Эдийн засгийн эрх зүй хэмээх ойлголтыг бий болгож, түүний тогтолцоог бүрдүүлэх нь төрөөс эдийн засгийн харилцаанд оролцох үндсэн зорилго, бодлого, зарчим, чиг үүрэг, арга, хэлбэр зэргийг тодорхойлох, нэгдсэн үзэл баримтлалтай болох, эрх зүй ба эдийн засгийн харилцан уялдаа холбоог хангах (тухайлбал, эрх зүйт төрийн зарчим, тэгш байх зарчим, төрийн социал бодлого нь эдийн засгийн онол, бодлоготой хэрхэн нийцэх вэ гэдгийг тодруулах), улмаар эрх зүйн бүтцийн харилцан хамаарлыг тогтоох, зөрчлийг арилгах зэрэг ач холбогдолтой юм.

◇◇◇◇◇ ◇◇◇◇◇ ◇◇◇◇◇

ШИНЭ НОМ



ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙ

Жилээс жилд олон улсын хувийн эрх зүйн харилцаа улам бүр өргөжиж, тэр хэрээр Монгол Улсын иргэд, хуулийн этгээд гадаад эдийн засаг, гэр бүл, өв залгамжлалын харилцаанд оролцох нь ихээхэн түгээмэл болж байна.

Энэхүү эмхтгэлд, олон улсын хувийн эрх зүйд хамаарах олон талт гэрээ, Инкотермс 2010, УНИДРУА-гийн олон улсын гэрээний зарчим, хобогдох Монгол Улсын хуулиудаас гадна хуульч, судлаачдын дунд ихээхэн эрэлт, хэрэгцээтэй байдаг хоёр талт эрх зүйн

харилцан туслалцааны гэрээг багтааснаараа онцлог юм.

Энэхүү эмхтгэл нь олон улсын хувийн эрх зүй, олон улсын бизнесийн эрх зүй судлаачид болон практик хуульчид, бизнес эрхлэгчид болон төрийн албан хаагчид, хувь иргэд ч ашиглахад зориулагдсан юм.

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат
хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит
илтгэлийн уралдаанд судлаачдын төрөлд
тэргүүлсэн илтгэл

Сонгуульд нргэд нийтээрээ оролцох зарчим ба хорих газар ял эдэлж байгаа хоригдлуудын сонгуулийн эрхийн асуудал

Отгонтэнгэр
их сургуулийн багш,
магистр (LLM)
Р.Очирбал



Угсаа залгамжлан засаглалын эрх барих явдлыг эгнэгт халсан улс орнууд засгийн эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй байх ардчиллын зарчмыг өөрийн улс орондоо төлөвшүүлэн хөгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа өнөө үед бүх нийтийн, чөлөөт, шууд, саналын нууцлалыг баталгаатай хангасан ардчилсан сонгууль чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид “Сонгуульд суралцахуй” хэмээх өөрийн бүтээлдээ “Шударга сонгууль гэдэг нь шууд ардчилал, Шууд ардчилал гэдэг нь ард түмний засаг, харин Ард түмний засаг гэдэг улсаа эзэгнэх ёс”¹ хэмээн тодорхойлноос үзэхүл сонгууль нь зөвхөн сонгох, сонгогдохын нэр бус харин ард түмний зүгээс өөрсдийн засаглалын эрх

¹ Чимид Б. Сонгуульд суралцахуй: тогтоцуу, цйл яву, эрх зүй Уб: 2008 он.

мэдлийг хэрэгжүүлэх онцгойрон шалгарсан үндсэн арга болой.

Харин иргэдийн хуулиар олгогдсон засаглалын эрх мэдлээ хэрэгжүүлэх бүрэн эрх, боломж болсон сонгох эрхийг хорих газар ял эдэлж байгаа гэх үндэслэлээр хуулиар хязгаарлах нь хүний үндсэн эрхэд үндэслэгдсэн эсэх, эрх зүйт ёсны үзэл санаанд нийцсэн эсэхийг тодорхойлох, ердэмтэн, судлаачдын анхаарал, судалгааг энэ чиглэлд хандуулах зорилгоор энэхүү нэгтгэлийг хэлэлцүүлж байна.

1. СОНГУУЛЬД ИРГЭД БҮХ НИЙТЭЭРЭЭ ОРОЛЦОХ ЗАРЧИМ

Английн хуульч, шүүгч Жеймс Физжеймс Стефен (1829-1894) "Эрх чөлөө, тусгаар тогтнол, эв нэгдэл" хэмээх номондоо "... Засаглалын хүчлэн зөвшөөрөгдсөн онолоор бол хүн болгон санааа өгөх эрхтэй. Энэхүү санааар төр сонгогдох ёстой"² хэмээн бичсэн бол НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн хуралдаанаас 1966 онд баталсан "Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт"-ын 25 дугаар зүйлд "Иргэн бүр аливаа алагчлагчийгээр болон үндэслэлгүй хязгаарлагдмал эрхээр төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөрөө уламжлан оролцох эрхтэй" хэмээн хуульчилжээ. Дээрхээс үзвэл хүн бүр сонгуульд оролцох улс төрийн үндсэн эрх, эрх чөлөөг эдлэх хэдий ч үндэслэл бүхий нөхцөлөөр сонгуулийн эрхэд хязгаарлалт тогтоож болохыг олон улсын хэм хэмжээгээр оролцогч улс орнуудад олгосон байна.

Сонгуульд иргэд бүх нийтээр оролцох зарчмын хязгаарлалтын асуудал нь дэлхийн түүхнээ өргөн цар хүрээтэй маргаан, мэтгэлцээнийг өдүүсэн, цаашид хүний үндсэн эрхийн агуулга, ач холбогдол гүнзгийрэн өргөжиж тусам онолын маргааныг бий болгох сонгуулийн эрх зүйн үндсэн асуудал болно. Тухайлбал, ардчиллын өлгий гэгдэх АНУ дахь сонгуульд иргэд бүх нийтээр оролцох эрхийг ханган баталгаажуулж байгаа өнөөгийн өндөрлөгөөс харахад түүхнээ хэд хэдэн үндэслэлээр сонгуулийн эрхэд хязгаарлалт тогтоон, шүүхийн хяналтаар тэдгээр нь Үндсэн хуулийн хэм хэмжээг зөрчсөн үндэслэлээр хүчингүй болж байжээ. Эдгээр нь дан ганц АНУ-ын хүрээнд үүссэн маргаан биш бөгөөд дэлхийн улс орнуудад нийтлэг үүссэн маргаан болохыг дурдах хэрэгтэй. Үүнд:

• Арс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлээр сонгуулийн эрхийг хязгаарлах - АНУ-ын Үндсэн хуульд 1869 онд оруулсан 15 дахь удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр "АНУ-ын иргэний сонгуулийн эрх нь арьс өнгө болон эд хөрөнгийн байдлаас хамааран хязгаарлагдах ёсгүй" хэмээн

² Дам ншлээ. Марк Платтнер. Либералчлалыг либерал ардчилал руу сэдэвт нэгтгэл. Ардчиллын чанар: Судалгааны өгүүллийн эмхтгэл, Уб: 2005 он.

зааснаар хар арьстнуудын сонгуулийн эрх хуульчлагдсан түүхтэй;³

• Хүйсээр ялгаварлан гадуурхах үзлээр сонгуулийн эрхийг хязгаарлах — XIX зууны сүүл үе хүртэл эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцаанд эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарлах хандлага дэлхийн улс орнуудад түгээмэл байлаа. Английн улс төр судлаач Жеймс Милл “Засаглалын тухай эссе” хэмээх бүтээлдээ “Сонгуульд оролцох эрхгүй хүмүүсийн ашиг сонирхол нь сонгуульд саналаа өгч байгаа хүмүүсийн ашиг сонирхолтой нэгдсэн гэж үзээд бүх нийтийн сонгуульд цөөн хүнийг хамруулж болно. Эмэгтэйчүүдийн саналыг аав нь юм уу, нөхөр нь илэрхийлж чаддаг хэмээн” үзээд эмэгтэйчүүдийг сонгуулийн эрхгүй байсныг тэрээр зөвтгөж байсан. Харин АНУ-ын Дээд шүүхээс 1886 онд сонгуулийн эрх нь иргэний бусад эрхийг хамгаалагч улс төрийн суурь эрх мөн болохыг зарлан тунхагласан хэдний ч 1920 онд Үндсэн хуульд оруулсан 19 дэх удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр эмэгтэйчүүдийн улс төрийн сонгуулийн эрхийг хүлээн зөвшөөрөх хүртэл эмэгтэйчүүд сонгох, сонгогдох эрх хязгаарлагдаж байсан.⁴ Үндсэндээ 1882-1990 он хүртэл эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийн хязгаарлалтын эсрэг улс орнуудад идэвхтэй өөрчлөлт хийсэн хувьсгалын он жилүүд байлаа;⁵

• Сонгуулийн татвар (Poll tax) — АНУ-ын Үндсэн хуульд 1962 онд оруулсан 24 дэх удаагийн нэмэлтээр Ерөнхийлөгчийн болон Конгрессын сонгуульд татварын шалтгаанаар хязгаарлах тогтоохыг хориглосон байна.⁶ АНУ-ын Вержины тойргийн сонгуулийн хорооны эсрэг Харперын өдүүлсэн (Annie E. Harper v. Virginia State Board of Elections) хэргийг шийдвэрлэсэн шүүхээс үзэхдээ “Үндсэн хууль бол сонгогчоос нэгэнтээ илэрхийлсэн саналыг хамгаалахад чиглэгдэхгүй харин сонгуулийн тэгш эрхийн баталгааг хангахад чиглэгдэх бөгөөд төр нь энэхүү чиглэмжийг заавал баримтлах ёстой. Нөгөөтэйгүүр эд хөрөнгө, сонгох эрхийн хооронд ямар нэг эрх зүйн хамаарал байхгүй учир сонгуулийн татвар нь Үндсэн хуулийн 14 дэх удаагийн нэмэлтийн заалтыг зөрчиж байна”⁷ хэмээжээ;

• Бичиг цсэг мэддэг эсэхийг харгалзан сонгуулийн эрхийг

³ John E. Nowak, Ronald D. Rotunda, Constitutional law, fourth edition, West Publishing co., St. Paul, Minn., 1991. 816.

⁴ Louis Fisher. American Constitutional law, McGraw-Hill publishing company, 1990. 1233.

⁵ Iceland (1882), New Zealand (1893), Australia (1895), Norway (1913), Denmark (1915), Austria (1918), First Czechoslovak Republic (1918), Second Polish Republic (1918), Netherlands (1919), Canada (1920), Sweden (1921), Republic of Ireland (1922), United Kingdom (1928), Brazil (1932), Spain (1933), France (1944), Jamaica (1944), Bulgaria (1945), Japan (1945), Chile (1949), India (1950), Greece (1952), South Africa (1994).

⁶ John E. Nowak, Ronald D. Rotunda, Constitutional law, fourth edition, West Publishing co., St. Paul, Minn., 1991. 1821.

⁷ 383 U.S. 663, 86 S. Ct. 1079, 16 L.Ed.2d 169 (1966) <http://hip.resource.org/courts.gov/cj/US/383/383US663.48.663.html>

хязгаарлах (Literacy test)³, хөгжлийн бэрхшээлтэй байдлаас хамааран сонгуулийн байранд ирэх боломжгүй шалтгаанаар сонгуулийн эрхийг хязгаарлах;

Хорих газар ял эдэлж байгаа цндэс.тэлээр сонгуулийн эрхийг хязгаарлах — 1990 оноос хойш сонгуулийн бүх нийтийн байх зарчимтай холбоотойгоор дэлхийн улс орнуудын үндэсний болон бүс нутгийн эрх зүйн зохицуулалтын хувьд маргаантай байгаа шинэлэг асуудал тул өөрийн улсын үндэсний эрх зүйн зохицуулалт болон гадаад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг тусгайлан авч үзье.

II. МОНГОЛ УЛС ДАХЬ ХОРИХ ГАЗАР ЯЛ ЭДЭЛЖ БАЙГАА ХОРИГДУУДЫН СОНГУУЛИЙН ЭРХИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн цндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно” хэмээн заасан бөгөөд сонгуульд иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд оролцох, иргэд саналаа нууцаар гаргах нь сонгуулийн үйл ажиллагааны үндсэн зарчим юм.

Хэдийгээр сонгуульд иргэд бүх нийтээр оролцох эрхтэй ч сонгуулийн нарийвчилсан хууль тогтоожид “Эрх зүйн чадамжгүй нь ишцхийн ишидвэрээр нотлогдсон, хорих газар ял эдэлж байгаа Монгол Улсын иргэд сонгуульд оролцох эрх эдлэхгүй” байхаар хязгаарласан зохицуулалттай байна. Нарийвчилбал, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “хорих газар ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “... хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй”, Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт “... хорих газар ял эдэлж байгаа иргэн сонгох эрх эдлэхгүй” хэмээн тус тус хуульчилжээ.

Монгол Улсын түүхэнд үйлчилж байсан сонгуулийн талаарх хууль

³ Literacy test гэх ойлголт нь цагаач ялангуяа хар арьстай хүмүүсийн сонгуулийн эрхийг хязгаарлах үр дүн бүхий арга хэрэгсэл байсан ч АНУ-ын эсрэг Гуйнны хэргийг (Guinn v. United States (1915)) шүүхээс шийдвэрлэхдээ бичиг үсэг тайлагдсан эсэх нь сонгуулийн хэрэгцээн дэлх ялгаварлал үүсгийн нэг хэлбэр тул Үндсэн хуулийг зөрчсөн болохыг зарлан тунхаглажээ.

John E. Nowak, Ronald D. Rotunda, Constitutional law, fourth edition, West Publishing co., St. Paul, Minn., 1991, 823.

тогтоомжид хорих газар ял эдэлж байгаа этгээдүүдийн эрхийн талаар зохицуулсан хэм хэмжээг түүвэр байдлаар харьцуулан судалж үзэхэд үндсэн 2 ялгамжит зохицуулалт илэрч байна. Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу.

1. 1924, 1960 оны Үндсэн хууль болон одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй сонгуулийн хууль тогтоомжид зааснаар Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, уг үйлдэлдээ хорих ялаар шийтгэгдсэн этгээдүүдийн хувьд сонгуулийн эрх нь автоматаар хязгаарлагдахаар заасан нь манай улс хорих газар ял эдэлж байгаа этгээдийн сонгуулийн эрхэд BLANKET BAN буюу бүхэлд нь хязгаарлалт тогтоодог дэлхийн улс орнуудад багтаж байна.

2. Харин 1940 оны Үндсэн хууль хүчин төгөлдөр үйлчилж байх үеийн Эрүүгийн хууль, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 74 дүгээр хурлын тогтоол болон БНМАУ-ын аймаг, хот, сум, дүүрэг, хороо, баг, хорины хөдөлмөрчдийн депутатуудын хурлын сонгууль явуулах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигт зааснаар хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн сонгуулийн эрх хязгаарлагдах эсэх нь шүүхийн шийдвэрээс ихээхэн хамаарахаар байжээ. Өөрөөр хэлбэл энэ үед сонгох, сонгогдох эрхийг хасах нь эрүүгийн хариуцлагын ялын нэмэлт төрөлд хамаарч байсан бөгөөд эдүгээ энэ загварыг ХБНГУ, Франц, Грек зэрэг улс орон хэрэглэж байна.

Америкийн эрх зүйн тогтолцооноос үүдэлтэй "*of laws and not of men*" буюу хүний баталсан хууль бус эрх зүйн үнэт чанарыг дээдлэх эрх зүйн үзэл санаа, түүнчлэн *fundamental human right* буюу хүний үндсэн, суурь эрхийг хүндэтгэн үзэх орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний үүднээс манай улсын сонгуулийн хууль дахь хорих газар ял эдэлж байгаа этгээдийн сонгуулийн эрхийн хязгаарлалт нь үндэслэлтэй эсэхийг онолын хувьд хөндөн авч үзэх нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа хорих газар ял эдэлж байгаа мянга мянган хоригдлын Үндсэн хуулиар олгосон улс төрийн цөм болсон эрхийн тухай асуудал болно.

III. ХОРИХ ГАЗАР ЯЛ ЭДЭЛЖ БАЙГАА ЭТГЭЭДИЙН СОНГОХ ЭРХИЙН ТАЛААРХ ГАДААД УЛС, ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сэдвийн хүрээнд бичигдсэн гадаадын эрдэмтэн, судлаачдын бүтээл, судалгааны байгууллагын тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийсний үр дүнд илтгэгчийн зүгээс улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг үндсэн гурван бүлэгт хуваан авч үзлээ. Үүнд:

1. Хорих газар ял эдэлж байгаа этгээдүүдийн сонгуулийн эрхийг хуулиар шууд хязгаарладаг улс орнууд;

2. Хорих ял эдэлж байгаа этгээдийн үйлдсэн хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хөнгөн, хүндийг харгалзан сонгуулийн эрхийг хязгаарлах эсэхийг хуулиар тусгайлан болон шүүхийн журмаар тогтоодог улс орнууд;

3. Хорих ял эдэлж байгаа эсэхээс үл хамааран сонгуулийн эрхийг тухайн улсын бүхий л иргэн баталгаатай эдэлдэг улс орнууд гэх зэрэг болно.

Английн төлөөлөгдчийн танхим (*House of Commons*)-ыг шаардлагатай мэдээллээр хангах чиг үүрэг бүхий Парламент болон Үндсэн Хуулийн Төв (*Parliament and Constitution centre*)-өөс гаргасан 2011 оны албан ёсны судалгаанд бичсэнээр⁹ ОХУ, Болгар, Эстони, Гүрж, Унгар, Лихтенштейн, Англи зэрэг улс оронд хоригдлуудын сонгуулийн эрхийг хуулиар шууд хязгаарладаг бол Андора, Австри¹⁰, Бельги¹¹, Франц¹², Герман¹³, Грек, Итали¹⁴, Люксембург, Нидерланд, Норвеги, Польш, Португаль, Румин, Турк зэрэг улс оронд зарим төрлийн хоригдлуудын сонгуулийн эрхэд хязгаарлалт тогтоодог, харин Чех¹⁵, Латви, Серби зэрэг улсад ямар байгууллагыг сонгууль эсэхээс хамааран сонгуулийн эрхийг хязгаарладаг байна. Албани, Харват, Бүгд Найрамдах Кибр Улс¹⁶, Дани, Финланд, Исланд, Ирланд¹⁷, Македон, Молдав, Серби,

⁹ *Prisoner's voting right*, Standard note, SN/PC, 01764, 7 September 2011, www.parliament.uk/documents/commons/lib/research/briefings/snpc-01764.pdf

¹⁰ Тус улсад сонгуулийн хууль зөрчиж хорих ял шийтгэгдсэнээс бусад хоригдол сонгууль өгөх эрхтэй. 2010 онд Австрийн эсрэг Фродльм мээүүлсэн (Helmut Frolid v. Austria) хэрэгтэй холбогдуулан Европын Хүний эрхийн шүүхээс тус улсад 1 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэгдсэн хоригдлын сонгуулийн эрхийг хуулиар хязгаарласныг Хүний эрх, Үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн I протоколын 3 дэх заалтыг зөрсөн гэх үндэслэлээр хүчингүй болгосон. European Court of Human right, Judgment, Strasbourg, 08 April 2010, Application no.20201/04 www.menschenrechte.at

¹¹ Бельги Улс 2009 он хүртэл хоригдлын сонгуулийн эрхийг хуулиар шууд хязгаарладаг байсныг өөрчлөх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж байдлыг харгалзан шүүхээс тухайн хорих ялаар шийтгэгдэх этгээдийн сонгуулийн эрхийг хязгаарлах эсэхийг шийдвэртээ тухайлан заадаг байхаар өөрчилсөн.

¹² 1994 оноос эхлэн хоригдлуудын сонгуулийн эрхийг автоматаар хязгаарладаг зохицуулалта хүчингүй болгосон бөгөөд сонгуулийн эрхийг хасах эсэхийг шүүхээс шийдвэрлэдэг. Зарим төрлийн гэмт хэрг тухайлбал, төрийн болон нийтийн захиргааны эсрэг гэмт хэрг үйлдсэн этгээдүүдийн сонгуулийн эрх нь автоматаар хязгаарлагддаг.

¹³ Франц, Грек зэрэг улстай адил хоригдлын сонгуулийн эрхэд хуулиар автоматаар хязгаарлалт тогтоодоггүй бөгөөд төлөөлөх төрлийн онц нөхцөл гэмт хэрг үйлдсэн этгээдийн сонгуулийн эрхийг хязгаарлах эсэхийг шүүх нэмэлт шийтгэлийн төрөл болгон хэрэглэдэг. Дам ишлэв. Alec C. Ewald Articles, Civil Death: The Ideological Paradox of Criminal Disenfranchisement Law in the United States. <http://subek.colorado.edu/~preuhs/state/ewaldcivildeath.pdf>.

¹⁴ Итали Улсад 5 ба түүнээс дээш жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн этгээдүүдийн сонгуулийн эрх нь хязгаарлагддаг.

¹⁵ Чех Улсын хуулиар хоригдлууд нь Чехийн Парламент болон Европын Парламентын сонгуульд саналаа мөх эрхтэй бол орон нутгийн болон хотын сонгуульд саналаа өгөх эрхгүй байлаар хуульчилжээ.

¹⁶ Тус улс 2006 он хүртэл хоригдлуудын сонгуулийн эрхийг хуулиар шууд хязгаарладаг зохицуулалта өөрчилсөн бөгөөд эдүгээ бүх хоригдол сонгууль өгөх эрхтэй.

¹⁷ 2006 оны хуулиар хоригдлууд нь өөрийн байнга оршин суудаг байсан газрынхаа сонгуулийн хэсэгт

Словян, Испани, Швед, Швейцари зэрэг европын улс ороны хуулиар хорих газар ял эдэлж байгаа этгээд нь сонгуульд чөлөөтэй оролцох эрхтэй байна. (Энэхүү судалгаа нь европын улс орнуудын түвшинд хийсэн судалгаа болно.)

Дэлхийн улс орнуудаас хоригдлуудын сонгуулийн эрхийн асуудлаар хамгийн маргаантай байгаа улс бол Англи юм. Тус улсын 1870 онд батлагдсан Хариуцлагын хууль (*Forfeiture Act*)-нар гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд нь иргэний зарим эрхээ алдахаар зохицуулсан бол 1983 онд батлагдсан Иргэдийн төлөөллийн тухай хууль (*Representation of the People Act*)-д хорих ял эдэлж байгаа иргэд сонгох эрхгүй болохыг хуульчилсан. 2004 онд Английн хорих газар ял эдэлж байгаа 3 хоригдол сонгуулийн эрхэд хязгаарлалт тогтоосон одоогийн хуулийн зохицуулалт нь хууль бус, үндэслэлгүй болохыг тогтоолохоор Дээд шүүхэд зарга мэдүүлсэн нь хожим Европын Хүний Эрхийн шүүхээс Английн үндэсний эрх зүйн зохицуулалт үндэслэлтэй эсэхийг тогтооход хүргэсэн юм. (*Pearson & Martinez v. Home secretary and others*), (*John Hirst v. Attorney General*). Харин Английн Дээд шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ "Ардчилсан улс орнуудад хоригдлуудын сонгуулийн эрхийн асуудалд өргөн цар хүрээтэй өөрчлөлт гарч байна. Одоогийн хуулийн зохицуулалт ирээдүйд өөрчлөгдөж болох хэдий ч энэ нь шүүхийн эрхэд хамаарах асуудал биш парламентын эрхийн асуудал"¹⁸ хэмээн үзсэнийг зарга өдүүлсэн Жон Хирст эс хүлээн зөвшөөрч Европын Хүний эрхийн шүүхэд давж заалдах гомдол гаргасан байна. Европын хүний эрхийн шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ Англи Улс хоригдлуудын сонгуулийн эрхэд үнэмлэхүйн хязгаарлалт тогтоосон нь Хүний эрх, Үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн I протоколын 3 дахь хэсгийн иргэд саналаа чөлөөтэй илэрхийлэх, нууцаар санал өгөх, чөлөөт сонгуулийн талаарх заалтыг зөрчсөн бөгөөд "хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн эрх чөлөө хязгаарлагдах хэдий ч энэ нь конвенцоор хамгаалагдсан иргэний бусад үндсэн эрхийг хасах үндэслэл болохгүй. Энэ бол ардчилсан тогтолцооны салгаж боломгүй суурь үндэс болно"¹⁹ хэмээн өөрийн шийдвэртээ бичжээ.

Английн Засгийн газараас Европын Хүний Эрхийн шүүхийн шийдвэрийг хянуулахаар тус шүүхийн дээд танхимд давж заалдсан ч амжилтанд хүрээгүй нь эцэстээ Англи Улс Хүний эрх, Үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн гишүүн улсаар цаашид байх

шуудангаар сонгууль өгөх эрхтэй байлаар хуучимжсан.

¹⁸ England and Wales High Court (Administrative court) Decisions (4th April 2001).

¹⁹ European Court of Human Right (30 March 2004). Judgment in the Case of John Hirst v. The United Kingdom (No2) (Application no.74025/01).

эсэх асуудлыг хөндөхөд хүргэж байна. Английн парламентын гишүүн асан Доминик Гривс хэлсэн үгэндээ "Англи Улс Европын хүний эрхийн конвенцийг баталсан хамгийн анхны улс бөгөөд конвенцоос гарсан анхны улс болохгүй" хэмээгээд улс үндэстний дотоодын хуулийн зохицуулалтыг конвенцийн заалтаас илүү хүчирхэг болгох саналтай байгаагаа илэрхийлсэн байна. Тэрээр цааш хэлэхдээ "Хэдийгээр Англи Улс конвенцийн оролцогч улс болохын хувьд Страсбургийн шүүхэд хариуцагч байх хэдий ч Европын Хүний Эрхийн шүүхээс чндэсний шүүхээр нэгэнтээ шийдвэрлэгдсэн асуудалд хөндлөнгөөс нөлөөлөлт үзүүлж байгааг буруутгасан байна."²⁰

Хэдийгээр Англи Улс Европын Хүний Эрхийн шүүхийн шийдвэрт тааламжтай хандаагүй ч уг шүүхийн шийдвэрт нийцүүлэн дотоодын хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах олон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2011 оны хавар Засгийн газар 4 хүртэлх жилээр хорих ялаар шийтгэгдсэн этгээдүүдийн сонгуулийн эрхийг хүлээн зөвшөөрөхөөр шийдвэрлэсэн ч энэ хугацааг 1 жил болгон бууруулахаар санал, санаачилга гарч байна.²¹ Харин дээрх хоригдлууд зөвхөн Английн болон Европын парламентын сонгуульд санал өгөх эсэх эсхүл орон нутгийн бусад сонгууль болон ард нийтийн санал асуулгад оролцох эсэхийг нэг мөр шийдээгүй байна. Учир нь Европын Хүний Эрхийн шүүхийн шийдвэрээр Англи Улс дахь BLANKET BAN буюу үнэмлэхүйн хязгаарлалт нь конвенцийн заалтыг зөрчсөн хэмээн үзсэн. Хэрэв үнэмлэхүйн хязгаарлалтыг Англи Улс өөрчлөөгүй тохиолдолд хоригдлуудын эрхийг хязгаарласан нөхөн төлбөр болгон 70000-80000 хоригдолд нийт 160 сая паундыг улс хариуцахаар Европын Хүний Эрхийн шүүх шийдвэрлэсэн.²² Харин Английн Ерөнхий сайд Давид Камерун "Страсбургийн шүүх Английн Засгийн газрыг нөхөн төлбөрийг шаардах эрхгүй" хэмээн албан ёсоор мэдэгдээд байгаа юм.²³

Хоригдлуудын сонгуулийн эрхийн асуудалд нэлээд амжилт олсон улсуудад Канад, Австрали, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс зэрэг улс зүй ёсоор багтана.

1902 онд батлагдсан Австралийн Сонгуулийн тухай холбооны хуулийн 44.11.4-т "Эх орноосоо урвах гэмт хэрэг үйлдсэн эсхүл 1 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн этгээд сонгуульд санал өгөх эрхгүй"²⁴ хэмээн заасан бол 1995 онд нэмэлт, өөрчлөлт оруулан 5 болон

²⁰ Owen Bowcott, legal affairs correspondent, *Attorney general aims to limit European power over English law*, 24 October 2011, www.guardian.co.uk

²¹ James Landale, Deputy political editor of BBC news, *Prisoners vote law: covers Scotland and Welsh elections*.

²² Prisoners take coalition to European court over breach of voting right (article), www.guardian.co.uk

²³ Cameron is clear to defy Europe on human right, Times, 18 February 2011.

²⁴ The Commonwealth Franchise Act, 1902.

түүнээс дээш жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн этгээдүүд санал өгөхгүй байхаар хуульчилж, харин 2004 онд хязгаарлалтыг 3 жил, түүнээс дээш болгон өөрчилсөн бол 2006 онд хорих ял эдэлж байгаа бүхий л хоригдлуудын Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын сонгуулийн эрхийг хязгаарласан байна.²⁵ Энэхүү хязгаарлалт нь үндэслэлтэй эсэхийг 2007 онд Роучийн мэдүүлсэн Сонгуулийн хорооны эсрэг хэргийг (*Rouch v. Electoral Commissioner*) Австралийн Дээд шүүх шийдвэрлээд хүчингүй болгосон бөгөөд 2004 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилж байна.

Одоогоор Австрали Улс хорих ялын хэмжээнээс хамааран хоригдлын сонгуульд санал өгөх эрхийг хязгаарлаж байна. (*Commonwealth* – 3 жил түүнээс дээш, *New South Wales* – 1 жил ба түүнээс дээш, *Victoria* – 5 жил ба түүнээс дээш, *Queensland* – хорих ял эдэлж байгаа бүхий л иргэн санал өгөх эрхгүй, *Western Australia* – 1 жил ба түүнээс дээш, *South Australia* – хязгаарлагдмт байхгүй, *Tasmania* – 3 ба түүнээс дээш жил, *ACT* – хязгаарлагдмт байхгүй, *NT* – 3 ба түүнээс дээш жил)²⁶

Канад Улсын Дээд шүүхээс 1992 онд Саувений өдүүлсэн Канадын эсрэг маргааныг (*Sauv'y v. Canada*) шийдвэрлээд хорих ял эдэлж байгаа иргэдийн сонгуулийн эрхийг хязгаарласан хуулийн заалт нь Канадын Эрх, Эрх Чөлөөний Тунхаг бичгийг зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгосон бөгөөд хэргийг шийдвэрлэсэн шүүгч Маклаклин хэлэхдээ “Канадын ардчиллын амин зүрх болсон сонгуулийн эрх нь гагцхүү зайлшгүй шалтгаанаар хязгаарлагдана. Харин засгийн газрын хязгаарлагдмтын үндэслэл нь хангалтгүй байна”²⁷ хэмээжээ. Дээрх Дээд шүүхийн шийдвэрийн дагуу 2 ба түүнээс жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэнээс бусад Канад Улсын иргэд сонгуульд санал өгөх эрхтэй байхаар хуульчилжээ.

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Насанд хүрсэн иргэн бүр Үндсэн хуульд заасан хугацаагаар хууль тогтоох байгуулагыг сонгох сонгуульд санал өгөх эрхтэй” хэмээн заасан бөгөөд Үндсэн хуулийн 36 дугаар зүйлд хүний эрхийн хязгаарлалт нь нээлттэй, ардчилсан нийгэм дэх хүний нэр төр, эрх тэгш байдал, эрх чөлөө болон бусад үнэт зүйлсэд нийцсэн, үндэслэл бүхий, хууль ёсны байна хэмээн заажээ. Энэхүү зарчмын дагуу 2004 онд

²⁵ Lisa Hill, University of Adelaide, *Prisoner voting right*, Symposium: Protecting Human Rights in Australia: Challenge and Strategies, November 2009.

²⁶ Lisa Hill, University of Adelaide, *Prisoner voting right*, Symposium: Protecting Human Rights in Australia: Challenge and Strategies, November 2009.

²⁷ Daniel Guttman, *Before the High Court*, *Roach v. Commonwealth: Is the Blanket Disfranchisement of Convicted Prisoners Unconstitutional?*, *Sidney Law Review*, vol.29:297.

Үндсэн хуулийн шүүхээс Хууль зүйн яам болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх Үндэсний төвийн хоорондын маргааныг шийдвэрлээд хорих ял эдэлж байгаа этгээдийн сонгуулийн эрх хуулиар хязгаарласан байсныг хүчингүй болгожээ.²⁸ Африкийн Засгийн газраас хорих ял эдэлж байгаа этгээдүүдийн сонгуулийн эрхийг хязгаарлах үндэслэлээ учир шалтгаан болон санхүүгийн нөөцтэй холбон тайлбарласан нь ихээхэн онцлог хэмээн судлаачид үзэж байна. Засгийн газраас нийгмийн бүхий л социаль бүлэглэлд тохирсон сонгуулийн тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн нөөц бололцоо байхгүйг онцлоод үүний оронд хөгжлийн бэрхшээлтэй эсхүл сонгогчийн саналыг хуудсанд бүртгэгдэж чадахгүй байгаа иргэдийн сонгуулийн эрхийг хангахад санхүүжилт олгох нь зүйтэй хэмээн мэдэгдсэн байна.²⁹

Харин Америкийн Нэгдсэн Улсын хувьд хоригдлуудын сонгуулийн эрхийн асуудлаас гадна цагдан хоригдож байгаа этгээд, хорих ялаа биеэр эдэлж дуусаад нийгэмдээ чөлөөтэй ажиллаж, амьдарч байгаа этгээдүүдийн сонгуулийн эрхийг хэрхэн хангах тухай асуудал маргаантай хэвээр байна. Угтаа АНУ дахь энэ төрлийн асуудал нь агуулга, хүрээний хувьд Европын улс орнуудаас ихээхэн ялгаатай байгааг тэмдэглэх хэрэгтэй. 2006 онд АНУ-д 5.3 сая гаруй сонгуулийн насны иргэд буюу 41 иргэн тутмын 1 иргэний сонгох эрх гэмт хэрэгтэй холбогдох шалтгаанаар хязгаарлагдсан байна. Эдгээрээс 74 орчим хувь нь хорих ялаа эдэлж дууссан, нийгэмдээ чөлөөтэй амьдарч байгаа иргэд гэсэн судалгаа гарчээ.³⁰ АНУ дахь энэхүү хязгаарлалт цаашид оршин байх эсэх нь нэгж хүний эрхэд суурьлагдсан хувийн үзлийг илүүтэйд үзэх Либерализмыг хөгжүүлэх үү? эсхүл нийтийн ашиг сонирхлыг илүүтэйд эрхэмлэх сэтгэлгээг хөгжлийн түүхчээ болгох уу? гэдгээс хамаарна хэмээн Америкийн судлаачид үзжээ.³¹ АНУ-ын муж улсуудын хоригдлуудын эрх зүйн зохицуулалтад гарч буй өөрчлөлтөнд дүн шинжилгээ хийж үзвэл нийтийн эрх ашгийг харгалзан гэмт этгээдүүдийн сонгуулийн эрхийг хязгаарлах үзэл санаа шүүмжлэлд өртөх хандлагатай байна. Одоогоор АНУ-ын Майн, Вэрмонт муж улсууд хорих газар ял эдэлж байгаа этгээдүүдийн сонгуулийн эрхийг хүлээн зөвшөөрсөн бол Юта болон Массачусеттс мужууд 1998, 2000 он хүртэл хүлээн зөвшөөрч байсан зохицуулалтаа хүчингүй болгосон. Харин Алабама, Флорида, Иова.

²⁸ Minister of Home Affairs v. National Institution for Crime Prevention and the Re-Integration of offenders (NICRO) and others /2004/, 5 BCLR 445 (CC).

²⁹ Lisa Hill, University of Adelaide, *Prisoner voting right*, Symposium: Protecting Human Rights in Australia: Challenge and Strategies, November 2009.

³⁰ The sentencing project, *Federal Voting Rights for People returning from Prison*, www.sentencingproject.org

³¹ Alec C. Ewald, *Civil death: The Ideological Paradox of Criminal Disfranchisement Law in the United States*, Wisconsin Law review, 1050.

Миссисиппи, Невада, Вержин зэрэг мужид хоригдлын сонгуулийн эрх автоматаар хязгаарлагддаг бол Делевар мужид хүн амины гэмт хэрэг, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлснээс бусад хоригдол ялаа эдэлж дууссанаас хойш 5 жилийн дараа түүний сонгуулийн эрх сэргээгддэг. Алайска, Арканзас, Жироржия, Миссури, Небраска, Нью Жерси, Нью Мексик, Хойд Каролина, Оклахама, Зүүн Вержин зэрэг мужид хорих ял эдэлж байгаа, ял тэнссэн болон хугацаанаас өмнө суллагдсан этгээдүүдийн сонгуулийн эрх хязгаарлагддаг байна.

Хорих газар ял эдэлж байгаа этгээдүүдийн сонгуулийн эрхийг хязгаарлаж байгаа үндэслэл:

• Гэмт хэрэгтэн этгээд зарим төрийн харилцаанд субъект байх шинжээ алдана (Civic /civil / deal) Эртний Грекэд “Шившиит этгээд” (pronounced infamous) хэмээн зарлагдсан гэмт этгээдийн шүүхэд зарга мэдүүлэх, хуралдаанд санал өгөх, олон нийтийн өмнө үг хэлэх, хувийн эд хөрөнгийг хааны сан хөмрөгт хураан хуримтлуулах зэргээр эрхийг хязгаарладаг байсан нь хожим европын улс орнуудад civic death гэсэн зарчим болтлоо хөгжсөн байна. Зарчмын агуулгыг эрдэмтэд тайлбарлахаа “dead in law” буюу бодьгал биеийн хувьд амьд боловч эрх зүйн хувьд эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцаанд үхсэн этгээдтэй адил хэмээн үздэг. Харин орчин үед энэ зарчмын агуулгыг нийгмийн гэрээний онолын үзэл санаатай холбон тайлбарлаж, хүний үндсэн суурь эрхийн үзэл санаагаар буруутган шүүмжилж байна;

• Нийгмийн гэрээний онол (social contract theory)-Нийгмийн гишүүдээс тогтоосон гэрээг зөрчиж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сонгуулийн эрхийг хязгаарлах талаарх үзэл санаа дэлхийн улс орнуудад түгээмэл байна. Жон Локкын бичсэнчлэн хэн ч бусдын амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө болон эд хөрөнгөд халдах эрхгүй³² бөгөөд гайхалшигтай эхлэлийг агуу төгсгөлөөр дуусгаж аюулгүй байдлыг хангахын тулд хүн бүр эрх ашгаараа нэгдэж³³ хууль зөрчсөн этгээдийг шийтгэх эрхийг төрд олгох нь зүйд нийцнэ. Түүнийхээр, хэрэв хэн нэгэн этгээд гэмт хэрэг үйлдэв түүнийг улс төрийн харилцаанд оролцох эрхийг хасах хэрэгтэй аж. Нийгмийн гэрээний онолыг баримтлагч Жан Жак Руссоу Локкын дэвшүүлсэн дээрх саналыг дэмжин өгүүлэхдээ “Нийгмийн эрхэд халдсан хэн боловч өөрийн хийсэн хууль бус үйлдлээрээ эх орноосоо урвасан гэм буруутан болох тул тэрээр нийгмийн гишүүн

³² Дам ншлов Locke, supra note 15, §6, at 9 Alec C. Ewald, Civil death: The Ideological Paradox of Criminal Disenfranchisement Law in the United States, Wisconsin Law review, 1072.

³³ Дам ншлов Id §124, at 66 Alec C. Ewald, Civil death: The Ideological Paradox of Criminal Disenfranchisement Law in the United States, Wisconsin Law review, 1072.

байх эрхгүй".³⁴ Түүнчлэн Томас Пайнс "Миний хэрэгжүүлж байгаа эрх бусад этгээдтэй харилцах харилцаанд цэрэг болох тул гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сонгуулийн эрхийг хязгаарлаж болно" хэмээн хэлснийг тэмдэглэх нь зүйтэй. Нийгмийн гэрээний онолын үзэл санааг баримтлагч дээрх эрдэмтдийн онол, сургаалийг эдүгээ хоригдлуудын сонгуулийн эрхийн хязгаарлалт үндэслэлтэй болохыг нотлоход улс төрчид, судлаачид чиглэмж болгож байна. Тухайлбал, Английн Ерөнхий сайд Давид Камерун "... хоригдлуудад сонгуулийн эрхийг олгох талаарх асуудал нь цнэндээ сэтгэл санааны дарамтыг бий болгож байна. Хэн нэгэн этгээд нийгмийн эсрэг гэмт хэрэг үйлдвэл тэрээр ардчилсан нийгмийн нэгээхэн хэсэг байх эрхээ алдана."³⁵ Австралийн Парламентын сенатор Эрик Абетц "Нийгмийн гишүүдийн эсрэг үйл ажиллагаа явуулж хууль зөрчсөн иргэн ирээдүйн хөгжлийн төлөө дуу хоолойгоо хүргэх эрхгүй"³⁶, хэрэв чи гудамжаар чөлөөтэй явах эрхгүй нэгэн тохиолдолд, мөн сонгуульд чөлөөтэй оролцох эрхгүй"³⁷, Английн Парламентын гишүүн асан Доминик Грисв "Хоригдлуудад сонгох эрх олгох нь утгагүй зүйл. Учир нь тэд хууль зөрчсөнөөрөө сонгуулийн эрхээ алдах бөгөөд нийгмийн цүргээ биелүүлэх хүртэлх хугацаанд энэхүү хязгаарлалт үйлчилнэ."³⁸ 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Англи Улсын улс төрчдийн дунд зохион байгуулагдсан Backbench нээлттэй мэтгэлцээнд Английн Парламентын гишүүн Дэвид Давис "Хоригдлууд хуульд заасан эрхтэй. Мэдээж жирийн Английн иргэдтэй харьцуулахад тэдний эрхийн хүрээ адилгүй. Учир нь хэрэв чи хууль зөрчөөл, хууль батлах эрхгүй. Нийгэмтэй байгуулсан гэрээгээ зөрчсөн нь тэрээр эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон сонгох эрхээ алдана гэсэн цг юм"³⁹.

• Сонгуулийн эрхийг хязгаарлах нь нэмэлт шийтгэл болно (Additional punishment)-Герман, Франц, Грек зэрэг улсад сонгуулийн эрхийг хязгаарлахыг нэмэлт шийтгэл болгон хэрэглэдэг талаар судлаачид тэмдэглэсэн нь цөөнгүй байна. Нөгөөтэйгүүр, Канад, Австрали, Андорра, Австри, Бельги, Ирланд, Нидерланд, Норвеги зэрэг улс орон гэмт хэргийн хүнд, хөнгөн, гэмт хэргтэнд оногдуулсан хорих ялын хэмжээг

³⁴ Дам ншлэн. Jean-Jacques Rousseau, Basic Political Writings. Alec C. Ewald, Civil death: The Ideological Paradox of Criminal Disenfranchisement Law in the United States, Wisconsin Law review, 1072.

³⁵ Kevin McKenna, Stop prisoners from voting? That's criminal, 3 April 2011, www.guardian.co.uk

³⁶ Lisa Hill, University of Adelaide, Prisoner voting right, Symposium: Protecting Human Rights in Australia: Challenge and Strategies, November 2009.

³⁷ Дам ншлэн. Daniel Guttman, Before the High Court, Roach v. Commonwealth: Is the Blanket Disenfranchisement of Convicted Prisoners Unconstitutional?, Sidney Law Review, vol.29, 317.

³⁸ Melanie Phillips, Cameron fumes and postures over the European Court of Human Rights. So why won't he stand up to it over votes for prisoners?, 4 November 2010, www.guardian.co.uk

³⁹ HC Deb 10 February 2011 c494.

харгалзан хуулиар сонгуулийн эрхийг хязгаарлаж байгааг нийгмийн зүгээс ногдуулсан нэмэлт шийтгэл хэмээн үзэж байна. Английн Ял Шийтгэлийн Шинэтгэлийн хорооны дарга Францес Крук, Консерватив Жонатан Айткентай хийсэн нүүр тулсан мэтгэлцээнд хэлэхдээ “Сонгууль бол сонгуулийн эрхээ хязгаарлуулсан хүмүүст ч нэгэн адил чухал хэдий ч бид тэдэнд иргэн хүн ямар бийх, сонгуулийн эрх ямар чнэ цэнэтэй болохыг харуулах ёстой”⁴⁰ гэсэн бол Канадын эрдэмтэн Ж.Гонтнер “хүнд, ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдчдийн сонгуулийн эрхийг хязгаарласнаар тухайн гэмт хэрэгтэн болон нийгмийн бусад гишүүнд гэмт хэрэг үйлдсэнээр бий болох үр дагаврын талаарх мэдээллийг хүргэж байна”⁴¹

Гэсэн хэдий ч Европын Хүний Эрхийн шүүх, Канадын Дээд шүүхээс сонгуулийн эрхийг хязгаарлах нь Эрүүгийн эрх зүйн тохиромжит хариуцлагын төрөл биш болохыг шийдвэртээ онцлон заасныг анхааран үзэх шаардлагатай. Тухайлбал, Европын Хүний Эрхийн шүүхээс Английн эсрэг Жон Хирстын мэдүүлсэн хэргийг шийдвэрлэсэн шийдвэртээ “Засгийн газраас хоригдлын сонгуулийн эрхийг хасах нь түүний ялын нэгдэхэн хэсэг хэмээн үзэж байна. Үнэндээ эрүүгийн хариуцлага нь хязгаарлагдсан эрх чөлөөнөөс бусад үндсэн эрхийн хувьд хязгаарлагдмал тогтоох үндэслэл болохгүй”⁴² хэмээн бичжээ.

Хорих газар ял эдэлж байгаа этгээдүүдийн сонгуулийн эрхийн хязгаарлалтыг үгүйсгэх үндэслэл:

• Сонгох эрх нь улс төрийн үндсэн суурь эрх (political fundamental right): Хүний эрхийн хязгаарлалт нь үндэслэл бүхий бөгөөд засаглалын хууль ёсны зорилгод нийцсэн байх ёстойг хүний эрхийн судлаачид санал нэгтэй номлодог. Засаглалын гол зорилго бол төлөөллийн тогтолцооны идэвхтэй ажиллагааг хангахад чиглэгдэх бөгөөд Австралийн Дээд шүүхээс Малхолландын өдүүлсэн сонгуулийн комиссын эсрэг хэргийг шийдвэрлэхдээ “Сонгох эрх нь улс төрийн илэрхийллийн дээд хэлбэр бөгөөд энэхүү эрхийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах нь Үндсэн хуулийн эсрэг үйлдэл” хэмээн үзжээ. Үндсэн эрхийн талаарх үндэслэл нь хоригдлын сонгох эрхийг нийгмийн гэрээний онолын үзэл санаагаар хязгаарлах үзэлтэй өрсөлдөхүйц үндэслэл бөгөөд эрдэмтэдийн дунд хүний үндсэн, суурь эрхийг нийгмийн гэрээгээр хязгаарлах нь үндэслэл бүхий эсэхэд онолын маргаантай байна. Тухайлбал, Канадын Дээд шүүхээс Сауегнийн мэдүүлсэн хэргийг шийдвэрлэхдээ “Нийгмийн гэрээг зөрчсөн

⁴⁰ Interview by Emine Sancer, *Should prisoners be allowed to vote?*, 23 April 2011, www.guardian.co.uk

⁴¹ Sauvy (No2) [2002] 3 SCR 519 at [159] (Gonthier J)

⁴² Hirst (No2) (application no.74025/01) (2005) ECHR 74025/01 (Grand chamber) at [45]

нь хоригдлын сонгуулийн эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Өөрөөр хэлбэл хуулийг даган биелүүлэхгүй явдал нь улс төрийн хариуцаанд түүний эрхийг тэтгэх үндэслэл болохгүй”⁴¹ хэмээн үзсэн.

“Хорих” ялаар шийтгэгдсэн этгээдүүдийг нийгэмшүүлэх зорилгод харш (promotion of civic responsibility)-Канадын Дээд шүүхийн шүүгч Маклакины хэлснээр эрх зүйн хууль ёсны байдал, хуульд захирагдах ойлголт нь иргэдийн сонгуулийн эрхээс шууд үүдэлтэй тул хоригдлуудын сонгуулийн эрхийг хязгаарлах нь тэднийг ардчиллын үнэт зүйлсэд дастан журамлах болон нийгмийн үүрэг хариуцлагыг ойлгуулах зорилгод харшиж байгааг онцлон тэмдэглэсэн байна. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч Ж.Мадала хоригдлуудын сонгуулийн эрхийг хязгаарласан хуулийн заалт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг шийдвэрлэсэнтэй холбогдуулаад хэлсэн үгэндээ “Хоригдлуудад сонгуулийн эрхийг олгох нь тэдний нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хөгжүүлэхэд ихээхэн ашигтай. Хэдийгээр тэд сонгуулийн эрхээ хязгаарлуулсан хэдий ч алдаатай хуулийн улмаас эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байснаа хожим мэдэх болно.”⁴² хэмээжээ.

ДҮГНЭЛТ

Хүний эрхийн агуулга, хүрээ дэлхийн түвшинд өргөжин тэлж буй өнөөгийн нөхцөлд үндэслэл бүхий хязгаарлалт хэмээн тооцогдож байсан зүйл, хүний эрхийн зөрчил болох тохиолдол олонтаа тохиолдож байна. Үүний нэгэн илрэл нь хорих газар ял эдэлж байгаа иргэдийн сонгуулийн эрхийг хуулиар хязгаарлаж байгаа явдал юм.

Манай улсын түүхэнд үйлчилж байсан, эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа сонгуулийн хууль тогтоомжид хорих газар ял эдэлж байгаа этгээд сонгуульд санал өгөх эрхгүй байхаар хуульчилсан ч энэхүү хязгаарлалт нь хүний үндсэн эрхийн шаардлагад нийцсэн эсэхийг онолын талаас нь судлан үзэх шаардлагатай байна. 1924 оноос өнөөг хүртэлх сонгуулийн зарим хууль тогтоомжид судалгаа хийхэд Монгол Улс түүхнээ хорих газар ял эдэлж байгаа этгээдийн сонгуулийн эрхэд хоёр төрлийн үндсэн хязгаарлалтын арга хэрэглэж байсан байна. Үүнд: 1924, 1960, 1992 оны Үндсэн хууль үйлчлэх үеийн бүхий л сонгуулийн хууль тогтоомжид хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн сонгуулийн эрхийг хуулиар автоматаар хязгаарлаж байсан бол 1940 оны Үндсэн хууль үйлчлэх үеийн сонгуулийн хууль тогтоомжоор сонгох эрхийг хасах нь эрүүгийн хариуцлагын нэгэн

⁴¹ *Sauve (No2)* [2002] 3 SCR 519 at [47] (McLacklin CJ)

⁴² *Minister of Home Affairs* [2004], 5 BCLR 445 (CC) at [106] (Madala J)

төрөл байж, уг хариуцлагыг 1 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн этгээдэд нэмэгдэл ял болгон хэрэглэх эсэхийг шүүхээс тусгайлан тогтоохоор заасан байна.

Харин гадаад улс орнуудын зохицуулалтыг харьцуулан судлахад үндсэн 3 төрөлд ангилан авч үзэх боломжтой байна. Үүнд:

- Хорих газар ял эдэлж байгаа этгээдүүдийн сонгуулийн эрхийг хуулиар шууд хязгаарладаг улс орнууд;

- Хорих ял эдэлж байгаа этгээдийн үйлдсэн хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хөнгөн, хүндийг харгалзан сонгуулийн эрхийг хязгаарлах эсэхийг хуулиар тусгайлан болон шүүхийн журмаар тогтоодог улс орнууд;

- Хорих ял эдэлж байгаа эсэхээс үл хамааран сонгуулийн эрхийг тухайн улсын бүхий л иргэн баталгаатай эдэлдэг улс орнууд.

Хоригдлын сонгуулийн эрхийг хязгаарлаж байгаа улс орнууд өөрсдийн хязгаарлалтын үндэслэлээ а) Эртний Грекэд анхлан үүсэж XIV зуунаас европын улс орнуудад хөгжсөн *CIVIC DEATH* буюу гэмт хэрэг үйлдэн эрхээ хязгаарлуулсан этгээд нь эрх зүйн статусын хувьд үхсэн этгээдтэй адил байх агуулга бүхий зарчим, б) Нийгмийн эсрэг зан үйл хийж, хууль зөрчсөн этгээдүүд нь Нийгмийн гэрээний онолын дагуу зарим эрхээ хязгаарлуулах нь үндэслэл бүхий бөгөөд хууль ёсны болох зарчим, в) нэмэлт эрүүгийн хариуцлагын төрөл гэсэн хэд хэдэн байдлаар тайлбарлаж байна.

Харин хоригдлын сонгуулийн эрхийн хязгаарлалт нь үндэслэлгүй, хууль бус болохыг улс орнууд болон эрдэмтэн, судлаачид а) Сонгох эрх нь улс төрийн харилцаанд хүний эдлэх үндсэн, суурь эрх тул зөвхөн хангалттай үндэслэлээр энэхүү эрхийг хязгаарлана. Хоригдлын хувьд нийгэмд эрх чөлөөтэй амьдрах эрх чөлөөгүй хэдий ч хязгаарлагдаагүй эрхийн хүрээнд хуулиар олгогдсон боломжийг чөлөөтэй хэрэгжүүлэх эрхтэй, б) хоригдлыг нийгэмшүүлэх, тэднийг ардчилсан нийгмийн үнэт зүйлсэд дасган журамлах, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгод харш гэсэн үндэслэлүүдээр хорих газар ял эдэлж байгаа этгээдийн сонгуулийн эрхийг хязгаарлах нь үндэслэлгүй хэмээн нотолж, тайлбарлаж байна. Улс орнуудын Үндсэн хуулийн шүүх, дээд шүүхийн шийдвэр болон бүс нутгийн хүний эрхийн шүүхийн шийдвэрийн жишиг хандлагыг харьцуулан судлахад нийгмийн гэрээний онол болон *civic death* зарим нь хүний үндсэн суурь эрхийн агуулгаар хязгаарлагдаж байна. Иймд бид өөрийн улс орны зохицуулалтыг ч олон улсын жишиг хандлагад ойртуулан Үндсэн хуульд бэхжүүлсэн сонгууль бүх нийтийн байх зарчмын агуулгыг өргөжүүлэх шаардлагатай байна.

Судлаачийн хувьд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн *"хорих газар ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй"*, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн *"... хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй"*, Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсгийн *"... хорих газар ял эдэлж байгаа иргэн сонгох эрх эдлэхгүй"* хэмээн заасан нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн *"Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ сонгоно"* гэснийг зөрчиж байгаа хэмээн үзэж байна.

Учир нь Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж, түүндээ хорих ялаар шийтгүүлж ял эдэлж байгаа этгээдийн хувьд нийгмийн дунд чөлөөтэй ажиллаж, амьдрах, нийгмийн гишүүдтэй хүссэн үедээ харилцах эрхэд хязгаарлалт тогтоогдох хэдий ч энэхүү хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн *"Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна."* гэсэн заалтын үйлчлэлд захирагдах ёстой. Хорих ялаар шийтгүүлсэн этгээдүүдийн засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдашгүй, хөндөгдөшгүй эрх тул сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх тэдний эрхийг хязгаарлах нь зүй ёсны хязгаарлалт болохгүй. Иймд хорих ял эдэлж байгаа нь аливаа этгээдийн хувьд түүний хувийн, эдийн засаг, нийгэм соёл, улс төрийн ямар эрх, эрх чөлөөнд хязгаарлалт болох эсэхийг ул суурьтай тодорхойлох шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХЭНД ҮЙЛЧИЛЭЖ БАЙСАН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ЗАРИМ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХОРИХ ГАЗАР ЯЛ ЭДЭЛЭЖ БАЙГАА ЭГТЭЭДИЙН СОНГУУЛИЙН ЭРХИЙН ХАРИМЦЛААГ ЗОХИЦУУЛСАН ТАЛААРХ ТҮҮВЭР СУДАЛГАА

№	Эрх зүйн актын батлагдсан огноо	пэр, пар,	Илтгэлийн агуулгад хамаарах зүйл, заалт
1.	1924 оны Үлдсэн хууль ⁴⁵		Гучин тандугээр зүйлийн 35.5 "Эд хичээх зэргээр нэрийг цутгах явдал чийдлэж, зарга ширх газраас ял шийтгэгдэхэд сонгох эрхгүй болно."
2.	1940 оны Үлдсэн хууль ⁴⁶		Дахин нэгдүгээр зүйл "... ийрн таслах газрын тооноогоор сонгуулийн эрхээ хасардаж шийтгэгдсэн хүмүүсээс бусад нь сонгох, сонгогдох эрхтэй болно."

⁴⁵ Аврагсмаа Ж. Батсайхан, О. Монгол Улсын Үлдсэн хууль 2004 он.

⁴⁶ Аврагсмаа Ж. Батсайхан, О. Монгол Улсын Үлдсэн хууль 2004 он.

	3. 1942 оны Эрүүгийн хууль ⁴⁷	<u>Дөрөвдүгээр бүлэг:</u> Гэмт хэрэг үйлдэгчдэд эрүүгийн хуулийн ёсоор оногдуулах ялын тухай 19 дүгээр зүйл: Шүүн таслахын засан сайжруулах чанар бүхий арга хэмжээнүүд нь 1. Засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх; 2. Хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх; 3. Улс төрийн ба иргэний хувийн зарим эрхүүдийг хасах гэх мэт нийт 10 хариуцлагын төрлийг заасан. 31 дүгээр зүйл: Улс төрийн ба ард иргэний зарим эрхийг хасаж болох үүнд: 1. Сонгох ба сонгогдох; 2. Улсын ямар нэгэн тушаал үүргийг гүйцэтгэх эрх гэх мэт нийт 5 төрлийг заасан байна. Нэгэн жилээс доош хорих ял оногдогчдод эрхийг хасах ялыг оногдуулаж үл болно.
--	--	---

⁴⁷ Монгол Улсын эрх зүйн тогтолцооны өөрчлөлт Дөрөвдүгээр боть 177-178 даяа тал.

4.	БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 74 дүгээр хурлын тогтоол ⁴⁸	Бага хурлын Тэргүүлэгчдээс тогтоох нь: 1. Ухаан мэдрэл сомоо буюу шүүн таслах газраас улс төрийнхөө эрх хасалдагдсаас бусад БНМАУ-ын Үндсэн хуулийн 71 дүгээр зүйлийн ёсоор үүний урьд сонгуулийнхаа эрхийг хасагдаж байсан тус улсын харьяат нарт цөмд нь сонгуулийн эрхийг олгохгүй. 2. Үндсэн хуулийн 71 дүгээр зүйлийн дор дурьдсан ёсоор өөрчлөн, 71 дүгээр зүйл: Ухаан мэдрэл сомоо буюу шүүн таслах газраас сонгуулийнхаа эрх хасалдагдсаас бусад БНМАУ-ын харьяат 18 нас хүрэгсэд эрэгтэй, эмэгтэй, үндэс угсаа, шашин шүтлэг, боловсрол, нүүдэл суурьшлын байдал болон хөрөнгөө чинээ байдлаар ялгаварлагдахгүй цөм сонгох эрхтэй болно.
5.	БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг БНМАУ-ын аймаг, хот, сум, хороо, баг, хорионы хөдөлмөрчдийн депутатуудын хурлын сонгуулийг явуулах тухай ⁴⁹ 1954-08-14	Хоёрдугаар зүйл: БНМАУ-ын харьяат 18 насанд хүрсэн ард иргэд, эрэгтэй, эмэгтэй, арвс өнгө, үндэстэн шашин шүтлэг, эрдэм боловсрол, нүүдэл суурьшина, хөрөнгийн байдал, нийгмийн тэргэлт ялгахгүйгээр тэгшхүү нүүхний тогтоолоор сонгуулийнхаа эрхийг хасалдаж шийтгэгдсэн хүмүүс ба мөн түүнчлэн хуульд тогтоогдсон журмаар ухаан солиотой гэж тооцогдсон хүмүүсээс бусад нь мөн сонгуульд оролцоно. Арван гуравдугаар зүйл: Шүүхийн тогтоолд заасан бүх хугацаанд сонгуулийнхаа эрхийг хасагдаж шийтгэгдсэн хүмүүс ба мөн түүнчлэн хуульд тогтоогдсон журмаар ухаан солио гэж тооцогдсон хүмүүсийг сонгогчдын нэрсийн жагсаалтанд үл орууна.

⁴⁸ Монгол Улсын эрдэм тогтоолжгийн түрэм зэмлэгт, Дорноддугээр боть 268-269 дэх тал.⁴⁹ Монгол Улсын эрдэм тогтоолжгийн түрэм зэмлэгт, Дорноддугээр боть 247-248 дэх тал.

6.	1960 оны Үндсэн хууль ³⁰	<u>Наян нэгдүгээр зүйл:</u> Ухаан солиотой гэж нотлогдсон хүнээс бусад 18 насанд хүрсэн БНМАУ-ын бүх иргэн төрийн аль ч байгууллагад сонгох, сонгогдох эрх эдэлнэ. <u>Хоёрдугаар зүйл:</u> БНМАУ-ын иргэд нь шууд болон төлөөлсөн байгууллагаар дамжин улс ба нийгэм, аж ахуйг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох бөгөөд шүүхэс солну гэж тогтоогдсон хүнээс бусад 18 насанд хүрсэн БНМАУ-ын бүх иргэн, төрийн аль ч байгууллагад сонгох, сонгогдох эрх эдэлнэ. <u>Аравдугаар зүйл:</u> Сонгогчдын ирэрийн жатсаалтад шүүхээс ухаан солну гэж тогтоогдсон буюу хорих ял шийтгэгдсэн хүмүүсээс бусад тус улсын харьяат, 18 насанд хүрсэн бүх иргэдийг оруулна.
7.	БНМАУ-ын Ардын Их Хурлыг сонгох сонгуулийн дүрэм ³¹ 1963-01-16	

³⁰ Амарсалма Ж. Галтайш. *О Монгол Улсын Үндсэн хууль*. 2004 он.

³¹ Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл Тасдугаар том. 233, 234 дүр тал.

8.	БНМАУ-ын орон нутгийн Ардын депутатуудын хуралг сонгох БНМАУ-ын орон нутгийн Ардын депутатуудын хуралг сонгох сонгуулийн тухай дүрэм ¹² 1984-02-20	2 дугаар зүйл: БНМАУ-ын орон нутгийн Ардын депутатуудын хуралг сонгох сонгуульд шийтгээрээ оролцох бөгөөд гэлцүү ухаан солиотой гэж тогтоосон журмаар нотлогдсон хүмүүсээс бусад 18 насанд хүрсэн БНМАУ-ын бүх иргэн сонгох, сонгогдох эрх эдэлнэ. Нийгмийн гараал, хөрөнгийн байдал, арьс, үндэс, боловсрол, хэл, шашин шүтлэг, тухайн нутагт оршин суугаа хугацаа, эрхээсэн ажлын байдлаар нь БНМАУ-ын иргэдийн сонгох, сонгогдох эрхийг шууд болон шууд бусаар хязгаарлахыг хориглоно. 10 дугаар зүйл: Хоригдох ял эдэлж байгаа этгээдийг сонгогчдын нэрсийн жагсаалтад оруулаахгүй.
9.	БНМАУ-ын Ардын Хуралг Тэргүүлэгчдийн зарлиг БНМАУ-ын Ардын Хуралг сонгох сонгуулийн дүрмийг батлах тухай 1986-02-22	2 дугаар зүйл: БНМАУ-ын Ардын Их Хуралг депутатын хуралг сонгох сонгууль нь бүх нийтийн байна. Ухаан солиотой гэж тогтоосон журмаар нотлогдсон хүмүүсээс бусад 18 насанд хүрсэн БНМАУ-ын бүх иргэн сонгох, сонгогдох эрх эдэлнэ. Нийгмийн гараал, байдал, эд хөрөнгө, арьс, үндэс, эрэгтэй, эмэгтэй, боловсрол, хэл, шашин шүтлэг, тухайн нутагт оршин суугаа хугацаа, эрхээсэн ажлын төрөл, шинж болон бусад байдлаар нь БНМАУ-ын иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарлахыг хориглоно. 17 дугаар зүйл: Хориг ял эдэлж байгаа этгээдийг сонгогчдын нэрсийн жагсаалтад оруулаахгүй.

¹² Мөнхсүх Уушан хууль тогтоомжийн түүхэн амтлага. Эрсдугаар боть-315-316 дэвх тал.
¹³ Мөнхсүх Уушан хууль тогтоомжийн түүхэн амтлага. Долдугаар боть-45-47 дэвх тал.

10.	1992 оны Үндсэн хууль ¹⁴	Арван зургадугаар зүйл: 16.9. Монгол Улсын иргэн шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ.
11.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль ¹⁵ 1992-04-04	1 дүгээр зүйл: Улсын Их Хурлын сонгууль бүх нийтийн байна. Санал авах өдөр эх орондоо байгаа, Монгол Улсын арван найман насанд хүрсэн иргэн үндэс утсаа, хэл, арсны өнгө, хүйс, нийгмийн гараа, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаваргүйгээр сонгох эрхтэй. Гэгдхүү эмнэлэгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцохгүй.
12.	Монгол Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль 1993-02-15	3 дугаар зүйл: ... Анхан шатны сонгууль бүх нийтийн байна. ... Гэгдхүү эмнэлэгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцохгүй.
13.	Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай 1996-08-27	3 дугаар зүйл: Санал авах өдөр аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа 18 насанд хүрсэн сонгуулийн эрх бүхий иргэн үндэс утсаа, хэл, арсны өнгө, хүйс, нийгмийн гараа, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаваргүйгээр сонгох эрхтэй. Гэгдхүү эмнэлэгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцохгүй.

Дүгнэлт:

Монгол Улсын түүхэнд үйлчилж байсан сонгуулийн таларх хууль тогтоомжид хорих газар ял эдэлж байгаа этгээдүүдийн эрхийн талар зохицуулсан хэм хэмжээг түүвэр байдлаар харьцуулан судалж үзэхэд үлдсэн 2 ялгамжит зохицуулалтыг гаргах боломжтой байна.

1. 1924, 1960 оны Үлдсэн хууль болон одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид зааснаар Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, уг үйлдэлдээ хорих ялаар шийтгэгдсэн этгээдүүдийн хууль сонгуулийн эрх нь автоматаар хязгаарлагдахаар заасан байна. Энэ шинжээрээ манай улс хорих газар ял эдэлж байгаа этгээдийн эрхэд BLANKET BAN бүхэлд нь хязгаарладаг улс орнуудад багтаж байна. Эдгээр улс орнуудад одоогийн байдлаар ОХУ, Болгар, Эстон, Гүрж, Унгар, Лихтенштейн, Ангел болон ази тивийн бүх улс багтгаж байна
2. Харин 1940 оны Үлдсэн хууль хүчин төгөлдөр үйлчилж байх үеийн Эрүүгийн хууль, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 74 дүгээр хурлын тогтоол болон БНМАУ-ын аймг, хот, сум, дүүрэг, хороо, баг, хоринь хөдөлмөрчдийн депутатуудын хурлын сонгууль явуулах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигт зааснаар хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн сонгуулийн эрх хязгаарлагдах эсэх нь шүүхийн шийдвэрээс ихээхэн хамаарахаар ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл энэ үед сонгох, сонгогдох эрхийг хасах нь эрүүгийн хариуцаагын нэмэлт ялын төрөлд хамаарч байжээ. Эдүгээ дэлхийн улс орнуудад энэ зогварыг ХБНГУ, Франц, Грек зэрэг улс оронд хэрэглэж байна.

* Амарсалаа Ж. Басгайхан О. Монгол Улсын Үндсэн хууль Увс, 2004 он.

в. Монгол Улсын эрдэмтнийг шинэ түрэмэг зогшилд Дэлгэрмөр болон 510-511 дэх тал.

Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгаа*

I. УДИРТГАЛ

1.1. Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны ажлын зорилго нь иргэн, хуулийн этгээдийн арбитраар хэрэг маргаанаа төдийлэн шийдвэрлүүлэхгүй байгаа шалтгааныг олж тодорхойлох, Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага, үндэслэлийг судлахад чиглэгдэж байгаа бөгөөд энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлээ. Үүнд:

- **Арбитраар маргаанаа шийдвэрлүүлэх иргэн, хуулийн этгээдийн тоо нэмэгдэхгүй байгаа шалтгааныг судлах;**

Зорилтын хүрээнд иргэн, хуулийн этгээдийн арбитраар тухай мэдлэг болон арбитраар маргаанаа шийдвэрлүүлж байсан этгээд, арбитраарас арбитраар үйл ажиллагаа болон шүүхийн зардал, арбитраар хураамж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат дамжлага, хугацаа, шуурхай байх зарчим зэргийн талаар социологийн аргаар судалгаа хийж дүгнэлт гаргасан.

- **Гадаадын зарим улсад байнгын арбитраар хаана байгуулж ажиллуулдаг талаар судлах;**

Байнгын арбитраар МҮХАҮТ-ын дэргэд эсвэл бусад төрийн бус байгууллагын дэргэд байгуулах боломжтой эсэхийг судлахын тулд гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтыг эрх зүйн бүлээр харьцуулан судалж дүгнэлт гаргасан. Мөн арбитраар тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан байнгын арбитраар харьяаллын талаарх асуудалд дүн шинжилгээ хийсэн.

- **Арбитраар шийдвэрийг хүчингүй болгуулах, арбитраар хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, арбитраар томилуулах, татгалзан гаргах гэх мэт талуудын хүсэлтийг шүүх шийдвэрлэхдээ онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх үндэслэлтэй эсэхийг судлах;**

* Судалгааг удирдсан ХЗҮХ-гийн Иргэн, зүйн зөвлөлийн эрх зүйн секторын эрхлэгч, хууль зүйн доктор Б.Тэмүүлэн, гүйцэтгэл зүйн секторын эрх зүйн шинжилгээний ажилтан Б.Солонго, Б.Наранцацралт, социологич Н.Анхжаргал

Дээрх асуудлыг шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэдэг бөгөөд арбитрчийг томилуулах, татгалзан гаргах талуудын хүсэлтийг шүүх онцгой ажнлагааны журмаар хянан шийдвэрлэж болох үндэслэлийг судалсан.

Судалгааг 2011 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Судалгаа явуулахад баримталсан зарчим: Судалгааг бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлах, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмаар гүйцэтгэв.

Хамрах хүрээ:

1. МҮХАҮТ-ын дэргэдэх Үндэсний арбитр-арбитр болон арбитрчдын талаар мэдээ, материал цуглуулав;

2. Нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн шүүх-иргэн, хуулийн этгээдийн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой маргаан шийдвэрлүүлэх иргэн, хуулийн этгээдийн арбитрт хандахгүй байгаа шалтгаан, нөхцөлийг судлав;

3. Нийслэлийн шүүхийн иргэний хэргийн төв архив-2006-2009 оны хооронд арбитрчийг томилуулах, татгалзан гаргах, арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай талуудын хүсэлтийг шийдвэрлэсэн 17 хэргийн материалыг уншиж танилцав;

4. Хан-Уул дүүргийн шүүх-2010 онд Үндэсний арбитраас гарах шийдвэрийг баталгаажуулах болон шийдвэр гүйцэтгэх хуудас олгосон 13 хэргийн материалыг уншиж танилцав.

Жич: Энэхүү судалгааг ХЗДХЯ-наас боловсруулсан “Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал”-д тулгуурлаагүй бөгөөд ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн хүрээнд судалсан.

Судалгааны арга: Баримт бичгийн судалгааны арга, анкетын арга, ярилцлагын арга, түүврийн арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргаар судалгааг хийж гүйцэтгэлээ.

1.2. Судалгааны ач холбогдол

ҮИХ-ын 38 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох тухай үндсэн чиглэлийн 2.102-д “Арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, арбитрын тогтолцоог сайжруулах, арбитр, шүүхийн хоорондын харилцааг нарийвчлан зохицуулах” чиглэлээр Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, Ерөнхий сайдаас 2010 онд баталсан “Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн

хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 1.9.2-д "Эдийн засаг, бизнесийн чиглэлийн маргааныг Арбитраар шийдвэрлүүлж байх, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн, цаг хугацаа алдахгүйгээр хангах, үйл ажиллагааг тодорхой болгох, хөнгөвчлөх зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна", Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1-т "...Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн төлөв байдлыг судлан тодорхойлож, хийдэл, давхардал, зөрчлийг ариглах замаар хуулийг боловсронгуй болгоно" гэж тус тус заасныг үндэслэн Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байгаа билээ¹. Үүнтэй холбогдуулан ХЗДХЯ-ны захиалгын дагуу энэхүү судалгааг хийв.

Энэ судалгаа нь арбитра хандах иргэн, хуулийн этгээдийн тоо нэмэгдэхгүй байгаа шалтгаан, нөхцөлийг социологийн судалгаагаар тогтоож, байнгын арбитраг бусад улс оронд хаана байгуулдаг талаарх харьцуулсан судалгаа хийж, Арбитрын тухай хууль болон түүнтэй холбоотой бусад материалаг хуулийн ололын үүднээс тайлбарлаж арбитраг шийдвэрийг хүчингүй болгуулах, арбитражийг томилуулах, тагталзан гаргах асуудлыг шүүх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх боломжтой эсэхэд хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт өгснөрөө ач холбогдолтой болсон.

II. АРБИТРЫН ТУХАЙ ХҮҮЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БУСАД ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛААТ

2.1. Арбитрын үйл ажиллагаа, арбитраар маргаанаа шийдвэрлэх тухай ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэг

Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХАУТ)-ын дэргэдэх Үндэсний арбитра нь байнгын арбитраг хувьд тогтмол үйл ажиллагааг тасралтгүй эрхэлж 2007 (26), 2008 (18), 2009 (31) онуудад буюу сүүлийн 3 жилийн байдлаар нийт 75 маргаан шийдвэрлэжээ. Гэтэл шүүхээр 2007 (30699), 2008 (28480), 2009 (35822)² он буюу сүүлийн 3 жилийн байдлаар нийт 95001 иргэний эрх зүйн маргааныг улсын хэмжээнд шийдвэрлэжээ. Энэ мэт шүүхээр шийдвэрлэгдэж байгаа иргэний хэрэг арбитраг байгууллагаар шийдэгдэж байгаа хэргээс даруй хэд дахин их байна.

Эрх зүйн харилцаанд оролцогч 200 иргэнээс санамсаргүй түүврийн


¹ Хууль зүй, дотоод хэргийн газрын Хууль зүйн бодлогын газар, Улсын дээд шүүхийн шүүгч, Нийслэлийн шүүхийн шүүгч, Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч, МХАУТ-ын дэргэдэх Үндэсний арбитраг шийдвэрийн бэрхлэхүүнтэй асмын хэсэг хуулийн төслийг боловсруулсан.

² Арбитрын тухай хууль, 2008.03.13-т өөрчлөлт оруулсан тухай хууль, нийслэлийн цахилгаан мэдээллийн үйлчилгээний газар, 2010 он.

аргаар авсан анкетаас “Та шүүхийн байгууллага болон арбитрын байгууллагын талаар хэр мэдлэгтэй вэ?” гэсэн асуултыг графикаар харьцуулан харвал:

График-1

Та шүүх болон арбитрын байгууллагын талаар хэр мэдэх вэ?




Дээрх графикаас харахад иргэд, олон нийт арбитрын байгууллагаас илүү шүүхийн байгууллагыг мэддэг болох нь харагдаж байна.

Шүүхийн байгууллагын хувьд муухан мэднэ, мэдэхгүй гэсэн хариулт 22,8 хувийг эзэлж байхад арбитрын байгууллагын талаар муухан мэднэ, мэдэхгүй гэсэн хариулт 57,2 хувийг эзэлж байгаа нь иргэд арбитрын талаар мэдлэг тааруу гэдэг нь харагдаж байна.

График-2

Ямар чиглэлээр хандаж байсан бэ?



Шүүхийн байгууллагад ямар чиглэлээр хандаж байсан бэ? гэсэн асуултад иргэд ихэвчлэн иргэний хэрэг, маргааныг шийдвэрлүүлэх

хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 1.9.2-д "Эдийн засаг, бизнесийн чиглэлийн маргааныг Арбитраар шийдвэрлүүлж байх, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн, цаг хугацаа алдахгүйгээр хангах, үйл ажиллагааг тодорхой болгох, хөнгөвчлөх зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна", Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1-т "...Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн төлөв байдлыг судлан тодорхойлож, хийдэл, давхардал, зөрчлийг арилах замаар хуулийг боловсронгуй болгоно" гэж тус тус заасныг үндэслэн Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байгаа билээ¹. Үүнтэй холбогдуулан ХЗДХЯ-ны захиалгын дагуу энэхүү судалгааг хийв.

Энэ судалгаа нь арбитра хандах иргэн, хуулийн этгээдийн тоо нэмэгдэхгүй байгаа шалтгаан, нөхцөлийг социологийн судалгаагаар тогтоож, байнгын арбитраг бусад улс оронд хаана байгуулдаг талаарх харьцуулсан судалгаа хийж, Арбитрын тухай хууль болон түүнтэй холбоотой бусад материалаг хуулийн ололын үүднээс тайлбарлаж арбитраг шийдвэрийг хүчингүй болгуулах, арбитражийг томилуулах, тагдалзан гаргах асуудлыг шүүх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх боломжтой эсэхэд хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт өгснөөрөө ач холбогдолтой болсон.

II. АРБИТРЫН ТУХАЙ ХҮҮЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БУСАД ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Арбитрын үйл ажиллагаа, арбитраар маргаанаа шийдвэрлүүх тухай ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэг

Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХАУТ)-ын дэргэдэх Үндэсний арбитр нь байнгын арбитраг хувьд тогтмол үйл ажиллагааг тасралтгүй эрхэлж 2007 (26), 2008 (18), 2009 (31) онуудад буюу сүүлийн 3 жилийн байдлаар нийт 75 маргаан шийдвэрлэжээ. Гэтэл шүүхээр 2007 (30699), 2008 (28480), 2009 (35822)² он буюу сүүлийн 3 жилийн байдлаар нийт 95001 иргэний эрх зүйн маргааныг улсын хэмжээнд шийдвэрлэжээ. Энэ мэт шүүхээр шийдвэрлэгдэж байгаа иргэний хэрэг арбитраг байгуулагаар шийдэгдэж байгаа хэргээс даруй хэд дахин их байна.

Эрх зүйн харилцаанд оролцогч 200 иргэнээс санамсаргүй түүврийн


¹ Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газар, Улсын дээд шүүхийн шүүх, Нийслэлийн шүүхийн шүүх, Хан-Уул дүүргийн шүүхийн шүүх, МХАУТ-ын дэргэдэх Үндэсний арбитраг, арбитражид, Монголын Үндэсний арбитраг ахлах мэргэжилтэн, хууль зүйн чиглэлээр судалгаа хийдэг судлаачийн бэрлэлтүүнтэй ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулсан.

² Арбитрын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулалтын тухай үндэсний төсвийн санхүүгийн үйлчилгээний газрын мэдээлэл 2010 он.

аргаар авсан анкетаас “Та шүүхийн байгууллага болон арбитрын байгууллагын талаар хэр мэдлэгтэй вэ?” гэсэн асуултыг графикаар харьцуулан харвал:

График-1

Та шүүх болон арбитрын байгууллагын талаар хэр мэдэх вэ?



Дээрх графикаас харахад иргэд, олон нийт арбитрын байгууллагаас илүү шүүхийн байгууллагыг мэддэг болох нь харагдаж байна.

Шүүхийн байгууллагын хувьд муухан мэднэ, мэдэхгүй гэсэн хариулт 22,8 хувийг эзэлж байхад арбитрын байгууллагын талаар муухан мэднэ, мэдэхгүй гэсэн хариулт 57,2 хувийг эзэлж байгаа нь иргэд арбитрын талаар мэдлэг тааруу гэдэг нь харагдаж байна.

График-2

Ямар чиглэлээр хандаж байсан бэ?




Шүүхийн байгууллагад ямар чиглэлээр хандаж байсан бэ? гэсэн асуултад иргэд ихэвчлэн иргэний хэрэг, маргааныг шийдвэрлүүлэх

зорилгоор хандаж байсан гэж хариулсан байна (51.2 хувь). Энэ нь арбитрт хандаж хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх иргэд, байгууллагын нөөц их байна гэж үзэж болох юм.

Мөн арбитр яг ямар үйл ажиллагаа явуулдаг талаар бяцхан сорилын тест явуулахад судалгаанд оролцогчдын 35,6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол арбитр нь зөвхөн улс хоорондын маргааныг зохицуулдаг байгууллага гэж 22,2 хувь нь хариулсан, 18,3 хувь нь арбитрыг шүүхийн байгууллага гэж хариулжээ. Харин 21,1 хувь нь арбитрыг дотоод болон гадаадын эрх зүйн этгээдүүдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэдэг гэж үзжээ.

График-3

Таны бодлоор арбитр нь ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага вэ?



Хүснэгт-1-ийг харвал “Арбитрын талаар хэр мэдлэгтэй вэ?” гэсэн асуултыг “Таны бодлоор ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага вэ?” гэдэг асуулттай харьцуулан үзвэл **Хангалттай сайн** мэднэ гэсэн иргэдийн 43,8 хувь нь зөвхөн аль нэг улсын харьяалалтайгаас үл хамааран гадаад худалдааны хэрэг маргааныг шийдвэрлэдэг гэсэн ойлголттой байна, харин дунд зэрэг мэднэ гэсэн иргэдийн 35,7 хувь буюу хамгийн өндөр хувь нь арбитрыг шүүхийн байгууллага гэсэн ойлголттой явдаг юм байна.

Хүснэгт-1


Таны бодлоор арбитр ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага вэ?

Арбитрын талаар хэр мэдлэгтэй вэ?	Аль нэг улсын харъяалалтайгаас үл хамааран гадаад худалдааны хэрэг маргааныг шийдвэрлэдэг байгууллага	Зөв дүгнэсэн	Шүүхийн байгууллага гэж үздэг	Мэдэхгүй
Хангалттай сайн мэднэ	43,8	37,5	18,8	0,0
Дунд зэрэг мэднэ	26,8	32,1	35,7	5,4
Муухан мэднэ	28,8	19,2	17,3	34,6
Мэдэхгүй	5,9	7,8	2,0	84,3

Доорх хүснэгтээс үзвэл иргэдээс арбитрын талаар хүмүүс хэр мэдлэгтэй талаар асуухад Хангалттай сайн мэднэ гэж 0,6 хувь, 16,1 хувь нь дунд зэрэг мэднэ, муухан мэднэ гэж 52,2 хувь нь, мэдэхгүй гэж 30,6 хувь нь хариулсан байна.

График-4

Таны бодлоор арбитрын байгууллага болон арбитрчдын талаар олон нийт хэр зэрэг мэдлэгтэй гэж бодож байна вэ?



Арбитрын талаар иргэд, олон нийт мэдээлэл муутай байгаа. Зөвхөн гадаад худалдааны маргаан шийддэг гэж боддог.

Арбитрчаар 8 жил ажилласан, нас 38

Иргэдээс авсан санал, асуулгаар иргэд арбитрын талаар мэдлэг хомс байдаг нь харагдаж байна. Харин арбитраар үйлчлүүлсэн иргэд, байгууллагаас дээрх асуултыг асуувал *Хангалттай сайн* мэднэ гэсэн хариултыг сонгосон ч бас л гадаад худалдааны хэрэг, маргааныг шийдвэрлэдэг гэсэн хариултыг давхар сонгосон байгаа юм. *Дунд зэрэг* мэднэ гэсэн хариулт сонгосон нь 100 хувь гадаад худалдааны маргааныг шийдвэрлэдэг гэж хариулжээ.

Хүснэгт 2


Таны бодлоор арбитр ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага вэ?

Арбитрын талаар хэр мэдлэгтэй вэ?	Аль нэг улсын харъяалалтайгаас үл хамааран гадаад худалдааны хэрэг маргааныг шийдвэрлэдэг	зөв дүгнэсэн
Хангалттай сайн мэднэ	50.0	50.0
Дунд зэрэг мэднэ	100.0	0

Дээрхээс дүгнэн үзвэл олон нийт болон арбитраар үйлчлүүлсэн байгууллага, иргэд арбитрын талаар бүрэн гүйцэт бус дутуу ойлголттой байдаг нь харагдаж байна.

Арбитраар үйлчлүүлсэн 24 иргэн, хуулийн этгээдээс арбитрын байгууллагаар хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэхийн гол ач холбогдлыг асуувал: 28,6 хувь нь арбитрын шийдвэр эцсийн бөгөөд заавал шийдэгдэнэ гэсэн хариултыг өгсөн байна. Мөн шат дамжлага бага гэж 21,4 хувь нь үзсэн бол 14,3 хувь нь цаг хугацаа хэмнэнэ, хүнд сурталд автахгүй гэж хариулжээ.

График-5



Олон арван (зуун) хавтаст хэрэгт дарагдсан илүүгчээр хам хум шийдвэрлүүлж 2-3 шат дамжлага дамжин цаг хугацаа маш ихээр алдсан нь дээр үү? Тухайн чиглэлээр мэргэшсэн этгээд (хуульч, эдийн засагч зэрэг)-ээр дагнасан богино хугацаанд хамгийн зөв шийдвэр гарах магадлалтайгаар маргаанаа шийдүүлэх нь зөв.

МУИС-ХЭС-ийн багш, арбитраар 5 жил ажилласан,
40 настай

Эдгээрээс дүгнэхэд ямарч байсан арбитраар үйлчлүүлсэн иргэн, хуулийн этгээд нь арбитрын ашигтай талыг мэддэг нь харагдаж байна.

Арбитрын хураамж, шүүхийн зардал

“Шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлж байгаа этгээдүүдийн тоо жил бүр нэмэгдэж байхад арбитраар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх этгээдүүдийн тоо нэмэгдэхгүй байгаа нь юутай холбоотой гэж та бодож байна вэ?” гэдэг асуултад үйлчлүүлэгчид хариулахдаа иргэд арбитрын талаар тодорхой ойлголтгүй байдаг гэж 33,3 хувь нь хариулснаас үзвэл иргэд тодорхой ойлголтгүй нь харагдаж байна.

Хүснэгт-3

Иргэд Арбитрын талаар тодорхой ойлголтгүй байдаг	33,3
Арбитрын хууль эрх зүйн орчин бүрдээгүй	11,1
Хүнд сурталтай	11,1
Зардал их гардаг	22,2
Цаг их алддаг	11,1
Шүүх байгууллага нь илүү найдвартай	11,1

Харин *зардал их гардаг* гэж 22,2 хувь нь хариулсан байгаа нь арбитраар хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх нь хэдий ашигтай ч үнэ хөлсний хувьд өндөр байх тал ажиглагдаж байна.

График 6-аас үзэхэд мөн арбитраар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 40 хувь нь *өндөр* гэж үзсэн байна. Бусад 20 хувь нь *боломжийн*, *бага* гэж үзжээ.

График-6

Танд **арбитрын зардал, улсын тэмдэгтийн хураамжийн үнэ хөлс, өртөг хэр боломжийн санагддаг вэ?**



Эндээс харахад арбитрын үнэ, өртгийн талаар үйлчлүүлэгчид харьцангуй өндөр гэж үзсэн байхад арбитрагчид үнэ, өртгийн хувьд 3 хүний нэг нь боломжийн гэж үзсэн байна.

Арбитрын шийдвэрийг шүүхийн журмаар албадан гүйцэтгүүлэхэд гарч буй зардал, хураамж өндөр байгаа.

МУИС-ийн багш, арбитрчаар 6 жил ажилласан, нас 46

ИХШШТХ-д зааснаар арбитрын шийдвэрийг хүчингүйд тооцуулах, шүүхээс нотлох баримт бүрдүүлэх, гүйцэтгэх хуудас бичүүлэх зэрэг ажиллагааг хангуулахаар шүүхэд хандахад Улсын тэмдэгтийн хураамж дахин төлөхөд хүрдэг нь зохимжгүй.

Арбитрчаар 8 жил ажилласан, нас 38

Арбитрын зардлын хэмжээг багасгах талаар арга хэмжээ авах хэрэгтэй. Одоо шүүхийн зардал буюу Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хэмжээтэй харьцуулахад арай өндөр байдаг.

МУИС-ХЭС-ийн багш, Арбитрчаар 8 жил ажилласан, 51 настай

Хэрэв та болон танай байгууллага ямар нэгэн маргааныг шийдвэрлэхээр боловч хаана эхэлж хандах вэ? гэдэг асуултад арбитраар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчид дахиж арбитрын байгууллагад хандахгүй гэсэн нь сонирхолтой байгаа юм.

Хүснэгт-4

Арбитрын байгууллагад	0
Шүүхийн байгууллагад	50
Мэдэхгүй	50

Шүүхээр маргаан шийдвэрлүүлэх эрх зүйн орчин арбитртай харьцуулахад илүү төлөвшсөн. Шүүхийн зардал нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд зааснаар харьцангуй бага. Гомдолтой эсвэл буруу шийдсэн гэж үзвэл дараагийн шатанд хянуулах боломжтой байдаг учраас ийм сонголтыг хийсэн байж магадгүй.

Доорх хүснэгтэд Арбитрын үйл ажиллагааг үнэлэсэн байдлыг харвал "Арбитр эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус, бие даасан, шударга байх байдал" гэсэн судалгаанд оролцогчдын 20 хувь нь сайн гэж хариулсан байхад бусад талаар сайн гэсэн үнэлгээ огт өгөөгүй байна. "Арбитр, зуучлалын ажиллагааг сурталчлах, сургалт, семинар зохион байгуулах талаар" гэсэнд 60 хувь нь муу гэж үнэлжээ.

Хүснэгт-5


	Сайн	Дунд	Муу
Монгол Улсын Арбитрын хууль зүйн орчин		80,0	20,0
Шүүх арбитр 2-ын хоорондын уялдаа холбоо		60,0	40,0
Арбитр эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус бие даасан, шударга байх байдал	20,0	80,0	
Арбитр, зуучлалын ажиллагааг сурталчлах, сургалт, семинар зохион байгуулах талаар		40,0	60,0

Энэ нь арбитрын үйл ажиллагааны талаар үйлчлүүлэгчид төдийлөн сэтгэл хангалуун биш байдаг, бусад үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаа нь харагдаж байна.

Харин График-7-г харвал “Арбитраар шийдвэрлүүлсэн хэрэг, маргааныг хэр шударга, үнэн зөв шийдэж өгдөг гэж та боддог вэ?” гэдэг асуултад 60 хувь нь үнэн зөв шийддэг тохиолдол их гэж хариулсан байна.

График-7

Арбитраар шийдвэрлүүлсэн хэрэг маргааныг хэр шударга, үнэн зөв шийдэж өгдөг гэж та боддог вэ?



Дээрхээс дүгнэвэл өөрийнөө сурталчлах, хууль, эрх зүйн орчин, шүүх, арбитрын үйл ажиллагааны уялдаа, холбоо зэрэгт хангалтгүй ажиллаж байна. Харин үйл ажиллагааныхаа хувьд өөрийнхөө үүргийг сайн гүйцэтгэж чадаж байна гэж үзэж болохоор байна.

Монгол Улсад байнгын болон түр арбитрын аль нь илүү давамгайл цйл ажиллагаа явуулсан нь ашигтай вэ? гэсэн асуултад үйлчлүүлэгчдийн 60 хувь нь байнгын арбитр байх ашигтай, харин 20 хувь нь аль аль нь байсан нь ялгаагүй гэж хариулсан байна.

Хүснэгт-6

Түр арбитр	0
Байнгын арбитр	60
Аль аль нь	20
Хариулаагүй	20

Байнгын арбитр мэргэшсэн, чадвартай болж бэхжих нь илүү цр дүнтэй. Энэ нь арбитрын ажилтнуудад бас хамаатай.

Арбитрчаар 8 жил ажилласан, нас 38

Арбитраар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат дамжлага, хугацаа, арбитрын шийдвэрт гомдол гаргах процедур нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хэр ялгаатай байна вэ?

Арбитрын хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаа шүүхийн процедуртай харьцуулахад арай хялбар явагддаг. Давах, хяналтын шатанд гомдол гаргах боломж хязгаарлагдмал. Хэргийг шийдвэрлэх хугацаа богино байдаг. Мөн Арбитрын процесс нь илүү чөлөөтэй, талуудын хүсэл зориг, сонголтод түшиглэсэн байдгаараа ялгаатай. Цаг хугацааны хувьд 2-3 дахин бага, дагнасан, мэргэшсэн этгээдээр хэрэг, маргаанаа шийдүүлэх, авлига, хээл хахуулиас ангид байдаг байна.

Иргэдээс арбитрыг олон нийтэд таниулахад ямар ажил хийх нь зохистой вэ? гэсэн асуултад хамгийн их санал өгсөн байдлаар нь жагсаан авч үзвэл:

Нэгдүгээрт, олон нийтийн телевиз, радиогоор сурталчлахыг санал болгосон;

Хоёрдугаарт, олон нийттэй тулж ажиллаж өөрсдийгөө таниулах

хэрэгтэй гэж үзсэн;

Гуравдугаарт, арбитрын байгууллагын талаар мэдээлэл өгдөг газрыг бий болгох хэрэгтэй гэж үзсэн байна.

Судалгаанд оролцогчдын санал

Хүснэгт-7

1	Арбитрын байгууллагын давуу талыг олон нийтэд зөв таниулан сурталчлах (хэвлэмэл тараах материал мөн сонин, сэтгүүл, радио, телевизээр сурталчилах, зохиомжит нэвтрүүлэг хийх зэрэг таниулах үйл ажиллагаа явуулах).
2	Арбитрын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох, арбитр, шүүх хоёрын ялгааг иргэдэд мэдүүлэх, нээлттэй хаалганы өдөр гэх мэт олон үйл ажиллагааг сар болгон тогтмол явуулах.
3	Арбитрын байгууллагын талаар мэдээлэл өгдөг газруудыг байгуулах. (шаардлагатай үед мэдээлэл өгдөг газар)
4	Эрх зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сургуулиудын хичээлийн хөтөлбөрт оруулах.
5	Хүнд сурталгүй, үнэнч шударгаар иргэдэд хүрч ажиллах.
6	Иргэдийг хамарсан үнэгүй лекц, семинар зохион байгуулах.
7	Нэрийг монголчилж бичих.
8	Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн мэргэжлийн биш ангийн хичээлийн хөтөлбөрт арбитрын талаар анхан шатны мэдлэг өгөх.
9	Тодорхой бодит жишээн дээр тайлбарлан таниулах.

2.2. Байнгын арбитрын харьяалаг (гадаад улсын эрх зүйн зохицуулалт)

Судалгааны ажлын зорилтын хүрээнд Англо-саксон, Ром-герман, хуучин социалист орнууд байнгын арбитрыг ашгийн болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дэргэд байгуулдаг эсэх, эсвэл зөвхөн мэргэжлийн холбоод болон худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд байнгын арбитрыг байгуулдаг эсэхийг эрх зүйн бүлээр нь үзвэл:

1. Эх газрын эрх зүйн системтэй улс орнууд¹

№	Улс орны нэрс	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1.	Армен	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын шүүхийн тухай хуульдаа Худалдаа Аж үйлдвэрийн танхим, Хөрөнгийн бирж гэх мэт байгууллагуудад байнгын арбитр байгуулах эрхийг олгосон.
2.	Беларусь	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Байнгын ажиллагаатай Олон Улсын Арбитрын шүүх нь төрийн бус, ашгийн төлөө бус, хуулийн этгээд байна. Байнгын арбитрын шүүхийг гадаадын хуулийн этгээд, худалдаа наймаа эрхлэгчидтэй гадаад эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд нь хувь нэмэр оруулах гол зорилготой арилжааны бус байгууллага байгуулна.

¹ Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх гадаад худалдааны арбитрын 2002 оны 9 дүгээр сард хийсэн судалгаа. Арбитрын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх зорилгоор судалгааны материалас МҮХАҮТ, УБ: 2003 он.

3.	Венесуэль	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арилжааны Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын төв танхимын нэг хэлтэс болохын хувьд танхимын захирлуудын зөвлөлд ажлаа тайлагнадаг. Хуулийн дагуу худалдааны танхимууд болон аливаа худалдааны байгууллагууд, эдийн засаг, аж үйлдвэрийн ажиллагаатай холбоотой олон улсын холбоо, байгууллага, маргаан шийдвэрлэх альтернатив аргыг дэмжих зорилготой байгууллага, их сургууль, боловсролын байгууллага, маргааныг шийдвэрлэх арбитрыг байгуулсан бусад байгууллага нь өөрсдийн арбитрын төвийг байгуулж болно.
4.	ХБНГУ	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаггүй.	Энэ улсын хувьд Арбитр нь бие даасан, хараат бус, ашгийн төлөө бус, олон нийтэд үйлчилдэг байгууллага байдаг.

5.	Индонези	Үгүй. Тусгайлсан арбитрын тухай хуульгүй.	Одоо хүртэл Индонез нь арбитрын тухай тусгай хууль батлаагүй. Иргэний хуульд арбитрын тухай зүйл, заалт бий ч эдгээр нь Юниситралын загвар хуульд үндэслэгдээгүй.
6.	Итали	Үгүй. Тусгайлсан арбитрын тухай хуульгүй.	Арбитрын ажиллагааг Иргэний хуулиар зохицуулсан.
7.	Литва	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Үйлдвэрлэл, худалдаа, аж ахуйн нэгжийг төлөөлөх, төрний бус байгууллага нь байнгын арбитрын байгууллагыг байгуулж болно. Байнгын арбитрын дүрмийг үүсгэн байгуулагчид бэлтгэж Хууль зүйн яам нь батладаг.
8.	Нидерланд	Үгүй. Тусгайлсан арбитрын тухай хуульгүй.	Арбитрын ажиллагааг Иргэний хуулиар зохицуулсан.
9.	ОХУ	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Олон улсын Арилжааны Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын шүүх улсын байнгын шүүх байна.

10.	Перу	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын төв худалдааны танхимдаа харъяалагддаг ч өөрийн удирдлага, хууль, дүрэмтэй. Арбитрын байгууллага хуулийн этгээд байх ёстой.
11.	Польш	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Эдийн засгийн танхимын тухай хуулиар зохицуулсан.	Арбитр танхимын хоорондын харилцааг арбитрын дүрмээр зохицуулна.
12.	Франц	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Арбитрын тухай тусгай хуульгүй.	Францын арбитрын үйл ажиллагааг Иргэний хуулиар зохицуулдаг. Тусгайлан гаргасан арбитрын хууль байхгүй. Францад Олон Улсын худалдааны танхимын арбитрын шүүх байдаг тул ихэнх маргаан үүгээр шийдэгддэг. Парисын арбитрын хороо нь бие даасан, хараат бус, ашгийн төлөө бус, олон нийтэд үйлчилдэг байгууллага юм.

13.	Украин	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Олон улсын Арилжааны Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Украины Арбитрын тухай хуульд байнгын арбитр нь тухайн хэргийг шийдэхээр байгуулагдсан бүрэлдэхүүн эсвэл байнгын арбитрын байгууллага, ялангуяа Украины Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арилжааны арбитрын шүүх буюу Далайн арбитрын хороо байна гэж шууд заасан байна.
14.	Чех	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг.	Чехийн Бүгд Найрамдах Улсын эдийн засгийн танхимын болон хөдөө аж ахуйн танхимын дэргэдэх арбитрын шүүх арбитрын шийдвэрийг биелүүлэх арбитрын ажиллагааны тухай хуулиар үйл ажиллагааг нь зохицуулна.
15.	Швед	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг.	Шведийн арбитрын актад тусгайлан заагаагүй. Гэхдээ Стокольмын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд арбитрын шүүх бий.
16.	Швейцар	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаггүй. Арбитрын тусгайлсан хуульгүй.	Швейцарьд олон улсын худалдааны танхимын арбитрын шүүх ажиллахаас гадна Цюрихын Худалдааны танхимд арбитрын шүүх байхгүй ч танхимын зөвлөлөөс томилсон арбитрын хороо бий.

17.	Эквадор	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Хуульдаа тусгайлан заагаагүй ч энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс аж үйлдвэрийн танхим, холбоо, нэгдэл, ангийн бус сангууд нь арбитрын төвийг ажиллуулж болохыг заасан. Гэхдээ тэд Эквадорын худалдааны танхимуудын холбоонд бүртгүүлсэн байх шаардлагатай. Энэ хуулийг батлахаас өмнө үйд ажиллагаагаа эхэлсэн байсан арбитрын төвүүд нь мөн бүртгэгдсэн байх ёстой.
18.	Эстони	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай актаар зохицуулсан.	Эстонийн Бүгд найрамдах Улсын Эстонийн худалдаа аж үйлдвэрийн танхимын арбитрын шүүхийн тухай актаар арбитрын шүүх Эстонийн худалдаа аж үйлдвэрийн танхимын байгуулсан байнгын арбитрын шүүх байхыг заасан байна. Арбитрын шүүх нь Танхимын шууд хараан дор ажилладаг бөгөөд арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлэх, маргаан шийдвэрлэх журмыг танхим баталдаг.

2. Англо-Саксоны эрх зүйн системтэй улс орнууд⁴

№	Улс орны нэрс	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1.	АНУ	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	АНУ-ын муж бүр тусдаа арбитрын тухай эрх зүйн зохицуулалттай. Гэхдээ АНУ нь Арбитрын тухай нэгдсэн хуультай. Энэ хууль бүх мужийн хувьд үндсэн зарчим болж үйлчлэх тул нарийн зохицуулалтын хэм хэмжээ агуулаагүй. АНУ-ын арбитрын зөвлөл бие даасан, хараат бус, ашгийн төлөө бус, олон нийтийн байгууллага буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани байдаг.
2.	Австрали	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Олон улсын арбитрын актаа Юнситралын загвар хуульд үндэслэн гаргасан. Тус актаар Юнситралын загвар хуулийг олон улсын арилжааны арбитрт хэрэглэх болохыг заасан. Австралийн арбитрчдын болон эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл нь бие даасан, хараат бус, ашгийн төлөө бус, олон нийтийн байгууллага буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани байдаг.

⁴ Монголын үндэсний хуульдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх гадаад хуульдааны арбитрын 2002 оны 9 дүгээр сэрл хийсэн судалгаа, Арбитрын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэхэд зориулсан судалгааны материалыас МҮХАҮТ, Уб: 2003 он.

3.	Англи	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Арбитрын тухай актад танхимын талаар тусгаагүй. Английн Лондонгийн Олон улсын арилжааны шүүх дэлхийн хамгийн том арбитрын төвүүдийн нэг юм. Уг арилжааны шүүх нь бие дааж, хараат бус, ашгийн төлөө бус, олон нийтийн байгууллага буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани байдаг.
4.	Бразил	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Бразилийн танхимуудад арбитрын ажиллагаа эрхэлдэг алба, хэлтэс байхгүй.
5.	Канад	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Арбитрын ажиллагааг хувийн байгууллага эрхлэн явуулдаг. Канадад маргаан шийдвэрлэхтэй холбоотой 50 гаруй холбооны хууль тогтоомж байдаг. Арбитрын үйл ажиллагааг зохицуулсан холбооны хууль нь Юнситралын загвар хуульд үндэслэгдсэн Арилжааны арбитрын тухай хууль юм. Муж бүр Юнситралын загвар хууль болон Нэгдсэн Вант Улсын 1899 оны Арбитрын актад үндэслэсэн арбитрын хуультай. Холбооны хуулиас гадна Канадын холбооны шүүхийн журмууд нь арбитрын үйл ажиллагааг зохицуулсан зүйл заалттай.

6.	Шинэ Зеланд	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Шинэ Зеландын арбитрын тухай акт Юниситралын загвар хуульд үндэслэгдсэн.
7.	Малайз	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Малайзын арбитрын төв нь хэдийгээр Засгийн газраас дэмжлэг авдаг ч ангийн төдөө бус байгууллага бөгөөд төрийн бус байгууллагын дэргэд байгуулагдах байна.
8.	Мексик	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Мексикийн худалдааны хууль, танхим ба түүний холбоодын тухай хуулиар арбитрын ажиллагааг зохицуулсан.
9.	Гондурис	ХАҮТ-ын дэргэд байрладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын танхим нэг хэлтэс болж ажилладаг. Хуулиар танхим арбитрын шүүх байгуулж болохыг зөвшөөрсөн. Тус хуулиар бие даасан арбитрын байгууллага байгуулахыг хориглосон.
10.	Энэтхэг	ХАҮТ-ын дэргэд байрладаг.	Энэтхэгийн Засгийн газар болон Худалдаа, аж үйлдвэрийн танхимын нэгдсэн хурлаас байгуулдаг.
11.	Индонези	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Арбитрын үндэсний зөвлөл бие даасан хуулийн этгээд юм. Энэ зөвлөлийг танхимын дэмжлэгтэйгээр байгуулсан бөгөөд танхимтай нягт холбоотой ажилладаг.

3. Социалист эрх зүйн системтэй улс орнууд⁵

№	Улс орны нэрс	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1.	БНАСАУ	ХАҮТ-ын дэргэд байдаггүй.	Эдийн засгийн маргааныг шийдэх ажиллагааг Солонгосын олон улсын худалдааны Арбитрын хороо ба Солонгосын далайн арбитрын хороо эрхэлж явуулна.
2.	Хятад	ХАҮТ-ын дэргэд байдаггүй. Арбитрын тухай хуулиар зохицуулсан.	Гадаадын хэрэг, маргаантай холбоотой арбитрын тухай тусгай зохицуулалтыг Хятадын арбитрын тухай хуульд оруулсан байна. Гадаадын хэрэг, маргааныг шийдэх арбитрын хороог Хятадын олон улсын худалдааны танхим байгуулж болно.

⁵ Монголчиг үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх гадаад худалдааны арбитрын 2002 оны 9 дүгээр сард хийсэн судалгаа. Арбитрын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцээнд зориулсан судалгааны материалыгс. МҮХАҮТ У-6: 2003 он.

4. Шашны эрх зүйн системтэй улсууд⁶

№	Улс орны нэрс	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1.	Египет	ХАҮТ-ын дэргэд байдаггүй.	Каирын төл Юнситралын загвар хуулийг шууд хэрэглэдэг.
2.	Бахрейн	ХАҮТ-ын дэргэд байрладаг. Уг харилцааг арбитрын тухай актаар зохицуулсан.	Юнситралын загвар хуулийг шууд хэрэглэхээр хуульдаа заасан.
3.	Лебанон	ХАҮТ-ын дэргэд байрладаг.	Лебаноны Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд байнгын арбитр ажилладаг бөгөөд Лебаноны цорын ганц арбитрын байгууллага юм.
4.	Арабын нэгдсэн Эмират улс	ХАҮТ-ын дэргэд байрладаг. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулдаг.	Дубай мужийн хувьд Дубайн худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль батлагдсанаар арбитрын байгууллагыг танхимын дэргэд байгуулахаар заасан байдаг.
5.	Катар	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр байдаг.	Худалдаа аж үйлдвэрийн тухай хуулиар байнгын арбитрыг танхимын дэргэд байхаар зохицуулсан.

⁶ Мин тэмд

5. Дорнын эрх зүйн системтэй улс орнууд⁷

№	Улс орны нэрс	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1.	БНСУ	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр нь байрладаггүй.	Дотоодын ба олон улсын арилжааны маргааныг шударга, хурдан шийдэх мөн энэхүү хуулиар гадаад эдийн засгийн хэлцлийн дэг журмыг бий болгох үүднээс Засгийн газраас Худалдаа аж үйлдвэрийн сайдын байгуулсан арилжааны арбитрын үйл ажиллагааг эрхлэх байнгын арбитрыг байгуулах зардлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн гаргана. Энэхүү хуулийг батлахаас өмнө үйл ажиллагаагаа эрхэлж байсан Солонгосын арбитрын зөвлөл нь Сайдын байгуулсан байнгын арбитр адил тооцогдох бөгөөд түүний дүрмийг Солонгосын Дээд шүүхээс баталсан гэж тооцно.

Англи-саксоны эрх зүйн системтэй улс орнуудад байнгын арбитрын байгууллага Танхимын дэргэд бус харин бие даасан хэлбэрээр, ихэвчлэн хууль зүйн товчооны хэлбэрээр байгуулагдсан байна. Харин Ром-Германы

⁷ Мөн тэнд

буюу эх газрын эрх зүйн системтэй улс орнууд болон пост социалист системтэй улс орнууд байнгын арбитражыг ХАҮТ-ын дэргэд байгуулахаар хуульчилсан байна. Социалист системтэй улс орнууд арбитражыг ямар байгууллага байгуулах болон түүний эрх зүйн зохицуулалтын талаар хатуу хуульчлан тогтоосон байхад Лалын буюу шашины эрх зүйн системтэй улс орнууд (Арабын улсууд) Арбитрын Нэгдсэн Холбоо байгуулж түүгээр дамжуулан маргааныг хянан шийдвэрлэдэг байна. Мөн зарим шашины эрх зүйн тогтолцоот хөгжингүй улсууд арбитрын шүүхийг байгуулсан байна. (Арабын нэгдсэн Эмират Улс, Египет гэх мэт) Шашины эрх зүйн тогтолцоот улсууд шариадын хууль зэрэг шашины номлолыг үндэслэн маргааныг шийддэг тул талууд өөр бусад олон улсын арбитрын байгууллагаар маргаанаа шийдвэрлүүлэхээр тохиролцдог байна. Харин Дорнын эрх зүйн системтэй улс орнууд маргааныг шүүх, арбитраж шийдвэрлүүлэхээс илүү урьдчилж зуучлал, хэлэлцээний аргаар шийдвэрлэдэг практиктэй байна.⁸

2.3. Арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцоо

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах, арбитрч томилуулах, татгалзан гаргах нь шүүхийн практикт ердийн журмаар шийдвэрлэгдэж байгаа бөгөөд ердийн журмаар гэдэг нь нэхэмжлэлээр болон гомдлоор хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхийг хэлнэ.

Нэхэмжлэлээр болон гомдлоор үүсэх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн материаллаг эрх зүйн харилцаа зөрчсөнтэй холбоотой маргаан шийдвэрлэхийг хэлэх ба хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах, хариуцагч нэхэмжлэлээсээ татгалзах, хүлээн зөвшөөрөх, эвлэрэх гэх мэт хэргийн оролцогчдын нийтлэг эрх, үүргийг хүлээдэг.

Ердийн журмаар буюу нэхэмжлэл, гомдлоор үүссэн иргэний хэргийн зорилго нь иргэн, хуулийн этгээдийн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой зөрчигдсөн эрхийг сэргээх, эрхийн маргааныг шийдвэрлэхэд оршдог. Тиймээс манай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай⁹ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д "эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл", 12.1.2-т "бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл"-д шүүх иргэний хэрэг үүсгэнэ гэж заасан.

Харин онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх

⁸ Мөн тэнд 81.

⁹ Төрийн мэдээлэл сэтгүүл У6: 2002 он, №7-д нийтлэгдсэн.

ажиллагааны зорилго нь эрх зүйн ач холбогдолтой үйл явдал¹⁰, үйлдлийг шүүхээс тогтооход орших ба энэ нь хүсэлт гаргагч буюу сонирхогч этгээд байхыг ойлгоно. ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т “Онцгой ажиллагааны журмаар хэрэг, маргаан хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдийн гаргасан хүсэлтээр” шүүх иргэний хэрэг үүсгэнэ гэснээс үзвэл Арбитрын тухай хуулийн 15.5, 17.4 дэх хэсэгт заасан зүйлүүд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж болох эрх зүйн үндэслэл болно.

Онцгой ажиллагааны журмаар хэрэг, маргаан хянан шийдвэрлэх маргааны төрлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлд заасан ба үүнд:

133.1.1. эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох¹¹;

133.1.2. хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах;

133.1.3. сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдэгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох;

133.1.4. хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох;

133.1.5. асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох;

133.1.6. эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх;

133.1.7. иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох;

133.1.8. хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх;

133.1.9. нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах;

133.1.10. хуулийн этгээдийг дампуурсанд тооцох.

Онцгой ажиллагааны журмаар хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүхийн зорилт нь тодорхой хууль зүйн үйл баримт байгаа ба байхгүй байгааг тогтоох, иргэний эрх зүйн тодорхой байдлыг хүлээн зөвшөөрөх, иргэний эрхийг сэргээн тогтоох замаар иргэн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалахад оршино.¹² Өөрөөр хэлбэл,

¹⁰ ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.1-д зааснаар “Иргэн, хуулийн этгээдийн эдийн ба эдийн бүс, баялагтай холбоотой эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгахар болоход шууд хамаарах үйл явдлыг эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэнэ”.

¹¹ ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.2-т заасан. ¹² ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.2-т заасан.

¹² Нарангэрэл.С. Эрх зүйн эх тогтоо бичиг. Анхны хэвлэл, Ув: 353 дэх тал.

онцгой ажиллагаа¹³ нь хэн нэгний зөрчигдсөн эрхийг сэргээх талаар шаарддаггүй, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн хэрэг (маргаан) биш бөгөөд гэм хорыг арилгах, нөхөн төлбөр гаргуулах гэх мэтийг шаарддаггүй. зөвхөн тодорхой үйл явдлыг (факт) тогтоолох зорилготой.

Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь хэд хэдэн онцлог шинжтэй:

1. Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтэд үндэслэнэ. Энэ хүсэлт нь ямар нэгэн этгээдээс хандаж гаргасан шаардлага биш. Бас зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, маргаантай эрхийг хамгаалахыг шаарддаггүй;

2. Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаанд материаллаг эрх зүйн маргаан байдаггүйгээс улбаалан хэрэгт эсрэг сонирхолтой этгээд байдаггүй. Харин энэхүү ажиллагааны явцад иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар гуравдагч этгээдээр оролцож болно. Тухайлбал, арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай талуудын хүсэлтийг хянан шийдвэрлэх явцад МҮХАУТ-ын дэргэдэх Үндэсний арбитраас шүүх хуралдааны үед шүүхэд мэдүүлэх эрхээ¹⁴ эдлэх бөгөөд энэ тохиолдолд гуравдагч этгээдээр оролцож байна гэж үзнэ;

3. Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал болон иргэний эрх зүйн байдлыг тогтооно. Энэ нь эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бий болгодог.¹⁵

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал тогтоох нь яагаад онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж байгаа үндэслэлийг авч үзвэл:

Шүүхээр ердийн журмаар хянан шийдвэрлэгдэж буй хэрэг, маргаан нь иргэн, хуулийн этгээдийн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой байдаг бол онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэж буй хэрэг нь эрхийн маргаангүй, зөвхөн тодорхой үйлдэл, үйл явдлыг тогтоолох юм. Тухайлбал, арбитрч томилох, татгалзан гаргах тухай хүсэлт гаргагчийн эсрэг сонирхолтой этгээд байхгүй ба зарим тохиолдолд үндэсний арбитр гуравдагч этгээдийн хувиар шүүх хуралдаанд тайлбар хийдэг байна. Үүний гол

¹³ С.Нарангэрэлийн "Эрх зүйн эх төлөг бичиг"-т дурдсанаар "Онцгой ажиллагаа" гэдэг нь сонирлогч талуудын хооронд эрх зүйн тухай маргаангүй талаарх иргэний шүүн таслах ажиллагааны онцгой төрөл.

¹⁴ Нийслэлийн шүүхийн 2008 оны 17 дугаар тогтоол. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай талуудын хүсэлтийг хянан шийдвэрлэхэд МҮХАУТ-ын дэргэдэх Үндэсний арбитраас гуравдагч этгээдээр оролцож тайлбар гаргасан.

¹⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Арван гуравдугаар бүлэг, 324 дэх тал.

мөн чанар нь арбитрын ажиллагаанд оролцогч талуудын хооронд үүссэн эрхийн маргааныг шийдвэрлүүлэхийн тулд түүний өмнө зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай бодит үйлдлийг тогтоолгоход оршино.

Арбитрын тухай¹⁶ хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д "Аль нэг тал нь арбитрч томилох тухай нөгөө талын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн талын арбитрчийг томилоогүй, эсхүл томилогдсон хоёр арбитрч 30 хоногийн дотор гурав дахь арбитрчийг тохиролцон томилж чадаагүй бол сонирхогч талын¹⁷ хүсэлтээр давж заалдах шатны шүүх тэдгээрийг томилно", 17.4-т "Талуудын тохиролцсон журам болон энэ хуулийн 17.2, 17.3-т заасны дагуу арбитрчийг татгалзан гаргаж чадаагүй бол сонирхогч тал тухайн арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүх болон байнгын арбитрын дүрэмд заасан эрх бүхий этгээдэд энэ тухай хүсэлт гаргаж болно" гэсэн нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтооход чиглэгдэж байгааг харуулж байна.

Арбитрч томилох, түүнээс татгалзах, арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах (Арбитрын тухай хуулийн 40.2.1), арбитрын шийдвэрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай талуудын хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж болох эсэх үндэслэлийг авч үзвэл:

Арбитрч томилох (Арбитрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг)

"Аль нэг тал арбитрч томилох тухай нөгөө талын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн талын арбитрчийг томилоогүй, эсхүл томилогдсон хоёр арбитрч 30 хоногийн дотор гурав дахь арбитрчийг тохиролцон томилж чадаагүй бол сонирхогч талын хүсэлтээр давж заалдах шатны шүүх тэдгээрийг томилно" гэж заасан ба талууд арбитрын шийдвэрийг хараат бус, бие даасан, бодитой гаргах чадвартай байна гэдэгт талуудад итгэл үнэмшил төрүүлэх, хэрэг маргаанаа түргэн шуурхай шийдвэрлүүлэх ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, маргаанаа богино хугацаанд, шударга шийдвэрлүүлэх урьдач нөхцөлийг хангаж байгаа учир нь энэ нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал болно.

¹⁶ Түрлийн мэдээлэлт сэтгүүл 2003 он, №20.

¹⁷ Арбитрын тухай хууль болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд "Сонирхогч тал" гэсэн нэр томъёог хэрэглэсэн байх бөгөөд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад сонирхогч тал гэсэн нэр томъёог хэрэглэсэн зүйл байхгүй. Улсын дээд шүүхээс үүнтэй холбоотой албан ёсны тайлбар гаргалагүй байна. Сонирхогч тал гэдгийг Монгол хэлний тайлбар томд эхрэн тайлбарласныг авч үзвэл "Сонирхогч" гэдгийг сонирхолд хүнийг хэлнэ, сонирхогч этгээд гэж сонирхож буй талыг ойлгоно гэж тайлбарласан байна. Энэ нь ИХШНШТХ-ийн зохиогчийн талаарх ойлголтыг агуулсан байх ба ИХШНШТХ-ийн 26 дугаар зүйлд зааснаар "Хэргийн зохиогч гэдэгт нэхээсэлэгч, харуулагч хууль заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувил нийлж эрх, үүргийгтэйгээр хэрэгт оролцох байгаа этгээд хамаарна" гэжээ.

Шүүх арбитрчийг томилохдоо дараах зүйлийг шалгуур болгоно. Үүнд:

1. Арбитрчаар томилох хүн нь хуульд заасны дагуу арбитрчаар томилогдох боломжтой эсэх;
2. Маргааныг бие даан, хараат бусаар шийдвэрлэх чадвартай эсэх;
3. Тухайн арбитрчаар томилох гэж буй хүн талуудын тохиролцсон шалгуурыг хангаж буй эсэх;

Шүүх эдгээр зүйлийг нягтлан шалгасны үндсэн дээр арбитрчийг томилох тухай шийдвэр гаргана. Шүүх Арбитрын тухай хуульд заасан дээрх асуудлыг шийдвэрлэхдээ аймаг, нийслэлийн шүүхийн шүүгч захирамж (шүүх тогтоол) гаргана. Эдгээр асуудлаар гарсан давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.¹⁸ Тухайлбал, уг захирамж, тогтоол хяналтын шатны шүүхэд хянагдахгүй гэж ойлгож болно.¹⁹ Түр арбитрын хувьд Арбитрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "арбитр нь байнгын болон түр хэлбэртэй байна", 5.7-д "Түр арбитрыг маргагч талууд тухай бүр бичгээр тохиролцон байгуулна" гэсэн нь түр арбитрт байгуулж болох эрх зүйн үндэс болох ба хуулийн 5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар байнгын болон түр арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагаа адил зарчмаар явагдана гэжээ. Дээрх заалтаас харвал түр арбитрын арбитрч томилох нь байнгын арбитрын адил зохицуулалт үйлчилнэ гэж болно. Шүүхээс арбитрч томилох эрх зүйн үндэслэл нь олон улсын арилжааны арбитрын тухай хуулийн загвар заалтын 11.3-т зааснаар талууд арбитрчаа томилж чадаагүй бол шүүх арбитрчийг томилоно гэжээ. Энэ нь талуудад арбитрч томилох эрхийг олгосон боловч энэхүү эрхээ хэрэгжүүлж чадаагүй, эрхийн маргаанаа шийдвэрлүүлэх урьдач нөхцөлийг тогтоож чадаагүй тул шүүхээр тодорхой үйлдэл хийлгүүлэхээр гаргаж буй хүсэлт юм.

Арбитрчийг татгалзан гаргах (Арбитрын тухай хуулийн 17 дугаар зүйл)

Арбитрын тухай хуулийн 17 дугаар зүйлд татгалзан гаргах журмыг тодорхойлохдоо:

- Арбитрчийг татгалзан гаргах журмыг талууд харилцан тохиролцоогүй;
- Арбитрчийг татгалзан гаргах журмыг харилцан тохиролцсон боловч уг журмын дагуу арбитрчийг татгалзан гаргаж чадаагүй бол.

¹⁸ Арбитрын тухай хууль "Давж заалдах шатны шүүхийн шийдвэр" гэж заасан бөгөөд Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын "Арбитрын хуулийг давж заалдах шатны шүүхэд хэрэглэх талаар" гаргасан зөвлөмжид уг шийдвэр нь шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гарна хэмээн тодорхойлжээ.

¹⁹ Хууль дээдлэх ёс сэтгүүл 2006 он, №2, 35 дахь тал.

Дээрх хоёр тохиолдолд арбитражийг татгалзан гаргах хүсэлтийг арбитраж бүрэлдэхүүнд бичгээр гаргаж болохоор хуульчилсан. Мөн арбитражаар томилогдсон хүн арбитражаас санаачилгаараа татгалзаж болно. Энэ тохиолдолд талууд зөвшилцсөнөөр татгалзан гарна. Үүнээс бусад тохиолдолд татгалзан гаргах эсэхийг тухайн арбитраж бүрэлдэхүүн шийдвэрлэнэ. Үүнтэй холбоотой хуулийн заалтаас үзвэл арбитраж санаачилгаараа татгалзсан бол тухайн арбитраж бүрэлдэхүүн шийдвэр гаргах шаардлагагүй, харин талууд зөвшөөрсөн тохиолдолд татгалзан гарсанд тооцож болохоор байна.²⁰

Арбитражийг татгалзан гаргаж чадаагүй тохиолдолд шүүх оролцох боломжийг Арбитраж тухай хуульд зохицуулсан ба сонирхогч тал арбитраж бүрэлдэхүүний шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хүсэлт гаргаж болно гэжээ. Харин шүүх дээрх хүсэлтийг хүлээн аваад хэрхэн шийдвэрлэх болон ямар шүүхийн шийдвэр эцсийн байх талаар заагаагүй, зөвхөн 17.5-д “Энэ хуулийн 17.4-т заасан маргаантай асуудлаар гаргасан эрх бүхий этгээдийн шийдвэр эцсийн байна” гэжээ. Арбитражийг татгалзан гаргаж чадаагүйгээс шүүхээр арбитраж томилуулах асуудал нь арбитраж ажиллагаа явагдсаны дараа буюу арбитражийг томилогдсоны дараах хүсэлт гэж ойлгож болно.

Хэдийгээр арбитраж томилогдсоны дараах үйлдэл боловч энэ нь арбитраж шийдвэр үндэслэлтэй болоход шууд чиглэгдсэн эрх зүйн ач холбогдол бүхий үйлдэл болно.

Арбитраж тухай хууль батлагдсанаас хойш арбитраж шийдвэрийг хүчингүй болгуулах тухай талуудын хүсэлтийн дагуу нийслэлийн шүүхийн хянасан хэргийн дотор арбитраж бүрэлдэхүүн томилохтой холбоотой гарсан маргаан нэг удаа гарсан бөгөөд (хэргийн дугаар 27 тоот²¹) хариуцагч шүүхэд гаргасан хүсэлт, тайлбартаа “... арбитражийг татгалзан гаргах эсэх” асуудлыг шийдвэрлэхдээ арбитраж тухай хуулийн 18.1, 19.1, 15.4, 40.2.2 дахь хэсгийн заалтуудыг зөрчсөн гэжээ. Гэтэл талуудаас томилогдсон хоёр арбитраж гуравдагч арбитражийг томилоход энэ талаар гомдол гаргаагүй арбитраж бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэхдээ дээрх хуулийн заалтуудыг зөрчөөгүй гэж үзээд арбитраж шийдвэрт ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй байна.

²⁰ Иргэний хэргэ шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйл шүүх, иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хуульд заасан үндэслэл байвал татгалзан гарал үүрэгтэй бөгөөд татгалзан гарал асуудлыг шүүх бүрэлдэхүүн (шүүх) шийдвэрлэх тасалгаанд хэлэлцэж Тогтоол (Засварж) гарган шийдвэрлэнэ.

²¹ Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн төв эрхлэл, 2008 оны хэргийн хяналт.

Арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах (Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 40 дүгээр зүйлийн 40.2.1 дэх хэсэг)

Арбитрын хэлэлцээр гэж Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар "гэрээний шинж, хэлбэр агуулсан эсэхээс үл хамааран аль нэг эрх зүйн харилцаатай холбогдон үүссэн буюу үүсч болох бүх төрлийн, эсхүл тодорхой төрлийн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх талаар талуудын хооронд хийсэн тодорхой төрлийн хэлцлийг хэлнэ". Иргэний хуулийн 39 дүгээр зүйлд "Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригтоо илэрхийлсэн"²² иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг хэлцэл гэнэ" гэж тодорхойлжээ. Мөн Олон улсын арилжааны арбитрын хуульд "Арбитрын хэлэлцээр нь талуудын хооронд ямар нэг эрхийн харилцаатай холбоотой үүссэн буюу үүсч болох тодорхой маргааныг арбитраар шилжүүлэх тухай гэрээний шинжтэй эсэхээс хамаарахгүй тохиролцсон тохиролцоо мөн" гэж заасан. Үүнээс харахад арбитрын хэлэлцээр болон иргэний эрх зүйн хэлцэл нь агуулгын хувьд ижил буюу аль аль нь талуудын хүсэл зоригтоо илэрхийлсэн байхыг шаарддаг.

Хэлцлийг амаар²³ болон бичгийн хэлбэрээр хийж болох ба бичгийн хэлцэлд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог. Бичгээр хийсэн хэлцэл нь арбитрын хэлэлцээртэй агуулгын хувьд ижил байна. Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын 2004 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр²⁴ гаргасан Арбитрын тухай хуулийг давж заалдах шатны шүүхэд хэрэглэх талаар зөвлөмжийн 7 дугаар зүйлд зааснаар Арбитрын хэлэлцээрийг дараах тохиолдолд байгуулсан гэж үзнэ. Үүнд:

1. Талуудын гэрээ арбитрын тухай заалттай;
2. Талууд арбитраар маргаанаа шийдвэрлэхээр гарын үсэг зурсан баримт үйлдсэн;
3. Талууд арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг нотлох хоорондоо солилцсон захидал, харилцаа;
4. Маргаан гарсны дараа арбитраар маргаанаа шийдвэрлэхээр тохиролцсон тохиролцоо зэрэг болно гэжээ.

Тухайлбал, талууд гэрээндээ "Энэхүү гэрээ, түүнтэй холбоотой цүссэн буюу гэрээг хэрэгжүүлэх, зөрчих, хүчингүй болгохтой холбоотой

²² "Хүсэл зориг" гэж тодорхой этгээдийн иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох буюу хэлцэл хийх зэмлэхээнийг эзлэх бөгөөд уг зэмлэхээний гадаад илэрлийг хүсэл зоригийн илэрхийлэл гэж ойлговол зохино.

²³ Талууд хэлэлцэл тохиролцсон, хэлцэл хийснийг нотолсон пайз, тасалбар зэргийг олгосон бол хүчинтэй байна.

²⁴ Улсын дээд шүүхийн мэдээлэл 2005 он. №1.

аливаа маргааныг Монголын Үндэсний худалдаа аж чйлдвэрийн танхимын дэргэдэх Үндэсний арбитрын шүүхээр, түүний хэрэг хянан шийдвэрлэх дүрлийн дагуу шийдвэрлүүнэ” хэмээн тусгаж болно.

Дээр дурдсаныг дүгнэн үзвэл арбитрын хэлэлцээр иргэний эрх зүй дэх хэлцлийн хэлбэрийг агуулсан буюу арбитрын хэлэлцээр нь иргэний эрх зүй дэх бичгийн хэлбэрээр байгуулсан хэлцэл гэж тайлбарлаж болох ба энэ талаар М.М. Богуславскийн “Олон улсын хувийн эрх зүй” номонд тэмдэглэгдсэн байдаг.²⁵

Дээд шүүхийн зөвлөмжид Арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлоход дараах асуудлыг тодорхойлно:

1. Тухайн хэлэлцээрийг эрх зүйн чадамж бүхий этгээд байгуулсан эсэх²⁶;

2. Тухайн хэлэлцээрээр арбитрын маргаан шийдвэрлэхээр тохиролцсон эсэх зэргийг анхаарч үзэх ба энэ шаардлагыг хангаагүй бол арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулна.

Иргэний хуулийн 56 дугаар зүйлд хэлцлийг хүчин төгөлдөр бус байх нөхцөлүүдийг заасан ба арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл нь мөн үүнд хамаарна. Иргэний хуульд зааснаар хүчин төгөлдөр бус хэлцлийг сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр анхан шатны шүүх хүчин төгөлдөр бусад тооцдог ба арбитрын хэлэлцээрийг талуудын гаргасан хүсэлтээр давж заалдах шатны шүүх хүчин төгөлдөр бусад тооцно. Хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах нь зөрчигдсөн эрхийг сэргээхтэй шууд холбоотой ба онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх үндэслэлгүй. Учир нь, хэлэлцээр (хэлцэл) нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д зааснаар эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрхийн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэлээр иргэний хэрэг үүсгэдэг, нэхэмжлэл гаргагчийн эсрэг тал үүнийг эсэргүүцэх, хариу тайлбар гаргах гэх мэт эрхийг эдэлдэг. Энэ нь онцгой ажиллагааны журмаар хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, онцлогтой нийцэхгүй тул хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцох нь шүүхэд ердийн журмаар хянан шийдвэрлэгдэнэ.

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах (Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйл)

Арбитрын тухай хуульд зааснаар Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай аль нэг талын гаргасан хүсэлтийг тухайн арбитрын

²⁵ Богуславский, М.М. Олон улсын хувийн эрх зүй 2008 он, 450 дэлх тал.

²⁶ Иргэний хуулийн 56 дугаар зүйлд заасан

ажиллагаа явагдсан газрын харьяа давж заалдах шатны шүүх хэлэлцэнэ. Шүүх талуудын хүсэлтийг хүлээн авч шийдвэрийг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэх ба илэрхий байгаа зөрчлийг арбитрын бүрэлдэхүүнээр өөрөөр нь засуулах хүсэлт гаргасан бол шийдвэр дэх зөрчилтэй асуудлыг хянах тодорхой хугацаа шүүхээс тогтоож болно.

Шүүх дараах тохиолдолд арбитрын шийдвэрийг хүчингүй болгоно.

1. Арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус бол;
2. Тухайн маргаан нь арбитрын харьяаллын маргаан биш байсан нь нотлогдсон;
3. Арбитрын бүрэлдэхүүн талуудын эрхийг хангаагүй;
4. Арбитрын ажиллагааны журмыг зөрчсөн;
5. Арбитрын бүрэлдэхүүн арбитрын хэлэлцээрт хамааралгүй асуудлаар шийдвэр гаргасан;

6. Арбитрын шийдвэр нь *ordre public*-т буюу нийтийн эрх ашиг сонирхолд нийцээгүй нь нотлогдсон.

Арилжааны арбитрын олон улсын загвар заалтын 34 дүгээр зүйлд "Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан үед хэрэв шүүх боломжтой гэж үзсэн эсхүл аль нэг тал хүссэн бол арбитраг хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг сэргээн явуулах боломж олгох, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлийг арилгах арга хэмжээ авахаар арбитраг санал гаргасан бол шүүх шийдвэр гаргахаар тогтоосон хугацааг түдгэлзүүлж болно" гэж заасан.

Мөн ИХШХШТХ-ийн 168.1, 168.3 дахь хэсэгт буюу шүүх хууль болон өөр хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй, хэргийн оролцогчдын шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжийг хангаагүй хэрэг шийдвэрлэсэн, хэргийн оролцогчийн хуулиар олгогдсон эрхийг ноцтой зөрчсөн, хууль бус бүрэлдэхүүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн, шийдвэрт шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зураагүй, эсхүл бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан, хуурамч нотлох баримт болон нотлох баримтыг шүүх дутуу үнэлсэн бол анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон бол давж заалдах журмаар хянан хэлэлцсэн шүүх тухайн хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаана гэсэн нь Арбитрын тухайн хуулийн 40 дүгээр зүйлд заасан үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох бус зөрчигдсөн эрхийг сэргээх үйл явдал учир ердийн журмаар шийдвэрлэдэг болохыг харуулж байна. Тиймээс Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх үндэслэлгүй юм.

Давж заалдах шатны шүүхэд 2006 онд 4, 2007 онд 6, 2008 онд 7.

2009 онд 2 удаа тус бүр арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай гомдол ирсэн ба үүнд талуудын эрх тэгш байх зарчмыг хангаагүй, нотлох баримтыг тал бүрээс бүрэн бодитой шинжлэн судлаагүй, арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамжийг хүчингүй болгуулах тухай гэх мэт хүсэлтүүд нийтлэг байлаа.

Дээрхийг дүгнэн үзвэл арбитрч томилох, татгалзан гаргахад онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж, болох ба харин хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, арбитрын шийдвэрийг хүчингүйд тооцуулах тухай талуудын хүсэлтийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэхдээ ердийн журмаар шийдвэрлэх талаар дурдсан.

Зарим гадаад улсын иргэний процессын хууль дахь онцгой ажиллагааны талаарх зохицуулалт

1. Хятадын Иргэний процессын хуулийн 12 дугаар бүлгийн 166 дугаар зүйлд²⁷ онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэг, маргааны төрлийг заасан ба үүнд:

- Сонгогчийн эрхийг хязгаарласантай холбоотой маргаан;
- Иргэнийг сураггүй алга болсонд тооцох болон иргэнийг нас барсанд тооцох тухай;
- Иргэний эрх зүйн чадвар, чадамжийг хязгаарласан болон чадвар чадамжгүйд тооцох;
- Эзэнгүй болон гээгдэл эд хөрөнгийг тодорхойлох гэх мэтийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг бөгөөд үүнээс бусад маргааныг ердийн журмаар шийдвэрлэдэг байна.

2. ОХУ-д Иргэний процессын хуулийн 22 дугаар зүйлд²⁸ зааснаар арбитрын шүүхээс гарсан шийдвэр болон гадаад улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхтэй холбоотой хэргийг шүүх хянан шийдвэрлэнэ гэж заасан ба тус хуулийн 262 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар дараах хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ гэжээ. Үүнд:

- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох;
- Хүүхэд үрчлэх;
- Иргэнийг нас барсан болон сураггүй алга болсныг тогтоох;
- Насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны иргэний бүрэн ба бүрэн бус чадамжийг хязгаарлахтай холбоотой хэргийн талаар;
- Иргэний чадвар, чадамжийг тогтоох;
- Эд хөрөнгө тогтоох болон сонгуулийн эрхийг тогтоох;

²⁷ http://www.moscow.go.mn/civil_procedure_low.html (сүүлд үзсэн 2011.03.29)

²⁸ http://www.moscow.go.mn/foreign_138FZ_10.doc (сүүлд үзсэн 2011.03.29)

- Бичиг баримт алдагдсанаас учирсан эрх сэргээх;
- Нотариатын үйлдэлтэй холбоотой маргаан;
- Сэтгэцийн өвчний улмаас иргэнийг сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх, гаргах;
- Иргэний эрх зүйн байдлыг өөрчлөх, засах.

III БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАА

1. Монголын үндэсний арбитр нь 1960 онд анх үүссэн бөгөөд 1995 онд Гадаад худалдааны арбитрын тухай хууль батлагдсанаар гадаад худалдаа, эдийн засгийн хэлцлээс үүдсэн болон гадаадын хөрөнгө оруулалттай компанийн үүсгэн байгуулагчдын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх Гадаад Худалдааны Арбитр нэртэй байгуулагдан ажиллаж байв. Үүний дараа 2003 онд Арбитрын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан нь олон талын ач холбогдолтой болсон. Тухайлбал, арбитрын маргаан шийдвэрлэх харилцаанд оролцож байгаа маргагч талуудад илүү өргөн эрхийг олгосон буюу талууд өөрсдөө тохиролцож, нэгдсэн шийдэл хүрсэн тохиолдолд ямар ч журмаар асуудлыг шийдэх боломжийг олгосон. Гэсэн хэдий ч Үндэсний арбитрын жилд шийдвэрлэж байгаа маргаан нь харьцангуй бага буюу иргэн, хуулийн этгээдийн арбитрын талаарх мэдлэг хомс байгаа нь судалгаанаас харагдаж байна. Арбитраар маргаан шийдвэрлүүлсэн иргэн, хуулийн этгээд нь арбитрын давуу талуудыг мэддэг боловч арбитрын зардал харьцангуй их байдаг тул дахин арбитрт хандахад эргэлзээ төрүүлж байна.

Шүүхээр маргаан шийдвэрлүүлэх эрх зүйн орчин арбитртай харьцуулахад илүү төлөвшсөн, шийдвэрт гомдолтой гэж үзвэл дараагийн шатанд хянуулах боломжтой байдаг тул шүүх нь арбитраас давуу талтай байдаг гэсэн ойлголт иргэдэд байдаг ба арбитрын ажиглагаанд оролцдог мэргэшсэн арбитрчид нь Монгол Улсад байнгын болон түр арбитрын аль аль нь ашигтай гэж үздэг байна.

2. Олон улсын хэмжээнд арбитрын байгууллагын хэлбэр олон янз байна. Англо-Саксоны ба Ром-Германы эрх зүйн бүлийн тогтолцооны тухайд ангилж үзэхэд Англо-Саксоны эрх зүйн системтэй орнуудад арбитрын байгууллага гол төлөв хязгаарлагдмал харилцаатай компанийн хэлбэрээр, харин Ром-Германы системийн тухайд ихэвчлэн нийгмийн нэгдэл бүхий хуулийн этгээдийн эсвэл худалдааны тапхимын дэргэд (харьяа) байгуулагддаг байна.²⁹

3. Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

²⁹ Japanese Arbitration Law: <http://iask.sina.com.cn/b/17830295.html> (сүүлд үзсэн 2011.03.29)

төсөлд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2003 оны Арбитрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн "Байнгын арбитраж хуралдаа аж үйлдвэрийн танхим, үйлдвэрлэгчдийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, тэдгээрийн нэгдлийн дэргэд байгуулж болно" гэсэн заалтыг хүчингүй болгохоор тусгасан нь байнгын арбитраж хурал, хэрхэн байгуулах нь тодорхойгүй болох төдийгүй эрх зүйн бүлийн хувьд авч үзвэл манай улсад тохирохгүй.

Олон улсын түвшинд АНУ-д Америкийн Арбитрын Холбоо, Англид Лондоны Олон Улсын Арилжааны Шүүх, Японд Арилжааны арбитраж зэрэг эдийн засгийн хөгжил, эрх зүйн төлөвшлөөр дээгүүр, өндөр хөгжилтэй улс орнууд байнгын арбитраж бие даасан институт гэж үзэн, аливаа байгууллагаас хараат бус, бие даасан байдлаар байгуулахаар зохицуулжээ.³⁷ Энэ нь арбитраж хөгжил, үзэл баримтлал тогтвортой хөгжсөн, нэг мөр болсонтой холбоотой юм.³⁸

Харин манай улсын хувьд: Ром-Германы эрх зүйн бүлд хамрагддаг, эдийн засгийн хөгжил нь өндөр хөгжөөгүй, иргэд нь эрх зүйн төлөвшил бага, арбитраж тухай мэдэгдэхүүн багатай зэргийг харгалзан үзэж арбитраж бие даасан, аль нэг байгууллагаас хараат бусаар байгуулах нь төдийлэн оновчтой бус байна.

4. Удирдамжийн гурав дахь хэсэгт дурдсаныг бүхэлд нь шүүх онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх үндэслэлгүй. Тухайлбал, Арбитрын шийдвэрийг хүчингүйд тооцуулах, хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, маргааны харьяалал тогтоох тухай талуудын хүсэлтийг шүүх онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх боломжгүй бөгөөд энэ нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой маргаан юм. Харин арбитражийг томилуулах, татгалзан гаргах нь эсрэг сонирхолтой этгээд байдаггүй, өөрөөр хэлбэл арбитраж томилох болон татгалзан гаргах эрхийг талуудад олгосон боловч тэрхүү эрхээ хэрэгжүүлж чадаагүй байдаг тул шүүх онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх нь онолын хувьд үндэслэлтэй юм.

Санал

1. Арбитрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Байнгын арбитраж Хуралдаа, аж үйлдвэрийн танхим, үйлдвэрлэгчдийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, тэдгээрийн нэгдлийн дэргэд байгуулж болно"

³⁷ Арбитрын тухай эдийн засгийн УИХ-аас хэлэлцэхэд зоригдсан зарим санал, судалгааны материал МҮХАҮТ 2003 он, 80 дахь тал.

³⁸ Мөн тэнд

гэсэн заалтыг өөрчлөх шаардлагагүй;

2. ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн “Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд” гэсний 133.1.11-д “Арбитрчйиг томилуулах, арбитрчйиг татгалзан гаргах” гэж нэмэх;


3. МҮХАҮТ-ын дэргэдэх Үндэсний арбитр нь өөрийн үйл ажиллагааны шүүхээс ялгагдах давуу талыг олон нийтэд зөв таниулан сурталчлах, хэвлэмэл материал тараах, мөн сонин, сэтгүүл, радио, телевизээр сурталчлах, зохиомжит нэвтрүүлэг хийх зэрэг таниулах үйл ажиллагаа явуулах;

4. Арбитрт хандах иргөн, хуулийн этгээдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор бодит байдалд нийцүүлж Арбитрын ажиллагааны зардлыг оновчтой тогтоох асуудлыг хуульчлах.



ШИНЭ НОМ

АНГЛИ-СОЛОНГОС-МОНГОЛ-ОРОС-ГЕРМАН ХУУЛЬ ЗҮЙН ТОЛЬ



Энэхүү толь бичиг нь БНСУ-ын Хууль зүйн судалгааны хүрээлэн болон Монголын Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2008 оноос хойш 3 жилийн турш хамтран хэрэгжүүлсэн төслийн үр дүн юм.

Энэхүү толь бичиг нь олон улсын харилцаа, олон улсын гэрээ, хэлэлцээр болон бусад хуулийн бичиг баримтын хууль зүйн нэр томъёог агуулсан юм. Мөн толь бичигт ашиглагдаж буй нэр томъёо нь олон улсын эрх зүйн болон олон улсын эрх зүйн баримтад ашиглагдаж байдаг нэр томъёо юм.

Уг толь бичиг нь олон улсын эрх зүйн оюутнууд болон олон улсын эрх зүйчдээр тогтохгүй бизнесмен, шүүгч, прокурор, хууль зүйн зөвлөх,

өмгөөлөгч, гадаад харилцааны ажилтан болон албаны хүмүүсийн хамгийн өргөн хэрэглээ болох буй за.

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат
хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит
илтгэлийн уралдаанд судлаачдын төрөлд
II байрт шалгарсан илтгэл

Үндсэн хууль бол хууль тогтоогчдод зориулсан хууль мөн



Улсын Их Хурлын Тамгын
газрын Эрх зүй, хуулийн
хэлтсийн ахлах зөвлөх,
докторант Л.Өлзийсайхан

Үндсэн хуулийг дээдэлнэ гэдэг нь хууль тогтоогчдын үндсэн үйл ажиллагааны алтан дүрэм юм. Тийм учраас Үндсэн хуулийг дээдлэх зарчим нь хууль тогтоогчдод шууд хамааралтай. Үндсэн хуулийг дээдлэх нь иргэнд болон засаг төрийн бусад байгууллага, албан тушаалтанд төдийлэн хамаатай зүйл биш. Харин тэд сахих, мэдэх, биелүүлэх үүрэгтэй. Үндсэн хуулийг дээдлэх нь сахих, мэдэх, биелүүлэхээс өөр зүйл.¹ Түүний үндсэн агуулга нь хууль тогтоогчид хууль тогтоохдоо түүнийг яс барь, түүнээс зөрсөн, гажсаныг бүү тогтоо, эргэлзээтэй зохицуулалт, хэм хэмжээ гарч ирвэл Үндсэн хуулийн талд, түүний үзэл баримтлалд нийцүүлэн хий гэсэн үг юм.

Парламентат ёстой улсад парламент ямагт ард түмний талд зогсдог юм. Тийм ч учраас хууль тогтоогчдоос баталсан хууль бүр нь формаль утгаараа хууль боловч “хуулийн амин сүнс”, “үндсэн эрх, хэм хэмжээний”

¹ Лүндэдорж Н. Шилжилтийн үеэс үлс төр, эрх зүйн асуудал Ув: 2010 он.

шалгуураар авч үзвэл хууль гэж хүлээн зөвшөөрөгдөх бодит чанарыг хангасан байх ёстой. Ийм хууль батлах явдал нь ард түмнийхээ өмнө хүлээсэн хууль тогтоогчдын гол хариуцлага. Түүний гол шалгуур, алсын (дээд) хязгаар нь Үндсэн хууль мөн.²

Үндсэн хууль бол нэг талаас төрийн аливаа эрх мэдлийг хязгаарлагч, нөгөө талаас хүний үндсэн эрхийн баталгаа мөн. Иймд хууль тогтоох байгууллагын бүхий л үйл ажиллагааны зорилго, бас хязгаар нь өдгөө хүний түгээмэл эрх, эрх чөлөөг хангахад чиглэгдэх учиртай. Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө гэсэн Хоёрдугаар бүлэгт хүний эрх, иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тунхаглаж өгсөн нь хууль тогтоогч хууль тогтоохдоо хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн хууль батлах эрхгүй гэдгийг, мөн Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Улсын Их Хурал, түүний гишүүний үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байх учиртайг хуульчилсан.

Хууль тогтоогч энэхүү Үндсэн хуулийн үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах нь тийм амар хялбар ажил биш. Үндсэн хуулийг жинхэнэ ёсоор хянаж, манадаг бие даасан хараат бус Үндсэн хуулийн шүүх ажиллаж байхаас гадна Үндсэн хууль, түүнийг дээдлэх үзэл хууль тогтоогчдын үйл ажиллагаандаа баримтлах үндсэн зарчим болж чадсан цагт хэрэгжинэ. Энэ нь бас хууль тогтоогчдын хууль зүйн болон ёс зүйн үүрэг, хариуцлагын гол шалгуур болно.

Монгол Улс ч ардчиллын энэ ололт, үнэт зүйлийг шинэ Үндсэн хуулиар хүлээн авч, төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим нь "хууль дээдлэх ёс"³ мөн гэжээ. Энэ бол Улсын Их Хурал өөрөө Үндсэн хуулиа, Засгийн газар, шүүх нь Үндсэн ба бусад хуулиа сахин биелүүлэх ёстой гэсэн Үндсэн хууль, хууль дээдлэх тухай Үндсэн хуулийн үзэл санаа, заалт юм. Ингэж хуульчилж өгсөн нь хүний эрх, эрх чөлөө улмаар нийгэмд эрх чөлөөт байдал тогтох Үндсэн хуулийн үндэс мөн.

Гэвч Үндсэн хууль бодитой оршихын шалгуур нь хууль тогтоох журмаар баталсан ямар нэг бичвэр байхын нэр огт биш. Үндсэн хууль байгаа эсэхийг хэлбэр дүрсээр нь бус бодит үйлчлэлээр хэмжих учиртай.⁴ Гэтэл өнөөдөр хууль тогтоогчид Үндсэн хууль зөрчсөн хууль батлах явдал бараг ердийн үзэгдэл болсноор Үндсэн хууль дээдлэх үзэл үгүйсгэгдэж, хомсдолд орж байна. Уул нь Үндсэн хууль бол хууль тогтоогчдод зориулсан хууль мөн.

Иймд Үндсэн хуульд тунхагласан (де юре) Улсын Их Хурал өөрөө

² Чинд Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуулт Уб: 2004 он.

³ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгэсэн.

⁴ Дүрэмлэж Н. Шилжилтийн үеийн төр, эрх зүйн асуулт Уб: 2010 он.

Үндсэн хуулиар хязгаарлагдах гэсэн зарчим нь бодит амьдралд хэрэгжиж байгаа (де факто) байдал ямар байгааг шинжилж үзье.

НЭГ. ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА

Үндсэн хуулийн цэц нь 1992 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар нийт 127 дүгнэлт гаргажээ. Үүнээс эрх зүйн акт Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаанаар 117 (нийт дүгнэлтийн 92.1%), эрх бүхий албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаанаар 10 (нийт дүгнэлтийн 8.1%) дүгнэлт гарчээ.¹ Дээрх судалгаанаас Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, УИХ-ын дарга, гишүүд Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Цэцийн дүгнэлт гарсныг тодруулахад:

1. Улсын Их Хурлын батлан гаргасан хууль, бусад шийдвэртэй холбоотой маргаанаар 104 (нийт дүгнэлтийн 81.9%) дүгнэлт гаргасны а. хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаанаар 97 (нийт дүгнэлтийн 76.3%); б. УИХ-ын тогтоол, бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаанаар 7 (нийт дүгнэлтийн 5.5%); в. УИХ-ын үйл ажиллагаа буюу хуралдааны процесс Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаанаар 1 (нийт дүгнэлтийн 0.78%) дүгнэлт байна. Харин УИХ-ын дарга, гишүүд Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаанаар 6 (нийт дүгнэлтийн 4.7% буюу УИХ-ын даргатай холбоотой 3, гишүүнтэй холбоотой 3) дүгнэлт гарчээ.

2. Үндсэн хуулийн цэцийн гаргасан нийт 127 дүгнэлтийн 71 нь Үндсэн хууль зөрчсөн байна гэж гарчээ. Үүнээс а. УИХ-аас хүлээн зөвшөөрсөн Цэцийн дүгнэлт 27 буюу нийт зөрчсөн гэж гарсан дүгнэлтийн 38%; б. УИХ-аас хүлээн зөвшөөрөөгүй Цэцийн дүгнэлт 42 буюу нийт зөрчсөн гэж гарсан дүгнэлтийн 59%; в. УИХ-аас хүлээн зөвшөөрсөн эсэхээ шийдвэрлээгүй, хэлэлцүүлгийн шатанд байгаа 2 дүгнэлт тус тус байна.

3. Үндсэн хуулийн цэцээс маргааныг эцэслэн шийдвэрлэсэн байдлыг харахад нийт 42 маргааныг эцэслэн шийдвэрлэж Үндсэн хуулийн цэцийн тогтоол гаргажээ. УИХ-ын хууль, бусад шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой маргаанаар нийт 38 (нийт тогтоолын 90.4%) тогтоол гаргасны: а. хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаанаар 35 (нийт тогтоолын 83.3%), б. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн дагуу хүчингүй болгосон хуулийн заалтыг дахин сэргээсэн эсэх тухай 1 маргаанаар, в. УИХ-ын тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх

¹ Үндсэн хуулийн цэцээс авсан мэдээлэл.

маргаанаар 2 (нийт тогтоолын 4.7%), г. УИХ-ын үйл ажиллагаа буюу хуралдааны процесс Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаанаар 1 тогтоол гарсан байна.

Энэ судалгаанаас харахад Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийг зөвхөн Улсын Их Хурлаас хамгаалж байна гэж дүгнэн хэлж болно. Улсын Их Хурал хууль тогтоохдоо Үндсэн хуулиа баримтлахгүй зөрчиж байгаа нь нийгэмд Үндсэн хуулийг дээдлэх үзлийг үгүйсгэсэн хэлбэр болно. Улсын Их Хурал хууль тогтоохдоо хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, төрийн эрх мэдэл хуваарилалтыг алдагдуулсан дээрх хуулуудыг батласнаар өөрөө хүний эрх, эрх чөлөөг хуулиар зөрчигч болж байна. Гэтэл Цэцээс гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрдөггүй. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэх хуралдаанд тайлбар авахуулахаар ирүүдсэн Цэцийн албан бичигт хэзээ ч хууль тогтоогчид бид Үндсэн хуулиа (нэг тохиолдоос бусад нь) зөрчжээ гэж хүлээн зөвшөөрдөггүй. Харин Үндсэн хуулийн агуулга, заалт, ач холбогдлыг үл хэрэгсэн Улсын Их Хурлаас баталсан бол "хамгаалах" ёстой гэсэн үзлээр онол, номоос гадуур муйхарлан сөрөг тайлбар өгч, хамгаалж байгаа⁶ явдал тогтсон жишиг болжээ. Ер нь ердийн хууль зөрчсөний учир гэм буруутныг тогтоож хариуцлага оногдуулдаг атал Үндсэн хууль зөрчсөн, түүнд халдсан эрх мэдэлтэнд хууэлэгдэг улс төрийн хариуцлагын төрлийг Улсын Их Хурал одоо хүртэл хуульчлахгүй байгаа нь Үндсэн хуулийн эсрэг үйлдэл мөн. Гэтэл хууль дээдлэх зарчмын суурь нь Үндсэн хуулийг дээдлэх явдал бөгөөд Улсын Их Хурал хууль тогтоохдоо Үндсэн хуулиа баримтлах нь ардчилал, эрх зүйт ёс, парламентат ёсыг монголд хөгжүүлэх, төлөвшүүлэх гол баталгаа, түүний ард түмний өмнө хүлээсэн гол хариуцлага.

ХОЁР. ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨН ХУУЛЬ ТОГТООГЧДЫН ХУУЛЬ

Улсын Их Хурал Үндсэн хууль болон бусад хуулиар хязгаарлагдаж байх ёстой. Хязгаарлагддаггүй гэдгээ Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр болон Үндсэн хуулийг зөрчсөн тухай Цэцийн дүгнэлт, тогтоолоор өөрсдөө нотолсон. Тийм учраас өөрөө өөрийгөө хязгаарлах хууль гаргах нь өнгөрсөн гэж зарим судлаач үзэж байна. Энэ бол Улсын Их Хурал гэж ямар байгууллага болсны хамгийн том нотолгоо юм. Уул нь ард түмнийг төлөөлсөн Улсын Их Хурал л гагцхүү Үндсэн хуулиар өөрөө өөрийнхөө хуулийг баталдаг ганц эрх мэдлийн байгууллага

⁶ Үндсэн хуулийн цэцэд Улсын Их Хурлаас гаргасан албан ёсны тайлбарууд, Цэцийн дүгнэлт, тогтоолууд УИХ-ын гишүүдээс өгсөн тайлбарыг уншихад тодорхой харагдана.

хувьдаа Үндсэн хуулийг зөрчих учиргүй. Тэгж байж Үндсэн хууль, хууль дээдлэх үзэл санаа хэрэгжинэ. Гэтэл Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлтийг:

1. Улсын Их Хурлын тухай хуулиар 9, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар 7, Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулиар 1, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар 2, Улсын Их Хурлын тогтоолоор 7 удаа⁷ тус тус гаргажээ;

2. 2008 оноос 2012 он хүртэлх сүүлийн дөрвөн жилийн хугацаанд Үндсэн хуулийн цэц эцэслэн шийдвэрлэж **тогтоол** гарсан нийт 10 хуулийн 6 нь⁸ Улсын Их Хурлын өөрийнх нь үйл ажиллагаа, зохион байгуулалт, сонгуулийн журмыг зохицуулсан үндсэн хуульчилсан буюу органик хууль болох Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиуд байгаа нь ноцтой дүгнэлтэд хүргэж байна.

2.1. Улсын Их Хурлын тухай хууль

1. УИХ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтаар "хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Засгийн газрын ажлын хэсэгт гишүүдийг оролцуулах асуудлыг Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн саналыг харгалзан шийдвэрлэх;"⁹ гэсэн бүрэн эрхийг 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлэхээр хуульчилжээ.

2. Мөн тус зүйлийн 11.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 11.3-т заасан Зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын дэд дарга, нам, эвслийн бүлгийн ахлагч, Улсын Их Хуралд суудал бүхий намын дарга-Улсын Их Хурлын гишүүн, Байнгын, түр хороодын дарга орно."¹⁰ гэжээ. Зөвлөл ямар чиг үүрэгтэйгээр ажиллахыг хуульчилсан мөн зүйлийн 11.3 дахь хэсэгт "Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг батлах, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл

⁷ http://www.conscourt.gov.mn/index.php_mn/decisions/constitutional-tsets-resolutions.

⁸ http://www.conscourt.gov.mn/index.php_mn/decisions/constitutional-tsets-resolutions.

⁹ Монгол Улсын Их Хурлын тухай хууль №6: 2011 он.

¹⁰ Монгол Улсын Их Хурлын тухай хууль №6: 2011 он.

(цаашид “Зөвлөл” гэх) Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана”¹¹ гэжээ.

Улсын Их Хурлын тухай хуулийн 11.1.13, 11.4 дэх хэсэгт заасан дээрх заалтууд нь өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа боловч Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтын “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биедэлтийг хянан шалгах”. Дочин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биедүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна. 2. Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.” гэсэн Үндсэн хуулийн төрийн эрх мэдэл хуваарлах, харилцан хяналт, тэнцэлтэй байх гэсэн үндсэн суурь зарчмуудыг тус тус зөрчжээ.

3. Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтаар “Улсын Их Хуралд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;” гэсэн “онцгой бүрэн эрх”-ийг олгосон байхад Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын тухай хуулийн Гишүүний бүрэн эрх гэсэн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад дээр дурдсан субъектүүдийг “эгүүлэн татах санал гаргах” эрхийг “нэмж” хуульчилжээ. Гэтэл Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “...гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.”, Жаран тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.”, Жаран зургадугаар зүйлийн Үндсэн хуулийн цэц... дараах маргаантай асуудлаар дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулна гэсэн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх” гэсэн заалтаас тус тус харахад Улсын Их Хурал, түүний гишүүдэд Үндсэн хуулиар “эгүүлэн татах санал гаргах эрх”-ийг огтоос хуульчилж өгөөгүй. харин бусад эрх бүхий субьектийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцдэг болох нь тодорхой байна. Тус заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх

¹¹ Мин талд.

гэсэн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг зөрчжээ.

4. Хуульд нарийн чанд, шударга хүндэтгэлтэй ханддаг газарт Үндсэн хуульд байгаа нэр томъёог өөрчлөн хэрэглэх ёсгүй. Гэтэл Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно." гэсэн заалтыг Улсын Их Хурлын тухай хуулийн 6.2 дахь хэсэгт "Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрийн хуулийг дээдлэн сахиж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая" хэмээн төрийн сүлдэнд тангараг өргөнө." гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсэгт Үндсэн хуулийн дээрх заалтыг ишлэл хийлгүй хууль зүйн техникийн хувьд шууд хуулбарлалт хийж, "Улсын Их Хурлын" гэсэн Үндсэн хуулийн үгийг хассан байна. Төрийн хуулийг дээдлэн сахиж гэснийг Үндсэн хуулийг гэж, төрийн хуулиас иргэний хууль руу гэсэн Үндсэн хуулийн үзэл баримтлал, Үндсэн хууль дээдлэх ёс хэмээхийн учрыг хууль тогтоогчид анхаарах цаг болжээ. Ийм чухал заалтыг хийхдээ Үндсэн хуулийн заалтыг задлахын оронд шууд хуулдаг нь хууль бүтээгчдийн сэтгэлгээний ядуурлын илрэл юм. Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлд Ерөнхийлөгч тангараг өргөхдөө "Үндсэн хуулийг дээдлэн сахиx" гэсэн нэр томъёогоор хуульчилж өгснийг ч гэсэн анхаарах. Хуульд бичих нэр томъёо нь хүртэл хууль зүйн шинжлэх ухаан юм.

Үндсэн хуулийг батлахад удирдлага болгосон онолын үзэл баримтлалыг мэдэлгүйгээр, ойлголгүйгээр санаатай болон санамсаргүй байдлаар энэ мэт "алдаа" хийн Үндсэн хуульчилсан буюу органик хуулиудыг батлан гаргах Үндсэн хууль дээдлэх үзлийн төлөвшилд сөрөг нөлөө үзүүлж байна. Үүнд, Үндсэн хуулийг үгүйсгэх, түүний заалт бүрийг хүчгүйдүүлэхэд хүргэж байгаа хууль тогтоогчид буруутай. Үндсэн хуулийн үзэл санааг зөв хэрэгжүүлэх, бусад хуулийг сайн боловсруулж гаргах хэрэгтэй байна. Гэтэл Улсын Их Хурлын тухай хуулиас гадна Эзсгийн газрын тухай, Шүүхийн тухай гэх мэт үндсэн хуульчилсан хуулиуд болох органик хуулиудаас Үндсэн хуулийн зөрчилтэй заалтуудыг олж харахад хэцүү биш. Энэ талаар судлаачдын гаргасан бодлогын тойм судалгаа¹², бүтээлүүдээс ч харахад тодорхой. Иймд хууль бүтээхийн хариуцлагыг монголд ухаарах цаг болсон.

2.2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль

¹² Монгол Улсад ирээдүйн зарчмыг бүс байдлыг бэхжүүлэх нь Бодлогын тойм судалгаа Уб: 2010 он.

Парламент өөрөө өөрийн дэгийг тогтоох нь түүнийг бусад төрийн байгууллага, тэр дундаа онцгойлон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас бие даасан байхын нэрэл буюу бэлгэ тэмдэг гэж үздэг байна. Үүнийг хууль тогтоох байгууллагын "үйл ажиллагааны хараат бус байдал" гэж нэрлэдэг.¹³ Нөгөө талаас парламентын дэг хуультай төстэй боловч хууль биш юм. Парламентын үйл ажиллагааны дотоод журмыг хуульчлах, хуулийн заалт болгон хэрэглэхэд хүндрэлтэй байдаг нь түүний хэм хэмжээний чанарын тал нь өөр бусад нийтийн эрх зүйн хэм хэмжээнээс огт өөр байдагтай холбоотой юм. Иймд аливаа орны парламентын хуралдааны дэгийн хэм хэмжээг "sui generis"¹⁴ эрх зүйн хэм хэмжээ гэж нэрлэдэг. Тодруулбал, хууль нь эрх, үүрэг бий болгож байхад дэг нь зарчмын хувьд зөвхөн хууль тогтоох байгууллага, түүний гишүүд аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаатай холбоотой бөгөөд хууль тогтоох байгууллагаас гадна хэрэгжүүлэх боломжгүй юм.¹⁵ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтын талаар Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид "үйл явцын буюу процессын журам бол "хуулийн амьдрах" хэлбэр гэдэг бөгөөд энэ талаар УИХ урт журамтай боловч эрх зүйн онолын түвшин хангалтгүй, чинсэн ба чинсэн бус, их, бага элдэв эрэмбийн зүйлийг сайтар ялгаж заагаагүй, нэлээд нь хуулиудыг хуульж, дэг болгосон байдалтай зэргийг хэлэхэд хэтрүүлэг болохгүй" гэж, мөн тэрээр цааш нь "УИХ-ын олон талт үйл ажиллагааны ангиллыг зөв хийж, эзэн, цаг хугацаа, хэмжээ зэргийг тод тогтоосон процессын хууль, түүний дээр ажилбарын журамчлалыг боловсронгуй болгох нь чухал."¹⁶

1. Хамгийн ноцтой нь Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтуудтай холбоотойгоор үүссэн асуудлыг Улсын Их Хурал нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаараа авч хэлэлцэх дэгийг одоо хүртэл боловсруулаагүй байгаа нь манай улсын парламент мэргэшээгүй гэж хэлэх хангалттай дүгнэлт болж байна. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 17, 18 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь заалт, мөн зүйлийн 3 дахь хэсэг, Гучин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гучин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гучин долдугаар зүйл,

¹³ Бодлогын сулалттай шинжилгээ (сулалтгааны эмхтгэл) I боть Уб: 2009 он, 294 дэх тал.

¹⁴ Sui generis-ийг томъёон нь латин үг бөгөөд аливаа юмны төмөр зүйл эсхүл цэвэр ганц шинжийг илэрхийлсэн утгатай. А.Чинва онцлог, цэвэр ганц зүйлийг хууль болон эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлохдоо "Sui generis" гэж нэр томъёог хэрэглэдэг байна.

¹⁵ Бодлогын сулалттай шинжилгээ (сулалтгааны эмхтгэл) I боть Уб: 2009 он, 294 дэх тал.

¹⁶ Чимид Б.Төр, ням, эрх зүйн шинжлэхийн эзэвтэй асуудал Нэлдүгээр хэлээр Уб: 2008 он, 98-99 дэх тал.

Дөчин дөрөвдүгээр зүйл. Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Жаран наймдугаар зүйл болон Жаран есдүгээр зүйл болно.

2. Монгол Улсын Их Хурлын хувьд дэгээ Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоолоор баталсан нь Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг зөрчиж байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 08 дугаар дүгнэлт болон 03 дугаар тогтоол, мөн тус шийдвэрүүдийг гаргахад үндэслэл болсон Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг **хуулиар тогтооно**" гэсэн заалтын дагуу цаашид парламентын дэгээ хуулиар баталж байх эсэх асуудал юм. Эсхүл Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн хэлсэнээр Улсын Их Хурлын олон талт үйл ажиллагааны ангиллыг зөв хийж, эзэн, цаг хугацаа, хэмжээ зэргийг тод тогтоосон процессын хууль, түүний дээр ажилбарын журамчлалыг боловсронгуй болгох асуудал чухаар тавигдаж байна. Эл ажлыг одоо хүртэл хийлгүй "нөхөөс" тавьж явсанаар хуулиуд эрх зүйт ёс, зүй ёс, ухаалаг байдлаар нарийвчлан зохицуулсан процесс ажиллагаанаас тойрч хуурай, ерөнхий, тунхаг шинжтэй болсоор байна.

3. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тайлбар болон түүнийг ямар субъект Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хорооны хуралдаан дээр тайлбарлах асуудал юм. Хууль зүйн өргөн хүрээнд авч үзвэл парламентын хуралдааны дэгийг "тайлбарлах эрх мэдэл"-ийг ямар субъектэд албан ёсоор олгох асуудал. Эл асуудал өнөөдрийг хүртэл ямар ч эрх зүйн зохицуулалтгүй байгаа бөгөөд уламжлал ёсоор Тамгын газар хууль, дэгийн асуудлаар зөвлөх гэсэн нийтлэг чиг үүргийн дор хэрэгжиж байна. Гэтэл дэгтэй холбоотой бүхий л асуудлаар гарсан тайлбарыг Тамгын газрын бүх Зөвлөхүүд нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд шууд тайлбар хийх эрхтэй байх эсэх, мөн дэгийн тухай хуулийн нэг заалтаар хэд хэдэн Зөвлөхийн өгсөн тайлбар, мөн Байнгын хорооны хуралдаан болон нэгдсэн хуралдаанд өгсөн тайлбарууд хоорондоо зөрчилдөхөд аль тайлбарыг давуу эрхтэйгээр хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөх, мөн тус тайлбаруудтай холбоотой гомдол гарвал түүнийг хэрхэн авч хэлэлцэх асуудал тодорхой бус байна.

4. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хийгээд түүнд хяналт тавих асуудал юм. Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тохиолдолд өдгөө хууль хэлэлцэх ердийн журмаар Улсын Их Хурал хэлэлцэж баталдаг. Гэтэл бусад орны парламентын хуралдааны дэгд өөрчлөлт оруулах эрхийг хэн эдлэх

буюу санаачлах, хэрхэн хэлэлцэх, санал хураалтыг ямар хэлбэрээр явуулах эсэх асуудлыг нарийвчлан зааж өгсөн нь дараах учир шалтгааны үндэстэй байна. Тодруулбал, парламентын гишүүдэд энэ эрхийг эдүүлэх байдал судалгаагаар маш өргөн ажиглагдаж байгаа бөгөөд нэг нийтлэг онцлог бол хуралдааны дэгд өөрчлөлт оруулах эрхийг зөвхөн гишүүд эдлэх боломжтой байдлаар зохицуулалт хийсэн байна.¹⁷ Өөрөөр хэлбэл, гүйцэтгэх эрх мэдлийн эсхүл бусад эрх мэдлийн байгууллага дэгд өөрчлөлт оруулах эрхгүй юм. Гэтэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (*нэгэнт хуулийн хэлбэрээр батлагдсан учраас*)-д Үндсэн хуулийн Харин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийнхээ дагуу Ерөнхийлөгч, Засгийн газар тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсаар ирсэн. Парламентат ёс хөгжсөн улсад бол эл асуудлыг Парламентын өөртөө засаглах хэлбэр (*автономи*)-т буюу Үндсэн хуулийн зарчимд халдсан гэж үздэг.

5. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтад Улсын Их Хурал дахь бүлэг "нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах" эрхтэй гэж заасны дагуу бүлгүүд хугацаагүй завсарлага авсанаар хуралдаан хойшлогдох, тухайн хуулийн төслийг цаг хугацааны хувьд хэлэлцэхгүй хойшлуулах практик сүүлийн үед Улсын Их Хуралд ихсэж байна. Хууль тогтоох байгууллагын үүрэг бол Үндсэн хуульд зааснаар хуулийг цаг тухайд нь батлан гаргах, хууль тогтоох чиг үүргээ тасралтгүй хэрэгжүүлэхэд оршино.

ГУРАВ. ҮНДСЭН ХУУЛЬЧИЛСАН ХУУЛИУДЫГ ТОГТООХ НЬ УИХ-ЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮҮРЭГ МӨН

Үндсэн хууль бол "хэрэглээний хууль" бус. Харин Үндсэн хуульчилсан, органик болон бусад хуулиар нарийвчлагдан нийгмийн зөв харилцаанд тодрон хэрэгжих суурь хууль мөний хувьд зөвхөн өөрийн үзэл баримтлалаар нийгмийн хөгжилд нөлөөлөгч хүчин зүйл мөн.¹⁸ Монгол Улсын Үндсэн хуульд "...хуулиар тогтооно" гэж заасан хуулиуд Үндсэн хуулиас салбарласан органик хуулийн хувьд түүний ерөнхий үзэл санаа, зарчмыг материаллаг болон процессийн хэм хэмжээгээр утга агуулгаар задлан тайлбарлах үүрэгтэй. Үүний үр дүнд Үндсэн хуульд заасан зарчмууд хэрэгжих механизм бий болно. Хүний эрх, эрх чөлөө ч баталгаажих болно. Эдгээр хуулийг тогтоох эрх нь гагцхүү хууль

¹⁷ Өзгийсайхан.А. Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн чиглэл. Ув: 2010 он.

¹⁸ Чиндэл Б.Төр, нэгд, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Нэгдцээр ээтэр Ув: 2008 он, 98-99 дэх тал.

тогтоогчид байгаа.

Хууль тогтоогчид Үндсэн хуульд "...хуулиар тогтооно" гэж заасан хуулиудаас 20 жилийн хугацаанд Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2-оор "Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ыг, Гучин долдугаар зүйлийн 3-аар "Улсын Их Хурлын дарга, Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх хууль"-ийг, Дөчин долдугаар зүйлийн 1-ээр "Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль"-ийг, Дөчин есдүгээр зүйлийн 5-аар "Шүүхийн ерөнхий зөвлөлийн хууль"-ийг тогтоох ёстой байв. Судлаачдын үздэгээр түүнчлэн бодит байдалд ч өнгөрсөн он жилүүдийн явцаас харахад парламент юунд их анхаарч ирэв гэвэл хуулийг хууль бүтээдэг арга, технологиор бүтээхийн төлөө бус, харин засаг тойрсон асуудлаар зав зайгүй гүйцгээв. Мөн хууль тогтоогчид Үндсэн хуулийн үг бүрийн цаана онол, ном, мэргэжил шаардсан асуудал байгаа гэдгийг нээж, задлан уншиж, дэлгэрүүлэн нарийвчилж, нэгбүрчилсэн хэм хэмжээ, хууль тогтоож чадаагүйд гол алдаа байгаа юм. Үндсэн хуулийг уншихдаа зөвхөн кирилл үсгээр бус бас онолоор, зарчмаар унших ёстой билээ. Үндсэн хууль гагцхүү хууль тогтоогчид зориулагдсан хууль гэдэг нь ч харагдаж байна.

ДҮГНЭЛТ

1. Үндсэн хуульд ёсны болон аюулгүй байдлын онолоор хууль тогтоогчид Үндсэн хууль, түүний үзэл баримтлалыг, мөн Үндсэн хууль болон үндсэн хуульчилсан органик хуулийн уялдаа холбоог онолын үүднээс зөв ойлгох, хэрэглэх хэрэгтэй байна. Энэ бол хууль тогтоох үйл ажиллагааны амин сүнс мөн.

2. Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа мэргэшээгүй. Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын чуулганы тухай хуулиуд нь Үндсэн хууль, түүний ерөнхий үзэл санаа, зарчмыг материаллаг болон процессийн хэм хэмжээгээр, утга агуулгаар задлан тайлбарласан хэм хэмжээнээс бүрдэх нь байтугай хууль тогтоогчдын, улс төрийн намын явцуу ашиг сонирхол, санаатай болон санамсаргүй алдсан "алдаа"-наас бүрдсэн хэм хэмжээнүүдээс ил тод харагдаж байна. Ийм хууль тогтоох байгууллага бусад хууль тогтоомжийг яаж батлан гаргах нь ойлгомжтой. Улсын Их Хурлаас баталсан хуулийг өнөөдөр "баян", "ядуу" хууль гэж ангилахад хүргэсэн нь хууль тогтоогчдын өөрсдийн алдаа. Эрх зүйн онолоор бол хуулийг хэмжээ, зэрэг, учир холбогдлоор нь Үндсэн хууль, Үндсэн хуульчилсан хууль, ердийн хууль гэж, нийгмийн харилцаанд нөлөөлөх байдлаар нь материаллаг хууль, процессын хууль

гэхчлэн ангилдаг. Гэтэл “ядуу” хуулийн төрөлд Шүүхийн тухай хууль орж байгааг¹⁹ гашуун боловч судлаачид нотлон хэлж байгааг үгүйсгэх аргагүй. Магадгүй “баян” хуулийн төрөлд хууль тогтоогчдын хууль Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн гэсэн хамгийн их дүгнэлт, тогтоол гаргаснаар тодорч болох юм. Энэ хариуцлагагүй байдлыг хууль тогтоогчид Үндсэн хуулиа дээдэлсэнээр засаж болно. Ингэхийн тулд Улсын Их хурал “**Үндсэн хуулийн байнгын хороо**”-г байгуулах ёстой. Мөн “**Үндсэн хуульчилсан шинэтгэл**”-ийг хийх хэрэгтэй байна. Учир нь Үндсэн хуульчилсан хуулиудыг Үндсэн хуульд нийцүүлэх “гүн боловсруулалт” тулгамдсан асуудал болж байна.

3. Хууль бүтээхийн хариуцлагыг монголд ухаарах цаг болсон. Хууль тогтоох ажиллагаа мэргэшээгүй, мөн өмнөх муу уламжлалд тулгуурлан хэрэгжүүлэх арга ажиллагааг нарийн хуульчлаагүй, ерөнхий, тунхагийн шинжтэй хуулиудыг голчлон батлан гаргасаар ирсэн нь хууль биелүүлэх, хэрэгжүүлэх ажиллагаанд томоохон доголдол гарч, хуульчид болон **эрх зүйн боловсрол**, сургалтын өмнө бэрхшээл үүсгэж байна. Хэрэгжүүлэх механизмгүй тунхагийн шинжтэй хуулиудад тулгуурласан сургалт нь хууль дээдлэх итгэл үнэмшилтэй эрх зүйчдийг бэлтгэх бололцоог алдагдуулж байна. Энэ хариуцлагыг Улсын Их Хурал, түүний ажлын алба, хуульчид, зөвлөхүүд ч гэсэн хүлээх хэрэгтэй. Иймд **Үндсэн хуулийн боловсрол**, **Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг** хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд бий болгох зайлшгүй шаардлага байна. Энэ ажлыг алгасвал Үндсэн хууль тогтворгүй болж түүний дархлаа, хамгаалалт алдагдах болно.



¹⁹ Монгол Улс-ийн нэгдлийн хэрэгт бус байдлыг бэхжүүлэх нь, Бодлогын тойм судалгаа, УБ: 2010 он.

Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёсон



Өвөрхангай аймгийн Захиргааны
хэргийн шүүхийн шүүгч, магистр
(LLM) Б.Сугар

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСОН

Хууль дээдлэх үзэл Европт XVIII зуунд хэмжээгүй эрхт хаант ёсны эсрэг тэмцлийн хэлбэр болон гарч иржээ. Төрийн бүх эрх мэдэл зөвхөн хааны гарт байсан ба түүний дур зоргоор бүхнийг шийдвэрлэх эрх ёсыг халж засаг төрийг Үндсэн хуулийн хязгаарлалтад оруулахын төлөө тэмцэл XVII-XVIII зуунд өрнөж ялсан түүхтэй. Тэр цаг үеэс хойш хууль тогтоох үйл ажиллагаанд ард түмний шууд, шууд бус оролцоо буюу төлөөлөл оролцоо, сонгууль, бүх нийтийн санал асуулга буюу референдум, парламент, эрх мэдэл хуваарилах зарчим зэрэг Үндсэн хуулийн, төрийн үндсэн эх сурвалж, гол зарчмууд нийтийн хүртээл болж хүн төрөлхтөний үнэт зүйлс болж эхэлсэн ажээ. Үүний үр дүнд зарлиг буюу хуулийг нэг албан тушаалтан (хаан, ноёд, хэсэг бүлэг) дур зоргоороо гаргах, хүслээрээ бүхнийг шийдэхийг хязгаарлаж, төрийн эрх мэдлийг хуваарилж тэдгээр нь харилцан хяналттай, тэнцвэртэй байж, иргэний нийгмийн хяналт, иргэний (хүний) эрхийг гарган тавьж түүнийгээ Үндсэн хууль гэх тулгуур гол хуулиар бэхжүүлэн зохицуулж эхэлсэн. Анхны Үндсэн хууль 1787 онд АНУ-д батлагдан гарч улмаар бусад улс оронд түгэн дэлгэрчээ.

Энэ үеэс хууль дур зоргын асуудал, нэг хааны санаан зорго бус харин төрийн эрх мэдэл, хүний эрх, нийгмийн хөгжлийн жам ёсыг тухайн улс

орон бүр өөрийн орны Үндсэн хуульд тусгаж Үндсэн хууль амьдралд бодитой биелэлнийг олж эхэлсэн. Иргэснээрээ түүнийг дээдлэх ёсыг нийтээр баримтлахад хүргэжээ. Энэ нь дүр зоргыг хууль ёсоор халсан хэрэг болсон ажээ.

Францын эрдэмтэн Жан Брежель “Эрх зүй бол байгаа хууль нь, харин хууль нь ямар байх ёстой вэ гэдэг нь эрх зүйн гүн ухаан болно” гэж өгүүлжээ. Үүнийг ургуулан бодоход зоргоор томьёолсон “болох, болохгүй” заалт зааврыг бус, зүй зохисыг үзэж, жам ёсыг тусган боловсруулсан бодит хуулийг дээдлэн хүндлэх нь гарцаагүй мэт. Үүнийг л “хууль дээдлэх”, “хууль хүлээн зөвшөөрөгдөхүй” нь Үндсэн хууль хэмээн үзэж болно. Ийм чанарын хуулийг төр, иргэний нийгмийн бүх байгууллага, албан тушаалтан, иргэн, нийтээр хүндэтгэн сахиж, нийгмийн бүх хэм хэмжээнээс дээгүүр тавьж, сахин биелүүлэх нөхцөл бүрдэнэ.

Чингис хаан “Бүх улсын доторх өмчийг хувааж, заргыг шийтгэж, түүнийгээ Хөх дэвтэрт бичигтүн. Надтай зөвлөж Шинхутугийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчил” гэж зарлиг буулгасан байдаг. Энэ зарлиг Их Монголыг төдийгүй эзэнт гүрнийг дагуулсан түүхтэй. Монгол төрийн түүхийн нугачаанд хууль дээдлэх ёс хувьсан өөрчлөгдөж байсан түүхтэй. Тэр бүхэн нь өнөө цагийн хууль дээдлэх ёс, хууль дээдлэх зарчмын агуулгатай яг адилгүй, харин хуулийн аргаар дарангуйлах ёсыг бататгасан шинжтэй байсныг түүх бидэнд өгүүлдэг.

Ардчиллын үнэт зүйлүүдийг бэхжүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим нь “хууль дээдлэх ёс мөн” гэж заасан байдаг. Хууль дээдлэх ёс нь өөрийн бодит агуулга, хэмжүүртэй. Хууль дээдлэх ёс бол дээд түвшний үнэлэмж, түгээмэл зарчим, тодруулбал, зөвхөн хуулийг эрх зүйн болон нийгмийн бусад хэм хэмжээнээс дээгүүрт тавьж ухамсарласан дотоод итгэлийн үндсэн дээр нийтээр, тэр дундаа төр засаг өөрийн бүхий л үйл ажиллагаандаа хуулийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх, хэрэглэх, хамгаалах ёсыг хэлж ойлгож байна. Үндсэн хуулиар төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим болгосон “хууль дээдлэх ёс”-ны учир утга, агуулга ийм болно.

Харин хууль дээдлэх үзэл нийгмийн болон хувь иргэний эрх зүйн ухамсар, биеэ авч явах байдал, хувийн зан байдал, харьцаа зэргээс гадна ёс суртахууны асуудал болж байдаг. Энэ тухайд судлаач “Мэдээж дээдлэх гэдэг нь үзэгдэл өөрөө тухайн субъект өөрийн болон бусдын оршихуй, мөн чанарт ашиг тустай хэмээн уг зүйлд итгэн үнэлж, түүний хүчин чадалд бишрэх, хайрлах, хүндэтгэх байдлаар хандах төдийгүй, энэ хандлага нь уг хүний дотоодод өөрийн хүлээн зөвшөөрсөн уг зүйлтэй

зөрчилдөхөөс эмээх сэтгэцээр дэмжигдсэн өс суртахуун, сэтгэл зүйн нөлөөллийг агуулсан байдаг” гэж бичсэн нь бий.

Хууль дээдлэхэд тавигдах бүхий л шаардлагуудыг ойлгож, хуулийг тууштай хангаж нийгмийн бодит байдалд амьдруулахад Үндсэн хуулийг дээдлэн шүтэх өс хууль зүйн хийгээд үзэл баримтлалын гол суурь болдог. Үүнийг бид байнга анхаарч харж ойлгож байх ёстой мэт.

ҮНДСЭН ХУУЛИЙН ДЭЭДЛЭН ШҮТЭХИЙН УЧИР

Хууль дээдлэх ёсны үндэс нь Үндсэн хуулийг дээдлэн шүтэх өс билээ. Энэ бол ямар нэгэн мухар сүсэг, сэтгэлийн хөөрөл биш. Харин бодитой оршин буй тухайн нийгэмд амьд оршиж үйлчилж байдаг эрхэмсэг орших оройн дээд үзэл санаа, зарчмын тухай асуудал билээ. Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн шүтэх учир нь түүний Монголын нийгэмд нөлөөлж үйлчилж буй чиг үүрэг, хүлээж буй хариуцлага юм.

Үндсэн хууль нийгмийн улс төрийн харилцааны үндсийг бэхжүүлэн хамгаалж байдаг. Өөрөөр хэлбэл төр түмний бүрэн эрхт байдал, нийгэмд хүний эзлэх байр суурийг тодорхойлж, төр ба нам, улс төр, нийгмийн бүлэг, эрх мэдлийн хуваарилалт, тэдгээрийн салаа мөчир, хоорондын харилцааны зарчмууд, төрийн байгуулал, байгууламж, нутгийн удирдлагын ардчилсан тогтолцоог бэхжүүлэн хамгаалах явдал энэ чиг үүрэгт хамаарч байдаг.

Нийгмийн улс төрийн хүчнүүдийн харьцааг оновчтой тодорхойлж бэхжүүлсэн бол тэр Үндсэн хууль сая бодитой, амьд болдог. Үндсэн хуулийн эдийн засгийн чиг үүрэг нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн харилцааны үндсийг хуульчлан бэхжүүлж, хамгаалахад оршино. Үндсэн хуулийн нийгэмшлийн чиг үүрэг олон талтай. Тухайлан дурдвал ард түмний үндэс байх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөхийн сацуу хүний нийгэм, соёлын эрх, эрх чөлөөг бататгаж, хангах баталгаа, нийтийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын талаарх төрийн байгууллагын үндсэн үүргийг тогтоон бэхжүүлэхэд оршино. Хууль зүйн чиг үүрэг нь нийгмийн бүх харилцааны үндсийг бэхжүүлэн тогтоож оршин байх, хөгжих хөрс суурь болж хамгаалж байдаг онцгой чанараар илэрдэг. Нийгмийн эрх зүйн харилцааны тэр дундаа хууль зүйн үндэс суурь нь Монгол Улсын Үндсэн хууль, “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” хэмээн Үндсэн хууль бол хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай акт гэдгийг шууд заасан.

Монголын ард түмэн, иргэд бидний эх болсон төрөлх Монгол

орныхоо бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, өнө удаан оршин тогтнож төр улсаа улсын дайтай улс шиг байгаасай гэсэн нэгэн үзүүрт сэтгэлийн илэрхийлэл бол Монгол Улсын Үндсэн хууль гэж миний бие үздэг, энэ үзэл санаа зүг бүрт түгэн дэлгэрч байгаа гэж ойлгодог залуу үеийн төлөөлөл билээ.

Хүн төрөлхтөний үнэт зүйлс, ёс, зарчим, үзэл баримтлал, хүсэл эрмэлзлэлийг хуульчлан зааж Үндсэн хуульдаа оруулах нь эхний алхам харин хэрхэн тэдгээрийг бодит үр дүнд хүргэхэд маш их хүчин чармайлт хэрэгтэй. Үүнийг бид 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр ардчилсан, шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойшх 20 шахам жилийн түүхээсээ мэдэх болжээ. Энэ хугацаанд манай улс орон шинэ Үндсэн хуулийн ачаар төрийн ардчилсан тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн зэрэг томоохон амжилтад хүрсэн. Гэхдээ бидний зорьсон бүхэндээ хүрэх эхний алхамууд дөнгөж тавигдаж байна. Нийгмийн амьдрал, эдийн засгийн орчин, хүмүүсийн сэтгэлгээ, боловсрол, соёл, ахуй хурдацтай өөрчлөгдөж биднээс маш эрчимтэй ажил хэрэгч байдлыг шаардах болсоноос гадна урьд өмнөхөөс илүү ухаалаг, буурь сууртай, асуудалд ноён нуруутай голч байхыг шаардах болжээ. Энэ бүхэнд бидний Монголчуудын тулах түших цэг маань Үндсэн хууль байсаар бидэнд өгөөжөө өгсөөр л энэ бол өвгөдийн минь, ахмад үеийнхний маань ухааны царыг илтгэж буй хэрэг биз ээ.

ҮНДСЭН ХУУЛИЙГ ДЭЭДЛЭН ШҮТЭХ ЁСЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТӨЛӨВШҮҮЛЭХИЙН УЧИР

Үндсэн хууль баталсны дараа хэрэгжүүлж эхлэх анхны арга хэмжээг 1992 оны УИХ-ын сонгуулиар халаагаа өгсөн Улсын Бага Хурал, Засгийн газар төлөвлөж батлан, тодорхой үйл ажиллагаануудыг явуулж идэвхтэй ажилласан байдаг. Үүнээс улбаалан хуучин хуулиудыг үндсэнд нь шинэчлэх ажил хийгдэж нийгмийн шинэ харилцааг зохицуулсан, шинэ шинэ харилцаануудыг тусгасан хууль олныг гаргасан, шинэ Үндсэн хуулийг 3 удаа хэвлэн нийтлүүлсэн зэрэг томоохон ажлуудыг нь дурдаж болно. Гэсэн хэдий ч өнгөрсөн хугацаанд Үндсэн хуулиар сурталчилж түүнд сурган хэвшүүлэх ажлыг төрийн байгууллага, аймаг, нийслэл, баг, хороо, аж ахуй нэгжээс айл өрх хүртэл нийгмийн бүхий л хүрээг хамаарсан өргөн цар хүрээтэй, улирал жил дамшсан “урт”, удаан хугацааны давтамжтай шахаж шаардаж, шалган дүгнэдэг эзэнтэй, шалгууртай, тогтмол ажил хараахан болсонгүй алгуурлажээ гэхэд хилсдэхгүй.

Төрийн албанд иргэдээс шалгаруулан шилж авах, улс төрийн ажилтан

бэлтгэхэд Үндсэн хууль, түүний үзэл баримтлалын тухай асуудлыг тодорхой болзол, шалгуур болгож анхаардаггүй байна. Үндсэн хуульд үнэнч байх нь албан хаагчийг төрийн хүн болгож буй ухамсрын гол хүчин зүйл, онцлох шалгуур, засаг төр нь нэг бодлого журамтай ажиллахын зайлшгүй нөхцөл мөн билээ. Энэ нь төрийн хүн эрх зүйт төрдөө зүтгэх жам ёсны шаардлагаас урган гарч буй хэрэг. Тиймээс ч манайд бол Үндсэн хуулийг гуйвалтгүй биелүүлэхээ тангаргаладаг бөгөөд ардчилсан зарим орон, тодруулбал, ХБНГУ-д иргэнийг төрийн албанд ороход нь Үндсэн хуульд үнэнч эсэхийг тусгайлан шалгадаг хуультай байдаг ажээ.

Сонгууль, сонгон шалгаруулалтаар төрийн удирдах дээд албан тушаалд очиж байгаа албан тушаалтан бүр томилогдохдоо Үндсэн хууль, хуулийг ягштал биелүүлэхээ тангарагладаг. Үндсэн хуульд үнэнч байхаа баталж гарын үсгээ зурдаг. Тэднээс хууль биелүүлэхийг шаардах эрх иргэдэд энэ үеэс үүсдэг гэж ойлгож болно. Үндсэн хуулийн биелэлт, хэрэгжилтийн асуудал эндээс эхэлдэг ч гэж харж болно. Хуулийн биелэлийг Монгол Улсад Засгийн газар хариуцан ажилладаг, УИХ-ын өмнө төрийн хуулийн биелэлтийг хариуцах эрх бүхий субъект бол Ерөнхий сайд, Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий субъект Үндсэн хуулийн цэц. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн манаач гэхдээ Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2.1-д Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс орон даяар зохион байгуулж хангах нь Засгийн газрын хамгийн гол, үндсэн чиг үүрэг нь билээ. Энэ нь санамсаргүй тохиолдлын хэрэг биш олон улсын жишиг ч ийм манай улсад ч мөн үүнтэй адил эрх зүйн зохицуулалт үйлчилдэг. Үндсэн хуулийн тодорхой зүйл, заалт биелэхгүй байгаа тухай асуудал их яригддаг. Тухайлбал, Үндсэн хуульд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах зэрэг олон заалтыг дурдаж болно. Өнөө үгүй ч маргааш Үндсэн хуулийн энэ мэт заалтуудыг биелүүлэхийн төлөө Монголын Засгийн газар, төрийн байгууллагаас эхлээд жирийн иргэн бид хүртэл хичээн эрмэлзэх ёстой Үндсэн хуулийн утга санаа ийм агуу ажээ.

Үндсэн хуулийн зарим бүлэг, зүйлийг ерөнхий боловсролын ахлах ангийн сурах бичигт оруулсан байдаг боловч энэ нь ор нэр төдий, хуулийн үзэл баримтлал, утга санааг энгийн байдлаар гүн гүнзгий ойлгуулах, хууль, эрх зүйн талаар өгч буй мэдлэг, мэдээлэл тэр дундаа Үндсэн хуулийн талаарх суурь мэдлэг хангалтгүй өгч байгааг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид тэргүүтэй судлаачид эмзэглэн дурдаж ярьж бичих болжээ. Бусад орны жишгээс

үзвэл Үндсэн хууль дээдлэх ёсыг нийт иргэн, төрийн албан хаагч, улс төрчид хамгийн гол нь залуу үеийнхэн, өсвөр насныханд итгэл үнэмшил, дадал зуршил болгож тэдний ухаан бодолд Үндсэн хууль, түүний цаад санаа, үзэл баримтлалыг өсөх багаас нь суулгаж зааж сургаж зориуд энэ асуудалд төрөөс анхаарч төрийн бодлогын түвшинд зохих шийдвэр гарган хэрэгжүүлдэг ажээ. Иймд дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлж төрийн бодлого болгосноор манай улс хүн төрөлхтөний үнэт зүйл болох эрх зүйт ёс, хууль дээдлэх ёс, Үндсэн хуулиа дээдлэн шүтэх, Үндсэн хуулийн үзэл баримтлалын талаар иргэн бүр тодорхой мэдээлэл, төсөөлөлтэй болж нийгмийн эрх зүйн ухамсар дээшилж ардчиллын үнэт зүйлсийг ард түмний хүртээл болгох боломжтой болно. Энэ талаар яригдаж эхэлж байгаа боловч төрийн шийдвэр гарч бодлогын хэмжээнд яригдаж ямар нэгэн нүдэнд үзэгдэхүйц, гарт баригдахуйц үйлдэл хийгдэхгүй байсаар өдийг хүрсэн нь үнэн төдийгүй эмгэнэлтэй байдалд ч хүргэх болжээ. Эрх зүйн өндөр ёс суртахуунтай, нийгэмд биеэ зөв авч явах чадвартай залуу үе бидэнд, манай улсад хэрэгтэй. Үүний тулд төрийн бодлогын хэмжээнд залуу хойч үедээ хандсан, тэдний эрх зүйн тэр дундаа Үндсэн хуулиа дээдлэн хүндлэх, түүний утга агуулга, мөн чанарыг ухан ойлгуулахуйц үр дүнтэй арга хэмжээ авах зайлшгүй шаардлага бодит амьдралаас урган гарч байна. Өмнө ургасан чихнээс хойно ургаж буй эвэрт бид анхаарах ёстой мэт.

Нийгмийн хамгийн гол суурь болсон Үндсэн хуулиа нийтээрээ дээдлэн шүтэхийн тулд Үндсэн хуулиа тайлбарлан таниулах болон сургалт, зохион байгуулалтын асуудалд шинжлэх ухааны үнэн зөв хандлага онцгой ач холбогдолтойг эрх зүйт төрийг төлөвшүүлсэн улс орнууд нотолдог. Хууль дээдлэх, Үндсэн хуулиа дээдлэн шүтэх гэдэг нь Монголын төр, иргэний нийгэм, ард түмнийг нэгдмэлээр авч үзсэн, үндэсний эв нэгдэл, язгуур эрх ашиг, туйлын зорилгын үүднээс эрхэмлэсэн ойлголт билээ. Харин иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж Үндсэн хуулийн талаарх үзэл бодлоо хэлэх, хэвлэн нийтлэх нь нээлттэй, хүн итгэл үнэмшилтэй, өөрийн үзэл бодолтой байх эрхийг Үндсэн хууль өөрөө баталгаажуулсан байдаг.

Үндсэн хууль нь өөрчлөгдөшгүй мөнхийн зүйл биш, гэхдээ зарим бүрхэг ойлгомжгүй, мэргэжлийн бус хүрээнд тодорхойгүй зүйлийг засаж залруулах, нийгмийн амьдралын хөгжил, өөрчлөлтийг дагаж нэмэлт, өөрчлөлт хийх нь нээлттэй боловч болгоомжтой хандах хэрэгтэй. Дордуулахын 7 өөрчлөлт гэсэн нэр томъёо 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс урган гарсныг санаж байх хэрэгтэй. Судлаачид болоод хуульчид, багш, мэргэжлийн

хүмүүс энэ 7 өөрчлөлт Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд дэвшил болсон гэхээсээ ухралт болсон гэдэгтэй илүүтэй санал нийлж байгаагаа олон удаа мэдэгдэж байсан. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа бол эхэлж тухайн өөрчлөх нь зүйтэй гэж үзсэн хэсгийн үзэл баримтлал, утга санааг ухаж ойлгох нь нэн тэргүүний асуудал байх ёстой. Хөнгөн хийсвэр байдлаар Үндсэн хуульд хандах хандлага байж болохгүй, гэхдээ өнөөдөр Үндсэн хуульд ийм ийм нэмэлт, өөрчлөлт хийх нь зүйтэй гэж хууль санаачлах эрх бүхий субъектүүд ярих нь нэмэгдэж байгаа нь цаг хугацааны хувьд тийм ч таатай зүйл биш юм.

Монгол Улсын Үндсэн хууль монголчууд бидний сонголт, ард түмний хамтын бүтээл. Төслийг нь боловсруулах болон эцсийн шатанд Монгол Улсын Бага Хурал 1, 2 дугаар хэлэлцүүлгийг оруулаад нийт 4 удаа, бүх ард түмэн нийтээрээ 3 сар хэлэлцэж, Ардын Их Хурлын 420 гаруй депутат 70 шахам хоног 2 удаа хэлэлцэж, 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өглөөнөөс цэг, таслалыг нэг бүрчлэн хэлж, үг бүрээр нь уншуулж сонсоод 1 депутатаас бусад нь санал нэгтгэйгээр баталсан төрийн гол хууль мөн билээ. Монгол төрийн тэргүүн асан П.Очирбат гуай тухайн үедээ Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын даргын хувиар “Монгол цаадын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай” Ардын Их Хурлын II дугаар хуралдаанд 1992 оны 10 дугаар сарын 07-ны өдөр тавьсан илтгэлдээ “Монгол Улсын Их цаадын тухай төсөл бол Монгол Улсын оюуны чадавхийг бүхэлд нь дайчилсан Монголын хөдөлмөрчид, эрдэмтэд, мэргэжилтэн, та бидний хамтын бүтээл” гэж тэмдэглэж байжээ. Эндээс түүний өмнөх хуулиудаас ялгаатай, Монголын ард түмэн нийтээрээ болон төлөөлөөрөө дамжуулан хэлэлцэж хэнээс ч хараат бусаар гардан эх барьсан анхны хууль байсан түүх нийм ажээ. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй. Бүлээн усаар утаавал хиргүй.

Энэ чанараараа бидний дээдлэн шүтэж, сүсэглэн мөргөж, ёсчлон сахих нийгмийн сэтгэл зүйн гүн үндэстэй эх хууль маань мэндэлжээ. Үеэс үед дээдлэн биширч залгамжлах аваас нэгэн зүйл үндэсний бахархал, Монгол төрийн, нийгмийн, хүн ардын сэтгэлийг түвшитгэх, аюул эндэгдэлгүй амар түвшин амьдран суух үндэс суурь энэ мөн билээ.

○○○○○ ○○○○○ ○○○○○

Олон улсын үйлчилгээний худалдааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

**ХЗҮХ-ийн Иргэн, эдийн
засгийн эрх зүйн секторын эрдэм
шинжилгээний ажилтан,
магистр (LLM) Б.Оюунбилэг**



ОРШИЛ

Үйлчилгээ гэж үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүн болох тодорхой үйлдэл бөгөөд үр дүн нь үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангасан байхыг ойлгоно.¹ Үйлчилгээний худалдааны барааны худалдаанаас ялгарах гол онцлог нь бодит буюу биет хэлбэр байдаггүйд оршдог байна.

Сүүлийн жилүүдэд үйлчилгээний худалдаа нэлээд хөгжиж олон улсын худалдааны ихэнх хувийг эзлэх болсон. Манай улсын хувьд ч үйлчилгээний худалдааны салбар дотоодын нийт бүтээгдэхүүний тал илүү хувийг эзэлж өссөн дүнтэй байгаа.²

Үйлчилгээний худалдаа гэдэг ойлголт нэгэнт бий болж олон улсад үйлчилгээний худалдааг зохицуулсан баримт бичиг болох “Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр”-ийн салшгүй хэсэг “Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр” 1995 онд батлагдан гараад даруй 16 жил өнгөрчээ. Энэхүү хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орсон хэдий ч манай улсад үйлчилгээний худалдаа гэсэн ойлголт нэр томъёоллын хувьд хэвшин тогтоогүй хэвээр байна. Мөн үйлчилгээний худалдаатай холбогдох судалгаа, шинжилгээ хийгддэггүй, үйлчилгээний худалдааны талаар хүмүүс ойлголт багатай байдаг зэрэг нь энэхүү салбар эрх зүйг

¹ Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал 2000 г.

² Монгол Улсын худалдааны бодлогын тойм 2003 он.

цаашид зайлшгүй судлах шаардлагатай судалгааны зүйл мөн болохыг харуулж байна. Энэхүү өгүүлээр үйлчилгээний худалдааны ерөнхий ойлголт хийгээд “Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт”-ийн талаар, энэхүү хэлэлцээрт нэгдэн орсонтой холбогдуулан Монгол Улсын авсан үүрэг амлалт, түүний хэрэгжилт, энэхүү хэлэлцээрт нэгдэн орсонгоор манай улсад бий болох боломж, нөхцөлийн талаар товч авч үзэхийг зорилоо. Ингээд олон улсын үйлчилгээний худалдааны тухай ойлголтын асуудлыг авч үзье.

ОЛОН УЛСЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Олон улсад бараа худалдааны сацуу олон улсын үйлчилгээний худалдаа өргөн хүрээтэй хөгжиж байгаа. Энэ хоёр худалдаа өөр хоорондоо нарийн нягт уялдаа холбоотой байдаг. Гадаадад бараа нийлүүлэхийн өмнө түүний зах зээлийн эрэлт, хэрэгцээнд дүн шинжилгээ хийхээс эхлээд шаардлагатай барааг тээвэрлэн хүргүүлэх хүртэлх төрөл бүрийн үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэх хэрэгтэй болдог. Олон улсын худалдааны эргэлтэд орж буй үйлчилгээний олонх төрөл нь барааг экспортлох болон импортлох ерөнхий ухагдахуундаа багтаж байдаг байна. Олон улсын үйлчилгээний худалдаа нь уламжлалт бараа худалдаанаасаа хэд хэдэн өвөрмөц онцлог ялгаатай байдаг.

Үндсэн гол ялгаа нь үйлчилгээний худалдаанд бодит буюу биет хэлбэр байдаггүйд оршино. Гэхдээ зарим төрлийн үйлчилгээний худалдаанд бодит буюу биет хэлбэрийг ашиглах явдал байдаг. Жишээлбэл, компьютерын хөтөлбөрт зориулсан соронзон хэрэгсэл ба цаасан дээр хэвлэн гаргасан баримт бичгийн зэрэг хэлбэр төрхтэй байдаг. Харин интернет хөгжиж өргөжин тэлэхийн хэрээр үйлчилгээний худалдааны ажилд дээрхтэй ижил төстэй материаллаг биет зүйлийг хэрэглэх явдал мэдэгдэхүйц багасаж байна.

Бараа, таваарынхтай харьцуулан үзэхэд үйлчилгээний үйлдвэрлэл, хэрэглээ үндсэндээ бараг нэгэн зэрэг явагддаг бөгөөд түүний бүтээгдэхүүнийг хадгалах асуудал гардаг.¹ Зөвхөн эдгээр ажил төрөлтэй уялдуулан гадаадад үйлчилгээгээр хангагчид байнга байх буюу бас тухайн оронд үйлчилгээг хэрэглэгчид байнга оршин байх нь чухал юм. Олон улсын үйлчилгээний худалдаанд нийлүүлэлтийн үндсэн 4 онцлог хэлбэр байдаг. Энэ нь:

1. Хил дамнасан худалдаа.(трансграничная торговля, crossborder trade)

¹ Геринков.И.Н. *Мировая торговля* 2001 г.

Энэ нөхцөлд үйлчилгээг худалдагч буюу худалдан авагчийн аль нэг нь хил давж холбогдох түнштэйгээ уулзах шаардлага гарахгүй бөгөөд энэ үүргийг зөвхөн үйлчилгээгээр хангагч л гүйцэтгэнэ. Ийм арга нь олон улсын хэмжээнд бараа худалдаалах үйл ажиллагаанд үлэмж нэвтэрч байна. Тухайлбал, хилийн чанадаас утсаар (факсаар), интернэтээр хуулийн зөвлөгөө өгөх, эсвэл гадаадын холбогдох сургуулийн холбоо, харилцаагаар дамжуулан сургах хөтөлбөрт хамрагдах зэрэг тааламжтай нөхцөл бүрдэж байгаа юм;

2. Хилийн чанад дахь хэрэглээ. (потребление за границей, consumption abroad) Энэ бол аль нэг улсын хэрэглэгч нөгөө орныхоо путаг дэвсгэр дээр үйлчилгээг олж авах, хэрэглэх явдал юм. Эл тохиолдолд зөвхөн үйлчилгээг худалдан авагч хилийн чанадад хүрэлцэн очно. Тодруулбал, холбогдох этгээд хилийн чанадад суралцах буюу эмчлүүлэх гэх мэт;

3. Үйлчилгээгээр хангах төлөөллийн байгууллагыг байгуулах тухай. (торговое присутствие в стране предоставления услуги, right of establishment) Энэхүү нөхцөлд үйлчилгээгээр хангах пүүс нь өөрийн пүүсийн төлөөлөгчийн газрыг буюу охин компанийг холбогдох оронд байгуулж, түүгээрээ дамжуулан үйлчилгээгээр хангах үйл ажиллагаа явуулна. Энэ тохиолдолд үйлчилгээ болон түүний хэрэглэгчийн аль аль нь хилийн чанадад гарч, үйл ажиллагаа явуулах шаардлагагүй;

4. Үйлчилгээгээр хангах бие хүмүүсийг байлцуулах тухай. (присутствие физических лиц предоставляющих услуги, presence of natural persons providing services) Хэрэглэгч оршин сууж буй оронд нөгөө нэг улсаас ирж ажиллах хүмүүсийн үйл ажиллагаанд үйлчилгээний ажил шууд хамаарагдсан байх нөхцөлд буюу тухайлбал, гадаадын банкнаас тухайн оронд нээж буй төлөөлөгчийн газрын шугамаар архитектор буюу банкны төлөөлөгч ирж ажиллах зэрэг асуудал дээрх ойлголтод багтдаг байна.⁴

Энэхүү үйлчилгээний худалдааг зохицуулсан олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар дараагийн хэсэгт авч үзье.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

Дэлхийн худалдааны байгууллагын өмнөх үе болох Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр нь дэлхийн хоёрдугаар дайны дараагаар олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн шинэ байгууллагууд, тухайлбал, Бреттонвудын тогтолцооны санхүүгийн байгууллагууд буюу хожим нь Дэлхийн банк, Олон улсын валютын сантай нэгэн үед тухайн хэлэлцээрийн дүнд байгуулагдсан.

4 <http://www.oecd.org/dataoecd/32/45/2404428.pdf>

Дэлхийн хоёрдугаар дайны дараа худалдааг чөлөөлөх үйл явцыг түргэтгэх, 1930-аад оноос дэлхий нийтийн эдийн засгийн оршин тогтнох болсон протекционист арга хэмжээний чиглэлд гарсан үлэмж хүндрэлийг засах ажлыг эхлэх зорилгоор ТХЕХ-ийг үүсгэн байгуулагч 23 орон 1946 онд хэлэлцээ хийж эхэлсэн. Хэлэлцээний эхний үе шатны үр дүнд дэлхийн худалдааны 1/5 орчим буюу 10 миллиард орчим долларын нийт үнийн дүн бүхий 45 мянган тарифын буулт хийж чаджээ. Буулт дүрэм, журам нийлээд 1948 оны 1 дүгээр сард хүчин төгөлдөр болсон Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр болсон байдаг.

ТХЕХ нь юуны түрүүнд оролцогч улс орнуудын хоорондын худалдааны харилцаанд удирдлага болгох зарчим, эрх зүйн хэм хэмжээ, дүрэм, журмыг агуулсан олон талт хэлэлцээр юм.

ТХЕХ-ийн заалтууд 1940-өөд оны сүүлчийн хагаст дэлхий дахинд бий болсон эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлыг тусгасан байсан учир нэг их удалгүй олон улсын өсөн нэмэгдэж буй эдийн засгийн харилцааны шаардлагаас хоцорч эхэлсэн бөгөөд үүнтэй уялдан ТХЕХ-ийн заалтыг боловсронгуй болгон өөрчлөх үйл явц эхэлсэн юм. Энэ үйл явц хэд хэдэн үе шаттай явагдсан бөгөөд цаашид ч үргэлжлэх нь тодорхой. Уругвайн үе шат нь бүх оролцогч бүх хэлэлцээрийг зайлшгүй мөрдөх ёстой гэсэн зарчимд шилжүүлсэн.

Уругвайн үе шат нь ДХБ байгуулах тухай эрх зүйн заалтууд нь ТХЕХ-ийн заалтуудаас давуу хүчин чадалтай байх чиглэлээр дээр дурдсан чиг шугамаа лавшруулсан. Энэ нь 16 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгт дурдсанаар “Тухайн хэлэлцээрийн заалт, олон талт худалдааны хэлэлцээрүүдийн аль нэг заалтын хооронд зөрөлдөөн гарвал энэхүү хэлэлцээрийн заалт илүү хүчинтэй байна” гэж дурдсанаас тодорхой юм.

ТХЕХ-ийн үйл ажиллагаа Уругвайн үе шатны явцад хөдөө аж ахуйн болон түүхий эдийн барааны олон улсын худалдаа, худалдаан дахь эрүүл ахуй, мал эмнэлэгийн хязгаарлалт зэрэг зөрчилтэй салбаруудыг өргөн хамрах болсон. Ингэснээрээ энэ үе шат дүүсхаас өмнө олон улсын худалдааны харилцааны эрх зүйн үндсийг боловсруулах, шинэчлэх талаарх ТХЕХ-ийн үүргийг улам идэвхжүүлсэнээр хэлэлцээний гол анхаарлыг энэ чиглэлд хандуулж чаджээ.

Пунта-Дель-Эстегийн тунхаглал нь сүүлчийн мөчид хүрсэн нийтлэг тохиролцооны үндсэн дээр авч үзвэл 2 үндсэн бүлгээс бүрдэж байлаа. Энэ нь Барааны худалдааны хэлэлцээ (1 дүгээр бүлэг), Үйлчилгээний худалдааны хэлэлцээ (2 дугаар бүлэг) байв.

Үйлчилгээний худалдааны хэлэлцээ нь бүхэлдээ ТХЕХ-ийн журам, практикийн дагуу хийгдсэн. Уругвайн үе шатны тунхаглалд дурдсанаар

үйлчилгээний худалдааны талаар хийсэн хэлэлцээний албан ёсны зорилго нь тухайлсан нэр төрлийн үйлчилгээнд тохирсон тодорхой заалт боловсруулах асуудлыг оролцуулан үйлчилгээний худалдааны зарчим, дүрэм, журмын олон талт тогтолцоог бий болгох явдал байсан.

Олон талт худалдааны хэлэлцээний төгсгөлийн баримт бичгийг бүрдүүлж байгаа 30-аад хэлэлцээр нь урьдчилсан хяналт шалгалт, барааны гарал үүслийн дүрэм зэрэг техникийн шинжтэй асуудлаас авахуулаад зарчмын шинэ баримт бичиг болох үйлчилгээний худалдааны салбарыг олонх орон хүлээн зөвшөөрсөн зарчим, дүрэм, журмын олон талт хэлэлцээр болгох хүртэл өргөн салбарыг хамаарч чадсан юм.

Барааны болоод үйлчилгээний худалдааны олон талын зохицуулалтын асуудлыг ойлгох явдлыг шинэ түвшинд гаргасан нь Уругвайн үе шатны бас нэг чухал амжилтын нэг бөгөөд энэ нь 1990-ээд оны үед дэлхийн худалдааны шинэ тогтолцоог бий болгоход олон улсын хандлагын цаашдын чиглэлийг тодорхойлох замд шинэ эхлэлийг нээж өгсөн юм.

1990-ээд оны эхэн хүртэл олон улсын хэмжээнд "үйлчилгээний худалдаа"-ны талаарх нэгдсэн ойлголт байгаагүй бөгөөд олон улсын хэмжээнд зохицуулсан зохицуулалт мөн байсангүй.

1940 оод оны дундуур үндэслэгдсэн ТХЕХ-ийн үргэлжлэл Уругвайн үе шатны үр дүнд үйлчилгээний худалдааг зохицуулсан, Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийг 1995 онд баталжээ. Ингэснээрээ улс орнууд олон улсын хэмжээнд үйлчилгээний худалдаагаа зохицуулах баримт бичигтэй болсон төдийгүй нэгдсэн ойлголттой болох анхны алхмыг хийжээ.

"Үйлчилгээ гэдэг нь үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүн болох тодорхой үйлдэл бөгөөд үр дүн нь үйлчлүүлэгчийн тодорхой хэрэгцээг хангасан байвал зохино"³ гэж тодорхойлсон байдаг.

Орчин үеийн олон улсын худалдаанд үйлчилгээний худалдаа өөрийн гэсэн онцлогтой эрх зүйн нарийн зохицуулалт шаардаж байгаа салбар юм. Статистикийн мэдээнээс үзэхэд үйлчилгээний худалдаа дэлхий нийтийн худалдааны 20 гаруй хувийг эзэлж, барааны худалдаанаас илүү эрчимтэй хөгжиж байгаагийн зэрэгцээ ажлын шинэ байр бий болгох гол эх үүсвэр болж байгаа юм.

Үйлчилгээний салбарт бүх төрлийн тээврийн үйл ажиллагаа, санхүү, банк, харилцаа холбоо, аялал жуулчлал, барилга байгууламж, эрүүл мэнд, боловсрол, мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ болон бусад олон салбарын үйлчилгээ багтдаг.

Олон улсын үйлчилгээний худалдааны барааны худалдаанаас ялгарах

³ Дэлхийн худалдааны байгууллагын эх зүйн зарим асуудал УБ: 2000 он, 114 дэх тал.

гол онцлог нь үйлчилгээний нэр төрөл, шинж чанарын ялгаа, үйлчилгээг оруулж гаргахад зохицуулалтын нэг мөр хандлагыг олоход гарах бэрхшээл, үйлчилгээний худалдаанд олон улсын барааны худалдаанд нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ байна. Тухайлбал, үндэсний нөхцөл, үндэстний нэн таалагмжтай нөхцөлийг жинхэнэ утгаар нь хэрэглэхэд хүндрэлтэй зэрэг асуудалтай холбоотой байна. Тиймээс 1990-ээд оны эхэн үе хүртэл Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн (ТХЕХ) хүрээнд үйлчилгээний худалдааг бүрэн хамаарч чадах олон талт хэлэлцээр байгуулж чадаагүй юм. Гэхдээ үйлчилгээний зарим тодорхой төрлийг улс хоорондын салбарын олон улсын хэлэлцээрээр зохицуулж байсан юм. Үйлчилгээний худалдаа олон улсын хэлэлцээрийн зохицуулах зүйл болсон. Энэ талаар хийх хэлэлцээний хүрээнд үйлчилгээний худалдааг зохицуулах олон талын зарчим, хэм хэмжээг боловсруулах санаачлагыг АНУ-ын Засгийн газар гаргажээ. Гэвч хөгжиж буй орнууд эхэндээ ийм хандлагыг эсэргүүцэж байсан хэдий ч эцсийн дүнд үйлчилгээний худалдааг зохицуулах олон талт хэлэлцээр байгуулах хэлэлцээг ТХЕХ-ээс тусад нь барааны худалдааны хэлэлцээний зэрэгцээ хийхээр тохиролцсон бөгөөд чухамхүү тийм бие даасан хэлэлцээний дүнд Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (ҮХЕХ) байгуулсан билээ.

ҮХЕХ нь Уругвайн үе шатны хэлэлцээний үр дүнд бий болсон зарчмын шинэ тогтолцоо юм. Тэрээр үйлчилгээний худалдааг зохицуулах олон талын эрх зүйн тогтолцооны үндэс болсон анхдагч зарчмуудыг агуулсны дээр энэ салбарын үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтой болсон юм. Тиймээс тухайн хэлэлцээрийн тодорхой заалтуудыг, ялангуяа эрх зүйн талаас нь нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор гарч байгаа билээ. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь харнуцаж биелэлтэд хяналт тавих ажлыг хариуцдаг байгууллага нь Үйлчилгээний худалдааны зөвлөл (ҮХЗ)⁶ юм.

ҮХЕХ нь 6 бүлэг, 29 зүйлтэй. Үндсэн 6 бүлэг нь дараах бүтэцтэй байна. Тухайлбал:

1. Хамрах хүрээ;
2. Нэр томъёо;
3. Нийтлэг үүрэг амлалт, дэг журам;
4. Тусгай үүрэг амлалт;
5. Үйлчилгээний худалдааг цаашид чөлөөлөх;
6. Дэгийн буюу төгсгөлийн заалт.

⁶ Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр 24 дүгээр зүйл.

ҮХЕХ нь 3 төрлийн эрх, үүргийн нэгдлээс бүрддэг. Үүнд:

- ҮХЕХ-ийн үндсэн хэсэгт бүх төрлийн үйлчилгээнд хамрах эрх зүйн үндсэн хэм хэмжээ, зарчмын шинжтэй үндсэн тодорхойлолтууд;

- ҮХЕХ-ийн тодорхой зүйл, заалтыг үйлчилгээний тодорхой салбарт хэрхэн хэрэглэхийг тодорхойлсон хавсралтууд (Далайн тээвэр, цахилгаан холбоо, банк, санхүүгийн үйлчилгээ, агаарын тээвэр гэх мэт), 2 дугаар зүйлийн дагуу чөлөөлөлт хийх (үндэстний нэн тааламжтай нөхцөлөөс чөлөөлөх гэх мэт);

- ДХБ-ын гишүүн орнуудаас тодорхой төрлийн үйлчилгээний талаар хүлээсэн үүрэг амлалтын жагсаалт.

Сүүлийн 2 хэсэг асуудал нь бие даасан эрх зүйн актуудад тусгалаа олсон хэдий ч ҮХЕХ-ийн салшгүй хэсэг болно. Тийм учраас ҮХЕХ-ийг судлах, түүний үйлчлэх хүрээг тодорхойлох, гишүүн орнуудын тодорхой эрх, үүргийг тодотгоход энэ бүлэг асуудлыг хамтад нь харицан холбоотой авч үзэх ёстой.

ҮХЕХ-ийн ийм бүтэц нь ДХБ-ын гишүүн бүх орон зайлшгүй мөрдөх ёстой бөгөөд салбар, нэр төрлийн үйлчилгээтэй холбоотой тодорхой үүрэг амлалтын хооронд ялгаатай авч үзэх боломж олгодог.

Тодорхой салбар, нэр төрлийн үйлчилгээ гэдэг 2 талын тусгайлсан хэлэлцээний үр дүнд шийдэгдэх асуудал бөгөөд үр дүн нь тухайн орны үүрэг амлалтын жагсаалтад тусгагдаж баталгаажих ёстой. Энэ утгаараа ҮХЕХ нь ТХЕХ-ийн эрх зүйн ерөнхий загвар (бүх нийтэд хамаарах үүрэг, амлалт, тарифын протоколуудад тусгагдсан зах зээлд нэвтрэх нөхцөл)-тай нийцэж байгаа болно.

ҮХЕХ-ийн тийм зохион байгуулалт нь тухайн хэлэлцээрийг эдийн засгийн хөгжлийн янз бүрийн түвшинд байгаа болон үйлчилгээний худалдааг өөр өөр арга, хэлбэрээр чөлөөлөхийг эрхэмлэж байгаа улс орнууд хүлээн авах боломжийг нэмэгдүүлж байгаа болно.

ҮХЕХ-ийн дор дурдсан гол заалтууд⁷ нь ТХЕХ-тэй адил төсөөтэй юм. Үүнд:

- Үндэстний нөхцөл: Үүрэг, амлалтын үндэстний жагсаалтад тусгагдсан үйлчилгээний салбарт тухайн жагсаалтад дурдсан нөхцөлөөр засгийн газар бүр гишүүн бусад орны үйлчилгээ болон үйлчилгээ үзүүлэгчдээс дутуугүй тааламжтай нөхцөл олгох ёстой.

- Үндэстний нэн тааламжтай нөхцөл: Засгийн газрууд гишүүн бусад орны үйлчилгээ болон үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд ямар нэгэн ялгаварлан гадуурхах явдал гаргах ёсгүй бөгөөд тэдгээрт бүгдэд нь аливаа бусад гишүүн улсын үйлчилгээ болон үйлчилгээ үзүүлэгчдэд

⁷ Сэжэр, Г. *Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал* УБ: 2000 он, 113 дүгн тал.

олгогдогс дутуугүй тааламжтай нөхцөл олгох ёстой. Гэхдээ ямарваа нэг үйлчилгээний хувьд аливаа гишүүн орны хувьд илүү тааламжтай нөхцөлийг хэвээр хадгалах сонирхолтой засгийн газрын хувьд ҮХЕХ хэрэгжиж эхлэхээс өмнө үндэстний нэн тааламжтай нөхцөлөөс чөлөөлөх асуудлаа баталгаажуулах замаар үүнийг хийх нэг удаагийн боломж олгосон болно. Тийнхүү чөлөөлсөн жагсаалт ҮХЕХ хэрэгжиж эхэлснээс хойш 5 жилийн дараа хянагдах ёстой.

• Ил тод байдал (нээлттэй байх): Үйлчилгээний худалдааг зохицуулахтай холбогдсон бүх төрлийн хууль тогтоомж, энэ талаар авсан арга хэмжээний тухай мэдээллийг хэвлэн нийтэлж байх ёстой. Учир нь тарифын зохицуулалт байхгүй тохиолдолд үйлчилгээний худалдааг зохицуулах үндсэн хэрэгслэл нь үндэсний хууль тогтоомж байх бөгөөд хэлэлцээрийн дагуу зохицуулахдаа эдгээр бүх арга хэмжээг ухаалаг, бодит, төвийг сахисан байдлаар хэрэгжүүлэх ёстой. Засгийн газруудаас түүнчлэн засаг захиргааны шийдвэрийг шуурхай эргэн харх боломжийг хангахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг тодорхойлсон байхыг шаарддаг байна.

• Хүлээн зөвшөөрөх: Аливаа баталгаажуулалт (жишээ нь, үйлчилгээ үзүүлэгчид зөвшөөрөл, гэрчилгээ олгох гэх мэт)-ыг харилцан хүлээн зөвшөөрөх асуудлаар засгийн газрууд хоорондоо 2 талын хэлэлцээр байгуулахдаа энэ нь тухайн хэлэлцээрт нэгдэн орох талаар хэлэлцээ хийх сонирхолтой гишүүн бусад орны хувьд нээлттэй байх ёстой. Нөгөө талаар тийнхүү хүлээн зөвшөөрөх нь ямар нэг ялгаварлан гадуурхах явдалгүйгээр олгогдох бөгөөд худалдаанд хязгаарлалт болох ёсгүй.

• Олон улсын төлбөр тооцоо, шилжүүлэг: Тухайн хязгаарлалт нь хязгаарлагдмал, түр хугацааны тодорхой нөхцөлтэй байж болох төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй тохиолдлоос бусад үед хэлэлцээрийн дагуу хүлээсэн тусгай үүрэг амлалтын хувьд санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэх олон улсын төлбөр тооцоо, шилжүүлгийн талаар ямар нэгэн хязгаарлалт байхгүй.

• Зах зээлд нэвтрэх болон үндэсний нөхцөл: Энэ салбарын амлалт нь үндэсний жагсаалтад тусгагдах ёстой. Жагсаалтад зах зээлд нэвтрэх нь баталгаатай болсон тийм үйлчилгээ, эсхүл түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлон заахын зэрэгцээ зах зээлд нэвтрэх асуудал хамаарч болох аливаа нөхцөлийг мөн тусгасан байх ёстой. Гадаадын үйлчилгээ үзүүлэгчдэд тэдгээрийг үзүүлж байгаа үндэсний үйлчилгээ үзүүлэгчдэд үзүүлдгээс дутуугүй нөхцөлийн хувьд зах зээлд нэвтрэх нөхцөл, боломж олгох талаарх үүрэг амлалтын аливаа хязгаарлалт нь жагсаалтад тусгагдвал зохино. Эдгээр үүрэг, амлалт нь харилцан

уялдаатай байх бөгөөд өөрөөр хэлбэл, эрх ашиг нь хөндөгдөж буй улс оронтой саармагжуулах хэлэлцээ хийсэний үндсэн дээр тэдгээрийг зөвхөн өөрчлөх буюу татан авч болно. Тийм байдлаар эдгээр үүрэг амлалт нь гадаадын хөрөнгө оруулагчид, үйлчилгээ экспортлогчид болон импортлогчдын хувьд ажил хэрэгч үйл ажиллагааны баталгаатай нөхцөл болох ёстой.

- Цаашид чөлөөлж боловсронгуй болгох хэлэлцээрт зааснаар шинэ хэлэлцээг үе шаттайгаар явуулах бөгөөд эхний ээлжийн хэлэлцээг 5 жилийн туршид эхлэх бөгөөд үндэсний жагсаалтад тусгагдсан үүрэг, амлалтын түвшинг нэмэгдүүлэх, үйлчилгээний худалдааны талаар засгийн газрын зүгээс авч байгаа арга хэмжээний сөрөг үр дагаврыг багасгах замаар чөлөөлөлтийн явцыг үргэлжлүүлэх болно.

- Маргаан шийдвэрлэх: Үйлчилгээний худалдаатай холбогдсон маргаантай асуудлыг ТНХХ, ҮХЕХ-ийн аль алины нь хүрээнд зохицуулах ёстой. Ингэхдээ үйлчилгээний худалдаа нь хил дамжсан болон үндэсний зохицуулалтын шинжийг давхар агуулгийг анхаарах ёстой.

ҮХЕХ-ийн дагуу үйлчилгээний худалдааг хил дамнан үйлчилгээ үзүүлэх, өөрийн нутаг дэвсгэрт хэрэглэх, бусад орны нутаг дэвсгэрт "худалдааны оролцоо"-той байх замаар үйлчилгээ үзүүлэх, гадаад орны нутаг дэвсгэрт оршин суух замаар хувь этгээдээс үзүүлэх үйлчилгээ гэж ялган тодорхойлсон. Гэвч үйлчилгээ гэдэг нэр томъёог онож тодорхойлох нь амаргүй асуудал юм. Хэрэв бараа материаллаг хэлбэртэй, биет нэгж (ширхэг, метр, килограмм г.м)-ээр хэмжигддэг бол үйлчилгээний хувьд эдгээр шалгуурыг хэрэглэх боломжгүй. "Үйлчилгээ нь үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүн болох тодорхой үйлдэл бөгөөд түүний үр дүн нь үйлчлүүлэгчийн тодорхой хэрэгцээг хангасан байвал зохино" гэж тодорхойлсон байна. Үүнээс үзэхэд үйлчилгээг үйлдвэрлэлээс салгаж болохгүй нь ойлгомжтой. Арга зүйн тийм хандлага нь үйлчилгээний ангиллыг тодорхойлох үндэслэл болсон бөгөөд хэрэг дээрээ үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны нэр төрлийн ангилал гэж үзэж болох юм. Учир нь үйлчилгээг тоо хэмжээний аливаа нэгжээр илэрхийлэх (үнийн дүнгээс өөр), тоон үзүүлэлтээр үнэлэхэд ихээхэн хүндрэл гарна. Ийм хүндрэлтэй асуудлууд нь хэлэлцээрийн үр дүн, хэлэлцээрийн бүтэц, заалтад ихээхэн нөлөөлөх учир аль болох дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай болж байгаа юм. Хэлэлцээрт оролцогчид өөр хоорондоо хэрэглэж байгаа болон харилцан буулт хийх жагсаалтад тусгагдсан үйлчилгээний нэр төрлийг үндэслэн 12 төрлийн салбарт, 160 нэрийн үйлчилгээг ангилан тогтоосон. НҮБ-

ын хүрээнд боловсруулсан бүтээгдэхүүний нэгдсэн ангиллын үндсэн дээр ТХЕХ-ийн нарийн бичгийн дарга нарын газраас бэлдсэн ангиллыг ҮХЕХ-ийн зорилгоор ашиглаж болно гэсэн үг юм.

Энэхүү ангилал бүхий дэлгэрэнгүй жагсаалтыг бүлэгчлэн авч үзвэл⁸:

1. Ажил хэргийн үйлчилгээ-46 нэр төрлийн үйлчилгээ;
2. Харилцаа холбооны үйлчилгээ-26 нэр төрөл;
3. Барилга байгууламж, инженерийн үйлчилгээ-5 нэр төрөл;
4. Төлөөллийн үйлчилгээ-3 нэр төрөл;
5. Ерөнхий боловсролын үйлчилгээ-5 нэр төрөл;
6. Хүрээлэн байгаа орчныг хамгаалахтай холбогдсон үйлчилгээ-4 нэр төрөл;
7. Санхүү, даатгалын үйлчилгээ-17 нэр төрөл;
8. Эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээ-4 нэр төрөл;
9. Аялал жуулчлал-4 нэр төрөл;
10. Чийрэгжүүлэх, соёл, спортын зохион байгуулах үйлчилгээ - 5 нэр төрөл;
11. Тээврийн үйлчилгээ-32 нэр төрөл;
12. Бусад үйлчилгээ гэх мэт болно.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ ХЭЛЭЦЭЭР БА МОНГОЛ УЛС

Монгол Улс Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр (1947 оны)-т нэгдэн орох өргөдлөө 1991 оны 6 дугаар сард гаргасан бөгөөд Монгол Улсын нэгдэн орох асуудлаарх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаад 1995 оны 1 дүгээр сард дээрх ажлын хэсгийг Дэлхийн худалдааны байгуулагад нэгдэн орох ажлын хэсэг болгон өөрчилсөн. Уг ажлын хэсэг Монгол Улс Дэлхийн Худалдааны Байгууллагыг үүсгэн байгуулах хэлэлцээрт нэгдэн орж болох тухай дүгнэлтэд хүрсэн⁹. Улмаар 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хурал соёрхон баталсан.

1997 оны 1 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн Дэлхийн худалдааны байгууллагын бүрэн эрхт гишүүн болсон байдаг.

Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын бүрэн эрхт гишүүн болсноор эдийн засаг, худалдаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай нөхцөл бүрдэж байгаа юм. Тухайлбал:

- Худалдааны харилцаанд нэн таатай нөхцөл болон үндэсний дэглэмийг бусдаас олж авах бололцоо нээгдсэн;

- Манай экспортын бараа гадаад орнуудын зах зээлд тарифын

⁸ Сэсээр Г. Дэлхийн худалдааны байгууллагын эрт эдийн засгийн асуудал Уб: 2000 он, 115 дэх тал.

⁹ Дэлхийн худалдааны байгууллага дахь Монгол Улс 2003 он.

илүү хөнгөлөлттэй нөхцөлөөр холбогдох бололцоотой болсон;

• Шууд хөрөнгө оруулалтыг оруулахад дөхөмтэй болсон. Худалдааны маргааныг Дэлхийн худалдааны байгууллагын маргаан таслах хороогоор шийдвэрлүүлж байх эрх зүйн бололцоо гарч байгаа нь арбитраар маргааныг шийдвэрлүүлэхэд шаардагдах их хэмжээний зардлаас чөлөөлөгдөх ач холбогдолтой юм.

Монгол Улс Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт заасан ерөнхий үүргээс гадна тусгай үүрэг, амлалтуудыг авсан байдаг. Эдгээр нь банк, санхүүгийн үйлчилгээ, бизнесийн үйлчилгээ, даатгал, холбоо харилцаа, түтээн тараал болоод аялал жуулчлалтай холбоотой тусгай үүргүүд бөгөөд Монгол Улс энэхүү жагсаалтад орсон үйлчилгээний салбаруудаар гадаад орны үйлчилгээ олгогчдод үндэсний нөхцөл эдлүүлэх, зах зээлийг нээлттэй болгох, үйлчилгээний худалдаанд нэн тааламжтай нөхцөлийг харилцан олгох олон улсын худалдааны дэг журамд хамруулахаар заасан байдаг. Энэ хүрээнд Монгол Улсын энэ салбар дахь харилцааг зохицуулж буй хуулиудыг авч үзвэл:

1. Мэргэжлийн үйлчилгээний хүрээнд:
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2001);
 - Аудитын тухай хууль (1997);
 - Компанийн тухай хууль (1999);
 - Банкны тухай хууль (1996) гэх мэт.
2. Банк болоод санхүүгийн үйлчилгээний хүрээнд:
 - Иргэний хууль (2001);
 - Төв банк (Монгол банк)-ны тухай хууль (1996);
 - Банкны тухай (1996);
 - Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль (1993);
 - Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (1995).
3. Даатгал, давхар даатгал болон тээврийн үйлчилгээний хүрээнд:
 - Даатгалын тухай хууль (2004).
4. Харилцаа холбооны үйлчилгээний хүрээнд:
 - Иргэний хууль (2001);
 - Харилцаа холбооны тухай хууль (2001);
 - Шуудангийн тухай хууль (2003);
 - Радио долгионы тухай хууль (1999).
5. Аялал жуулчлалын үйлчилгээний хүрээнд:
 - Иргэний хууль (2001);
 - Аялал жуулчлалын тухай хууль (2000);
 - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994).

6. Тээвэрлэлтийн үйлчилгээний хүрээнд:
 - Авто тээврийн тухай хууль (1995);
 - Усан замын тээврийн тухай хууль (2003);
 - Иргэний нисэхийн тухай хууль (1999).
7. Зар сурталчилгааны үйлчилгээний хүрээнд:
 - Зар сурталчилгааны тухай хууль (2002).
8. Санхүүгийн түрээс:
 - Иргэний хууль (2001);
 - Санхүүгийн түрээсийн тухай (2006).

Эдгээр хуулийн зохицуулалтаас харахад ДХБ-ын өмнө авсан үүрэг, амлалтын дагуу гадаадын аливаа үйлчилгээний худалдаа эрхлэгчдэд дотоодын үйлчилгээ эрхлэгчдэд үзүүлдэгийн адил буюу ямар нэгэн хязгаарлалтгүй үйл ажиллагаа явуулж болох боломжоор хангасан байдаг. Энэхүү үүрэг амлалттай зөрчилдсөн зарим нэг хууль тогтоомж байна. Жишээлбэл, аялал жуулчлалын салбарын тухайд үзэхэд энд тусгай үүрэг амлалт авахдаа хил дамнасан нийлүүлэлт, хилийн чанад дахь хэрэглээ, арилжааны оролцоо зэрэгт зах зээлд нэвтрэх хийгээд үндэсний нөхцөлийн тухайд ямар нэгэн хязгаарлалт тогтоохгүй байхаар үүрэг амлалт авсан¹⁰ байна. Гэсэн ч хуульд "тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хорилоно"¹¹ гэж заажээ. Энэхүү хориглолт нь гадаадын хуулийн этгээд болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хувьд хамаарагдаад 100 хувь Монголын хуулийн этгээдийн хувьд хамаарахгүй байхаар заасан байна. Энэ нь Монгол Улс гадаадын хуулийн этгээдэд хязгаарлалт тогтоохгүй байхаар үүрэг, амлалт авсантай нь зөрчилдөж байна гэсэн үг юм. Энэ мэтчилэн хууль, эрх зүйн зохицуулалт болоод олон улсын гэрээг уялдуулах асуудал Монгол Улсын хувьд чухал асуудлуудын нэг юм.

Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орсноор Монгол Улс хөгжиж буй, шилжилтийн эдийн засагтай орнуудад олгодог аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтийг ухаалгаар, бүрэн эдэлж, өөрийн орны эрх ашигтай холбоотой асуудлаар олон улсын эрх зүйн хамгаалалтад орж, том, жижиг, хөгжилтэй, хөгжингүй аливаа улс орнуудтай эрх тэгш харилцах, бодлогоо чөлөөтэй хэрэгжүүлэх өргөн боломжийг олж байгаа бөгөөд энэхүү боломжоо ашиглахын сацуу эрх зүйн зохицуулалтаа боловсронгуй болгож, үүрэг амлалтаа мөрдөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

○○○○○

○○○○○

○○○○○

¹⁰ Үйлчилгээний тухай тусгай үүрэг амлалтын жагсаалт 9 дэх тал.

¹¹ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль 33дугаар зүйс, 33.2.

Гэрээнээс татгалзах болон гэрээ цуцлах тухай Иргэний хуулийн зохицуулалтыг шүүхийн практикт хэрэглэх асуудал

Монголын Өмгөөлөгчдийн холбооны
 гишүүн, өмгөөлөгч, докторант Л.Банзрагч



Монгол Улс 2002 онд шинэ Иргэний хуулийг батлан, мөрдөж эхэлснээс хойш даруй арван жил болж байна. Энэ нь хуулийн алдаа, оноог дэнслэн эргэн харж болохуйц хугацаа төдийгүй мөн хуульчдын хууль хэрэглэх ур чадвар, хуулийг нэг мөр ойлгох хангалттай хугацаа гэж үзэж болно. Гэвч иргэний эрх зүйн зарим ойлголт, эрх зүйн зохицуулалтыг онол, арга зүйн хүрээнд зөв хэрэглэхгүй явдал байсаар байна. Үүний нэг нь гэрээнээс татгалзах болон гэрээг цуцлах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэглээний асуудал юм.

Монгол Улсын Иргэний хуульд гэрээнээс татгалзах болон гэрээг цуцлах замаар гэрээний үүргийг дуусгавар болгож болохоор зохицуулсан байдаг. Гэрээнээс татгалзах болон гэрээг цуцлах нь эрх зүйн үр дагавраараа ялгаатай. Гэрээний талууд гэрээний эрх зүйн харилцааны дүнд үүссэн үр дагаврыг гэрээ байгуулагдахаас өмнөх байдалд буцаан оруулах замаар гэрээг дуусгавар болгохыг гэрээнээс татгалзах гэнэ. Гэрээнээс татгалзсан тохиолдолд гэрээ нь бүхэлдээ харилцан буцаах үүргийн харилцаа болдог.¹Татгалзлаар гэрээний үүргийг дуусгавар болгосон тохиолдолд талууд гэрээний гүйцэтгэлийг биет байдлаар нь түүнчлэн гэрээ биелснээс олсон ашгийг харилцан буцааж өгөх үүрэгтэй бөгөөд мөн хуульд заасан тодорхой тохиолдолд мөнгөөр нөхөн төлж болдог. Харин гэрээг цуцлах гэдэг нь онолын үүднээс үүргийн харилцааг

¹ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги) У6: 2006 он, 768 дахь тал.

зөвхөн ирээдүйд үгүй болгоход чиглэсэн эрх байдаг.² Тиймээс гэрээг цуцлах хэмээх ойлголтыг зөвхөн урт хугацааны гэрээний харилцаанд хэрэглэх нь тохиромжтой. Гэрээнээс татгалзах болон гэрээг цуцлах үндэслэл нь гэрээнд заасны дагуу, гэрээнд заагаагүй бол хуульд заасны дагуу бий болно.

ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Гэрээнээс татгалзах асуудлыг Иргэний хуульд хангалттай зохицуулсан байдаг. Иргэний хуулийн 204 дүгээр зүйл нь гэрээнд зааснаар гэрээнээс татгалзах тохиолдолд хэрэглэх журам юм. Хуульд зааснаар гэрээнээс татгалзах эрх зүйн үндэслэлийг Иргэний хуулийн 225 дугаар зүйлд заасан байгаа. Хууль болон гэрээнд зааснаар татгалзсанаас үүсэх үр дагаврыг Иргэний хуулийн 205 дугаар зүйлд, гэрээнээс татгалзсанаас үүсэх учирсан хохиролыг Иргэний хуулийн 227 дугаар зүйлээр тус тус зохицуулсан. Монгол Улсын Иргэний хуулийн Ерөнхий ангид гэрээнээс татгалзах үндэслэл, журмыг харьцангуй логик уялдаа холбоотой зохицуулж өгсөн хэдий ч гэрээг цуцлах үндэслэл, журам нь тодорхойгүй байна. Иргэний хуулийн 221 дүгээр зүйлд гэрээнээс татгалзах болон гэрээг цуцлах ойлголтыг ялгаагүй нэгд ойлголт гэж харагдахаар заажээ. Иргэний хуулийн 221 дүгээр зүйлийг гэрээг цуцлах эсвэл гэрээнээс татгалзах зохицуулалт гэж шууд дүгнэх боломжгүй байна. Учир нь урт хугацаатай гэрээнд хэрэглэхээр зохицуулсан нь гэрээг цуцлах зохицуулалт гэж ойлгогдохоор байгаа боловч гэрээнээс татгалзсанаас үүсэх үр дагавар болох ИХ-ийн 205 дугаар зүйлийг хэрэглэж байгаа нь гэрээнээс татгалзах зохицуулалт болохоор харагдаж байна. Харин Иргэний хуулийн Тусгай ангийн хүрээнд эдгээр ойлголтыг харьцангуй ялгаатай байдлаар зохицуулсан. Гэхдээ ИХ-ийн &254.1,256.1-д эд хөрөнгийн доголдолтой холбогдуулж гэрээг цуцлалтаар дуусгавар болгож болохоор зааж өгчээ. Хуулийн дээрх зүйлүүд нь цуцлалт биш, харин татгалзал байсан бол илүү практик ач холбогдолтой болох байсан. Учир нь гэрээний зүйлийн доголдолтой холбогдуулж гэрээний үүргийг дуусгавар болгож байгаа тохиолдолд худалдан авагч татгалзлаар дуусгавар болгож ИХ-ийн &205.1-д заасан үр дагаврыг бий болгохыг хүсдэг. Өөрөөр хэлбэл худалдах, худалдан авах гэрээний зүйл доголдолтой бол ихэвчлэн доголдлыг арилгуулах буюу эсхүл гэрээний доголдолтой зүйлийг буцаан өгч, мөнгөө авах хүсэлтэй байдаг. Иймээс ИХ-ийн &254, 256 дугаар зүйл нь гэрээнээс татгалзах зохицуулалт байх байжээ.

² Бүлэгшлэл.Б Иргэний эрх зүйн тусгай анги №6: 2010 он, 64 дэх тал.

ШҮҮХИЙН ПРАКТИК, АРГА ЗҮЙ

Шүүхийн практикт эдгээр эрх зүйн зохицуулалтыг нэг мөр, зөв ойлгон хэрэглэхгүй байна. Энэ нь нэг талаас Иргэний хуулийн Ерөнхий ангид гэрээнээс татгалзах үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулсан боловч гэрээг цуцлах үндэслэл, журам ялангуяа гэрээг цуцалснаас үүсэх үр дагаврыг төдийлөн тодорхой зохицуулаагүй орхигдуулсан, нөгөө талаас тодорхой төрлийн гэрээний хүрээнд эдгээр ойлголтыг ялгаагүй байдлаар тусгасан нь дээрх нөхцөлийг бүрдүүлсэн байж болох юм. Гэхдээ шүүх байгууллага нь хуулийг зөв хэрэглэх практик тогтоож хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй¹ ажилладаг гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хууль хэрэглэх гэдэг нь эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах буюу тэдгээрийн хийдэл ба тодорхой бус байдлыг арилгах талаар бүрэлдэн тогтсон шүүх буюу бусад хууль хэрэглэгчийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүйн учир холбогдол бүхий зан үйл юм.² Шүүх шийдвэр гаргахдаа тухайн шийдвэрийн үндэслэлийг заавал тайлбарладаг гэдэг утгаараа шүүхийн шийдвэр эрх зүйн хэм хэмжээний тайлбар болж, эрх зүйн шинжлэх ухааны ойлголтыг өргөжүүлдэг. Ийм учраас шүүх иргэний эрх зүйн шинжлэх ухааны тогтсон ойлголтыг эвдэх, шинжлэх ухаанч бус тайлбар хийхгүй байх үүрэгтэй субьект юм.

Шүүхийн практикт гэрээнээс татгалзах болон гэрээг цуцлах ойлголтыг нэг ойлголтын хүрээнд үзэж байгаа төдийгүй, гэрээнээс татгалзах эрх зүйн зохицуулалтыг арга зүйн хувьд буруу хэрэглэх байдал байсаар байна. Үүнд:

1. Иргэний хуулийн 254 дүгээр зүйлийн 254.1, 256 дугаар зүйлийн 256.1 дэх хэсгийг хүчээр гэрээнээс татгалзах гэж ойлгон хэрэглэж байна. Тодруулбал, ИХ-ийн & 254.1, 256.1-д зааснаар гэрээг цуцалсан атлаа гэрээнээс татгалзсанаас үүсэх үр дагаврын эрх зүйн зохицуулалт болох 205 дугаар зүйлийн 205.1 дэх хэсгийг хэрэглэж байна³. Өөрөөр хэлбэл,

ИХ&254.1 ИХ& 256.1 ИХ&205.1 дараалалтай хэрэглэж байна.

Иргэний хуулийг хэрэглэж тодорхой асуудлыг шийдвэрлэхдээ “тусгайлан зохицуулалтаас ерөнхий зохицуулалт” гэсэн зарчим баримталадэг. Өөрөөр хэлбэл тусгай ангийн болон тусгайлан зохицуулалт тухайн асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол ерөнхий ангийн болон бусад ерөнхий зохицуулалтыг хэрэглэдэг. Иймээс тусгай ангийн эрх зүйн

¹ Баярсайхан Д. Эрх зүйн онол Уб: 2010 он, 210 дэх тал.

² Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг Уб: 2011 он, 570 дэх тал.

³ Шүүхийн шийдвэрийн эмгэгтэй цураг-2 (Иргэний хэрг) Уб: 2006 он, 10 дэх тал.

зохицуулалтад ИХ-ийн &254.1, 256.1-д гэрээнээс татгалзах боломж олгоогүй, зөвхөн цуцлах зохицуулалт байгаа тул түүнийг хүчээр татгалзах гэж ойлгон хэрэглэхгүйгээр ерөнхий ангийн зохицуулалтыг хэрэглэх нь зүйд нийцнэ.

ИХ-ийн &254.1, 256.1-д гэрээг цуцлахаар заасныг техникийн алдаа гэж ойлгохоор байдаг хэдий ч, хуулийг хэрэглэхэд тухайн заалтын үг, үсэг, цэг, таслал чухал ач холбогдолтой тул дээрх зүйлийг хүчээр татгалзал болгон хэрэглэх боломжгүй юм.

2. Гэрээнээс татгалзах эрх зүйн үндэслэлийг, өөрөөр хэлбэл гэрээнд заасан үндэслэл эсвэл хуульд заасан үндэслэл болох Иргэний хуулийн 225 дугаар зүйл, 226 дугаар зүйлийг шалган тогтоолгүй, Иргэний хуулийн логик уялдаа холбоог нь анхаарахгүйгээр шууд Иргэний хуулийн 205 дугаар зүйлийн 205.1 дэх хэсгийг хэрэглэх тохиолдол түгээмэл байна⁶.

Иргэний хуулийн ерөнхий ангийн гэрээнээс татгалзах зохицуулалт нь логик дэс дараалалтай хэрэглэхээр зохицуулагдсан байдаг. Гэрээнээс татгалзах ерөнхий ангийн зохицуулалтыг хэрэглэхдээ Иргэний хуулийн 225, 226 дугаар зүйлийг юуны өмнө шалгах хэрэгтэй. ИХ-ийн &225-г хэрэглэх анхдагч урьдчилсан нөхцөл нь тухайн гэрээ хоёр талын гэрээ байх, гэрээний нэг тал нь үүргээ зөрчсөн байх, уг үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож өгсөн байх, эсхүл нэмэлт хугацаа тогтоож өгөх шаардлагагүй үндэслэл бий болсон эсэх (ИХ-ийн&226) зэрэг нөхцөл юм. ИХ-ийн &225.1-н дагуу гэрээнээс татгалзах эрх байгаа гэдгийг тогтоосон тохиолдолд ИХ-ийн &205 дугаар зүйлээр үр дагаврыг нь тооцож, гэрээнээс татгалзсантай холбоотойгоор үүссэн хохирол бий болсон буюу улмаар түүнийг нэхэмжилсэн бол ИХ&227 дугаар зүйлээр гэрээнээс татгалзсантай холбоотой учирсан хохирлын асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм. Гэрээнээс татгалзах зохицуулалтыг хэрэглэх логик дараалал

ИХ&225 ИХ& 226 ИХ&205 ИХ&227

Үүний өмнө мэдээж гэрээ байгуулагдсан эсэх, гэрээг үгүйсгэх үндэслэл байгаа эсэх болон бусад асуудлыг шалгах нь тодорхой юм.

3. Худалдах, худалдан авах гэрээгээр худалдагч тал гэрээний зүйлийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх боломжгүй бодит нөхцөл байдал үүссэн тохиолдолд худалдан авагч гэрээний хариу төлбөр болгон шилжүүлсэн мөнгийг буцаан шаардсан шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэхдээ шүүх нэхэмжлэлийн шаардлагыг

⁶ www.zhirnecourt.mn, 2009.12.22-ны өдрийн 5/ДШ-ийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хураллаан 01 дүгээр тогтоол.

хангаж шийдвэрлэсэн байдаг боловч энд гэрээнээс татгалзах эрх зүйн зохицуулалтыг үндэслэхгүй, харин ИХ-ийн &243.1-г үндэслэсэн тохиолдол ч байна.⁷

Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсэг нь худалдах, худалдан авах гэрээний агуулга, талуудын үндсэн үүргийг тодорхойлж өгсөн зохицуулалт болохоос бус гэрээнээс татгалзах эрх зүйн зохицуулалт биш. Хэрэв хуульд зааснаар гэрээнээс татгалзаж байгаа бол ИХ-ийн &243.1-ээс гадна ИХ-ийн &225, ИХ-ийн &205 дугаар зүйлүүд болон хуулийн бусад заалтыг үндэслэх нь зүйтэй байсан.

ИХ&243.1 ИХ&225 ИХ&226 ИХ&205 ИХ&227

4. Орон сууц хөлслөх гэрээг цуцлан, орон сууцыг чөлөөлүүлэхдээ, мөн түүнчлэн түрээсийн гэрээг цуцлан, түрээсийн гэрээний зүйлийг буцаан олгох агуулга бүхий шийдвэр гаргахдаа Иргэний хуулийн 205 дугаар зүйлийн 205.1 дэх хэсгийг баримталж байна.⁸ Тухайлбал, нэхэмжлэгчийн "хөлслөгч хөлсөө төлөхгүй байгаа тул орон сууц хөлслөх гэрээг цуцалж өгнө үү" гэх шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэргийг шүүх гэрээг цуцлан, орон сууцыг чөлөөлүүлэх шийдвэр гаргахдаа Иргэний хуулийн 294 дүгээр зүйлийн 294.2.1-т зааснаар гэрээг цуцлан, улмаар 205 дугаар зүйлийн 205.1-ийг баримтлан чөлөөлүүлж байна. Энд гэрээг цуцалсан атлаа, гэрээнээс татгалсанаас үүсэх үр дагаврын талаарх зохицуулалтыг баримталж байгаа нь мөн л гэрээнээс татгалзах болон гэрээг цуцлах зохицуулалтын ялгаатай шинжийг анхаарахгүй байгаагийн идрэл юм.

ИХ-ийн &294.2.1 ИХ-ийн &205.1 -гэж хэрэглэж байна.

Орон сууц болон түрээсийн гэрээ нь татгалзлаар бус, цуцалтаар дуусгавар болговол зохимжтой урт хугацааны гэрээнд хамаарадаг тул ИХ-ийн тусгай ангийн 294 дүгээр зүйл, ИХ-ийн & 304.1-т цуцалтаар дуусгавар болохоор зааж өгсөн байдаг. Эдгээр гэрээг цуцалсан тохиолдолд ИХ-ийн &205.1-ийг хэрэглэх боломжгүй юм. Учир нь ИХ-ийн &205.1 бол гэрээнээс татгалзсан тохиолдолд үүсэх үр дагаврыг зохицуулсан зохицуулалт юм. Гэрээг цуцлах нь үүргийн харилцааг зөвхөн ирээдүйд үгүй болгоход чиглэсэн эрх байдаг гэдгийг анхаарах хэрэгтэй.

⁷ www.sukhbaatar.court.gov.mn, 2011.04.06-ны өдрийн Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн шүүх хуралдааны 570 дугаар шийдвэр.

⁸ www.surtees.court.mn, 2010.01.14-ний өдрийн УДШ-ийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 64 дүгээр тогтоол, 2010.02.18-ны өдрийн УДШ-ийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 152 дугаар тогтоол.

**“Ардчилсан Үндсэн хууль 20 жил” эрдэм шинжилгээний хурал
болов**

Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ойд зориулсан “Ардчилсан Үндсэн хууль 20” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2012 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулжээ.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлыг УИХ-ын дэд дарга Г.Батхүү нээж үг хэлсэн байна. Тэрээр, Монгол Улсын ардчилсан өөрчлөлтийн эхэн үе буюу 1990-1992 онд төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлж байсан АИХ-ын депутатууд, УБХ-ын эрхэм гишүүд, эрдэмтэн, судлаачид, өргөн олон түмнийхээ идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр өв уламжлалынхаа шигшмэл арвин баялаг санг орчин үеийн, ардчилсан үнэт зүйлсийн сонгомол ололтуудтай хослуулан боловсруулж шинэ Үндсэн хуулийг баталж хэрэгжүүлж эхэлснээс хойш 20 жил болж байна гэдгийг онцлон тэмдэглэжээ.

Хуралд Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид “Шинэ, ардчилсан Үндсэн хууль бол Монголын ард түмний бүтээл мөн”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Ч.Өнөрбаяр “Үндсэн хуульд ёсны хөгжил, чиг хандлага”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Л.Өлзийсайхан “Үндсэн хуулийг дээдлэх ёс ба түүний дархлааг тогтоох нь”, Удирдлагын академийн захиргааны сургуулийн захирал, хууль зүйн шинжлэх ухааны доктор Ч.Энхбаатар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал: Үндсэн хуулийн зохицуулалт ба өнөөгийн практик” сэдэвт илтгэлүүдийг тус тус хэлэлцүүлсэн байна. Түүнчлэн тус хуралд Үндсэн хуулийн төслийг боловсруулсан эрдэмтэн, судлаачид, УБХ-ын гишүүд, хэлэлцэн баталсан АИХ-ын депутатууд, Үндсэн хуулийг хэрэгжүүлэх үйл хэрэгт биечлэн оролцож ирсэн, одоо ч оролцож буй үе үеийн төрийн түшээдийн төлөөлөгчид өргөнөөр оролцсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, хэрэгжилтийн үйл явц, үр дүн, цаашдын чиг хандлага, хөгжлийн асуудлаарх илтгэлүүд хэлэлцүүлсэн нь шинжлэх ухаан, практикийн болоод улс төрийн олон талын чухал ач холбогдолтой хурал болсоныг оролцогчид онцлон хэлсэн байна.

Энэхүү эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийнхээ энэ дугаарт нийтгэлснийг уншигч та болгоно уу.

С.А.тантуяа

○○○○○○ ○○○○○ ○○○○○

Б.Чимидийн нэрэмжит шилдэг илтгэлийн уралдаан боллоо

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг батласан өдрийг тохиолдуулан Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдааныг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. 2009

оноос улбаатай уралдааны 4 дэх удаагийнх 2012 оны нэгдүгээр сарын 12-нд буюу шинэ Үндсэн хуулийг батласны 20 жилийн ойн өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд боллоо.

Уг арга хэмжээг нээж Удирдлагын академийн захирал, академич Г.Чулуунбаатар, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, доктор, профессор Д.Солонго, УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин, Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал, академич Ж.Амарсанаа, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор Б.Гүнбилэг нар үг хэлж, Б.Чимид багш Тайландаас утсаар мэндчилгээ дэвшүүлж, нийт оролцогчид баяр хүргэн амжилт хүсч, шинжлэх ухаанд дурлаж байгаа оюутан, судлаачдад баярлаж буйгаа илэрхийлэв.



Урдаааны шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтан, судлаач, багш нарын ангилалд 25, оюутны ангилалд 30 бүтээл ирсэн бөгөөд багш, судлаачдаас "Отгонтэнгэр" их сургуулийн багш Р.Очирбал "Сонгуульд иргэд нийтээрээ оролцох зарчим ба хорих газар ял эдэлж байгаа хориглуудын сонгуулийн эрхийн асуудал", УИХ-ын Тамгын газрын Эрх зүй, хуулийн хэлтсийн ахлах зөвлөх Л.Өлзийсайхан "Үндсэн хууль бол хууль тогтоогчид зорицсан хууль мөн", УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн судлаач, референт П.Амаржаргал "Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, Япон Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийг Үндсэн хуулийн эрх зүйн үнднээс харьцуулах нь" сэдэвт илтгэлээрээ эхний гурван байр, Нийслэлийн прокуратурын газрын Ял эдлүүлэх ажлагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Мөнхбаа "Прокурорын хяналтын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал", Булган аймгийн сум дундын шүүхийн шүүгч Н.Нарангэрэл "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн оролцоог хангах нь" сэдвээр шагналт бийр эзэлсэн бол оюутнуудаас МУИС-ийн Хууль зүйн сургуулийн IV курсын оюутан Г.Давааням "Үндсэн хуулийн үзлийн Үндсэн

хуулийн хэрэгжилтэд тавих дээд хяналт ба Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолыг Үндсэн хуулийн цэц хянах асуудал”, мөн сургуулийн V курсын оюутан С.Жавхлан “Үндсэн хуулийн нэр томъёо болон түүнтэй холбоотой зарим асуудал”, мөн сургуулийн IV курсын оюутан Ж.Содномдаржаа “УИХ-ын гишүүд сонгуулийн тойрогтоо мөнгө хуваарилан авч зарцуулж байгаатай холбоотой эрх зүйн асуудал” сэдэвт илтгэлээрээ эхний гурван байр, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V курсын оюутан Д.Ренчиндорж “Үндсэн хуулийн зөрчлийг арилгахад Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн ач холбогдол”, мөн сургуулийн V курсын оюутан Б.Гантөмөр, М.Цэнд-Очир нар “Хууль тогтоох эрх мэдлийг Засгийн газарт шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдэвт илтгэлээрээ шагналт байр эзэллээ.



Уралдааныг УИХ-ын гишүүн, Нээлттэй академийн тэргүүн Х.Тэмүүжин, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд захирал, хууль зүйн шинжлэх ухааны доктор, проффессор Н.Лүндэндорж, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн доктор Г.Банзрагч, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрхлэгч Р.Мухийт нар шүүн явуулсан байна.

“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн энэ дугаарт тус эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдаанд тэргүүлсэн илтгэлүүдээс нийтэллээ.



**“Захиргааны эрх зүйн тусгай ангийн хөгжлийн чиг хандлага”
сэдэвт эрдэм шинжилгээний хурал боллоо**

Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимтэй хамтран “Захиргааны эрх зүйн тусгай ангийн хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2012

оны 1 дүгээр сарын 23-ны Даваа гаригт Хууль зүйн үндэсний хүрээлэнд зохион байгууллаа. Тус хурлыг нээж МУИС-ийн ХЗС-ийн захирал доктор, профессор Д.Солонго үг хэллээ.



Энэхүү эрдэм шинжилгээний хуралд хууль зүйн доктор П.Одгэрэл "Монгол Улсын захиргааны эрх зүйн ерөнхий, тусгай ангийн уялдаа холбоо: Татварын эрх зүйн жишээн дээр", хууль зүйн доктор Ш.Цогтоо "Захиргааны эрх зүйн тусгай ангийн өнөөгийн байдал", докторант Д.Ганзориг "Захиргааны эрх зүйн тусгай анги хичээлийн агуулгыг шинэчлэн тодорхойлох нь", хууль зүйн доктор Г.Банзрагч "Эдийн засгийн захиргааны эрх зүй нь Захиргааны эрх зүйн тусгай ангийн бүрэлдэхүүн хэсэг болох нь", хууль зүйн доктор А.Эрдэнэцогт "Захиргааны эрх зүйн тусгай ангийг хөгжүүлэх процессын эрх зүйн шаардлага", докторант Ж.Жавзандулам "Захиргааны эрх зүйн тусгай ангийн зарим салбар дахь захиргааны хариуцлагын асуудал", хууль зүйн доктор Д.Гангабаатар "Бэлчээрийн эрх зүйн зохицуулалт ба гадаад орнуудын туршлага", докторант С.Энхмэнд "Захиргааны эрх зүйн тусгай ангийн хүрээн дэх Газрын эрх зүйн зохицуулалтын онцлог" зэрэг сонирхолтой сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүллээ.

Тус эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийнхээ энэ дугаарт нийтэлснийг уншигч та болгооно уу.

С.Алтантуяа



**"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн
найруулгын төслийн агуулга, ач холбогдол" хэлэлцүүлэг амжилттай
зохион байгуулагдлаа**

Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хамтарсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга, ач холбогдол” сэдэвт хэлэлцүүлгийг Хууль зүйн үндэсний хүрээлэнд 2012 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа.

Эл хэлэлцүүлгийн зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хэрэгжүүлж буй иргэний, захиргааны болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан хуулийн төслийг хуулийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэлэлцэх зарчмаар нэмэлт санал авах байв.

Хэлэлцүүлэгт УИХ-ын ХЗБХ-ны төлөөлөл, МУ-ын Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн шүүх, Нийслэлийн прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, албаны удирдах албан тушаалтанууд оролцсон юм.

Түүнчлэн эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагууд ШУ-ны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, МУИС-ын Хууль зүйн сургууль, ДХИС-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Эрдэм шинжилгээний хүрээлэн, Отгонтэнгэр ИС, Шихихутаг ДС, Халх журам ДС, Их засаг ИС, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Монголын нотариатчдын танхим, Монгол банк, арилжааны банкуудын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөл, судлаачид хамтран санал солилцлоо.

Хэлэлцүүлгийн үеэр ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын хэлтсийн дарга, докторант, дэд хурандаа Ц.Очгэрэл “Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх нь”, ДХИС-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн ахлах багш, докторант, хошууч Б.Алтангэрэл “Хорих ангийн нээлттэй ба хаалттай дэглэмийн онцлог, ач холбогдол ба хуулийн нэр томьёо”, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтоолцоонд шилжүүлэх талаар бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт”, ШШГЕГ-ын ШГГ-ын дэд дарга, хурандаа Х.Энхбаатар “Иргэний болон захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” зэрэг илтгэлийг тус тус хэлэлцүүлсэн юм.

Энэхүү хэлэлцүүлгийн зорилт нь Хорих ял эдлүүлэх тогтолцоог хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцсэн, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой тогтолцоонд шилжүүлэх, иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх зэрэг үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн эрх зүйн шинэ зохицуулалттай болох хэмээн хэлэлцүүлгийг зохион байгуулагчид өгүүлж байв.

○○○○○ ○○○○○ ○○○○○



“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2012 оны захиалга - УЛС ДАЯАР

ХЗДХЯ-ны дэргэдэх Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэл хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийг 9 дэх жилдээ хэвлэн нийтийн захиалгаар түгээж байна.

Тус сэтгүүл нь шинэ ондоо буюу 2012 оноос гаралтын тоогоо өсгөж жилд зургаан дугаар гарч уншигчдынхаа мэлнийг мялаахаар боллоо.

Жилийн хоёр, дөрөв, зургаа, найм, арав, арванхоёрдугаар саруудад В5-ын хэмжээтэй 120-150 хэвлэмийн хуудастай хэвлэгдэн гарах юм.

Сэтгүүлийн зөвлөл УИХ, Засгийн газар, шүүх, прокурор, өмгөөлөл, нотариатын байгууллага болон МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрдэмтдийн төлөөлөл зэрэг өргөн бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг.

Тус сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэлд Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг тооцдог бөгөөд УИХ, Засгийн газар, ХЗДХЯ-ны харьяа бүх агентлаг, шүүх, прокурор, өмгөөлөл, нотариатын байгууллага болон хуулийн фирмүүд, хувийн компаниудад захиалгаар түгээдэг. Мөн Монгол шуудан компаниар дамжуулан хөдөө, орон нутгийн уншигчдад захиалгаар хүрдэг билээ.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн томоохон судалгааг тус сэтгүүлд нийтэлж уншигчиддаа хүргэхээс гадна гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачид, хуульчид бусад идэвхтэн бичигчидтэй хамтран ажилладаг.

“Хууль дээдлэх ёс” сэтгүүл нь хуульчид, эрдэмтэн, судлаачид, хуулийн их, дээд сургуулийн оюутнууд төдийгүй төрийн байгууллагын нийт албан хаагч, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд зориулагдсан юм.

“Хууль дээдлэх ёс” сэтгүүл нь жилд 6 дугаар, хагас жилд 3 дугаар гарна.

Жилийн захиалгын үнэ 18 000 төгрөг

Хагас жилийн захиалгын үнэ 9000 төгрөг

Захиалгын индекс

№	Монгол шуудан	Улаанбаатар шуудан	Түгээмэл шуурхай шуудан	Sky post
“Хууль дээдлэх ёс” сэтгүүл	200279	2001065	111054	200279

Хууль зүйн үндэсний хүрээлэн
байгуулагдсаны 10 жилийн ойн
төнд дэвшуурье.

